МҮХАҮТ-ын дэргэдэх
Монголын Олон Улсын Арбитр

# ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫН ЭМХЭТГЭЛ

2020 он

Эрхлэн хэвлүүлсэн: МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр

Хянасан: С.Энхцэцэг
М.Шинэбаяр

Эмхэтгэсэн: Б.Хатантуул

Хэвлэлд бэлтгэсэн: Б.Хатантуул
Э.Номинсогоо
О.Эрдэнэдалай

Дизайн: О.Гомбо-Эрдэнэ

Гэрээний загварын эмхэтгэл

Өмнөх үг

Иргэн, хуулийн этгээдүүд бизнесийн эрх зүйн харилцаанд оролцох явцад хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдлэх боломж бүрдсэн байх нь бие биедээ итгэх итгэлийг нэмэгдүүлж, хамтын ажиллагааны тогтвортой байдал хангагдах суурь болдог. Өнөөдөр иргэд хоорондын бизнесийн харилцаа өргөжин тэлж эдийн засгийн эргэлтийн урсгалыг нэмэгдүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч үүний зэрэгцээ эрх зүйн харилцаанд талуудын эрх тэгш байдал хангагдаж байх явдал нь бизнесийн ёс зүйн нэн тэргүүний асуудал мөн.

Гэрээний эрх зүйн харилцааны шинжээр нь долоон төрөлд ангилан, харилцагч талуудын эрх ашгийг харилцан тэнцвэртэй тусгаж, хуульд заасан хэлбэр шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн бизнесийн харилцаанд түгээмэл хэрэглэгддэг 48 гэрээний загвар бүхий эмхэтгэлийг иргэдийн эрх зүйн харилцааг соёлжуулж, тогтвортой хамтын ажиллагааг бий болгоход тус болно хэмээн итгэж эмхэтгэн бүтээв.

Гэрээний эрх зүйг сонирхон судалдаг оюутан судлаач болон завгүй бизнес эрхлэгчдийн ажил үйл хэрэгт өдөр тутмын чухал хэрэглэгдэхүүн болно гэдэгт итгэж байна.

МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраас анхлан хэвлүүлж буй гэрээний эмхэтгэлийг бизнес эрхлэгч, оюутан судлаачдын гарт хүргэх ажилд бодитой туслалцаа үзүүлсэн “Европын холбооны Монголын худалдааг дэмжих төсөл ТРАМ”-д гүн талархал илэрхийлье.

Амжилт дагуулсан хэлэлцээр бүтээж, ажил үйлс тань өргөжин дэлгэрэхийг хүсье.

Арбитрын дарга С.Энхцэцэг

## АГУУЛГА:

*ӨМНӨХ ҮГ*.......................................................................................................3

*АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ*.....................................................................................6

Ажил гүйцэтгэх гэрээ .............................................................................................7

Барилгад засварын ажил хийх гэрээ ......................................................................16

Барилгын ажил гүйцэтгэх гэрээ ............................................................................19

Өрөмдлөгийн гэрээ.................................................................................................23

Хөдөлмөрийн гэрээ ...............................................................................................29

Хөлсөөр ажиллуулах гэрээ ....................................................................................36

*БУСДЫН ӨМЧЛӨЛД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ* ...........................................40

Бараа арилжих тухай гэрээ....................................................................................41

Бараа бөөнөөр худалдах, худалдан авах гэрээ.......................................................49

Бэлэглэлийн гэрээ ...................................................................................................54

Гадаадын тоног төхөөрөмж худалдан авах гэрээ ...................................................56

Ноу-хау худалдах, худалдан авах гэрээ...................................................................61

Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг .....................................................................65

Худалдах, худалдан авах гэрээ.................................................................................65

Тээврийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ...................................................68

Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ .............................................71

Үнэт цаас, хувьцаа худалдах, худалдан авах гэрээ...................................................76

Худалдах худалдан авах гэрээ ..................................................................................79

*БУСДЫН ЭЗЭМШИЛ АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ*..............................86

Ажлын байр түрээслэх гэрээ......................................................................................87

Тоног төхөөрөмж түрээслэх тухай гэрээ.....................................................................91

Түрээсийн гэрээ..........................................................................................................96

Худалдааны байранд талбай түрээслэх, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ.....................100

*МӨНГӨ ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ*.....................................................................105

Барьцаат зээлийн гэрээ ..............................................................................................106

Валют худалдах, худалдан авах гэрээ .........................................................................109

Зээлийн гэрээ .............................................................................................................112

Зээлийн баталгаа гаргах гэрээ....................................................................................114

Санхүүгийн түрээсийн гэрээ.........................................................................................118

*ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ* ........ 124
Агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ ........ 125
Ачаа тээвэрлэлтийн гэрээ ........ 130
Гадаад худалдааны тээвэр-экспедиторын ........ 133
Үйлчилгээ үзүүлэх гэрээ. ........ 133
Даатгалын гэрээ ........ 143
Олон улсын хэмжээнд ачаа тээврийн шуурхай мэдээллээр хангах тухай гэрээ ........ 147
Үйлчилгээ үзүүлэх гэрээ ........ 151

*ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ* ........ 155
Агентын гэрээ ........ 156
Барааг зуучлалын байгууллагаар дамжуулан ........ 160
Бэлтгэн нийлүүлэх гэрээ ........ 160
Бүтээгдэхүүнийг удаан хугацаанд аж ахуйн ........ 164
Харилцааны дагуу бэлтгэн нийлүүлэх тухай гэрээ ........ 164
Бэлтгэн нийлүүлэх гэрээ ........ 170
Бэлтгэн нийлүүлэх материал, түүхий эдийг ........ 179
Дахин боловсруулах тухай гэрээ ........ 179
Гадаадаас хүнсний бараа худалдан авах гэрээ ........ 183
Гадаадад бараа бэлтгэн нийлүүлэх гэрээ ........ 191
Дистрибьютерийн гэрээ ........ 195
Франчайзийн /бүтээл ашиглах, зөвшөөрөл/ гэрээ ........ 203
Хамтран ажиллах гэрээ ........ 209

*БУСАД ТӨРЛИЙН ГЭРЭЭ* ........ 213
Бизнесийн мэдээллийн нууцыг хадгалах тухай гэрээ ........ 214
Компанийн эрх шилжүүлэх тухай гэрээ ........ 219
Хамтарсан компани байгуулах тухай гэрээ ........ 222
Эвлэрлийн гэрээ ........ 232

***АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ***

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас _______________________________________________________

*(захиалагч байгууллага, иргэний нэр, хаяг)*

_____________________________________________________________________

(цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж ______________________________

*(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)*

Нөгөө талаас _______________________________________________________

*(ажил гүйцэтгэгч байгууллага, иргэний нэр, хаяг)*

(цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлөн ___________________________

*(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)*

нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн батлагдсан зааварчилгаа, техникийн даалгаврын дагуу түүний материалаар (эсвэл өөрийн материалаар)___________________________________________________ ________________ ажлыг гүйцэтгэх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Гэрээний хугацаа: Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж ажлыг эцсийн байдлаар хүлээн авсан актад Захиалагч гарын үсэг зурж, Гүйцэтгэгчийн ажлын үлдэгдэл хөлсийг төлснөөр дуусгавар болно.

2.2 Ажил гүйцэтгэх хугацаа: Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2.1 Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа _____________

2.2.2 Ажил эхлэх хугацаа _________________________

2.2.3 Ажил дуусах хугацаа ________________________

### ГУРАВ. ТӨЛБӨР, ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

3.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс _____________ төгрөг байна. Үнийн дүнд НӨАТ болон бусад холбогдох хураамж, зардлууд орсон болно.

3.2 Ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгөх үед хөлсийг төлнө. (Хэрэв ажлыг тодорхой хэсгээр, үе шаттай гүйцэтгэхээр тохиролцсон бол тухайн хэсгийн ажлын үр дүнгээр хөлсийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцож болно.)

## ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ажлыг эхлэхэд шаардлагатай заавар, зааварчилгаа, батлагдсан техникийн даалгаврыг ажил эхлэхээс __ хоногийн өмнө бэлэн болгон Гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт нарийвчилсан тайлбарыг Гүйцэтгэгчид өгч болно.

4.2 Захиалагч нь гэрээний 3 дугаар зүйлд заасан журмын дагуу Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт, бусад мэдээлэл, тоног төхөөрөмжийг ажил гүйцэтгэгчийн эзэмшилд шилжүүлнэ.

4.3 Захиалагч тал нь анх батлагдсан техникийн даалгавар, заавар дээр нэмэлт хүсэлт гарган ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд холбогдох хөлсийг төлөх үүрэгтэй.

4.4 Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

4.5 Ажлын гүйцэтгэлийг тухай бүрт хянах, ажлын явцтай танилцах, ажлын явцын талаар мэдээлэл авах, өөрийн саналаа оруулах, ажил дууссаны дараа ажлын акт, гүйцэтгэлээр хүлээн авах бөгөөд захиалгыг зөрчиж буруу, дутуу, чанар, стандарт, техникийн шаардлага хангаагүй ажлыг тогтоосон хугацаанд засах, гүйцээн хийхийг шаардах, уг шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ.

4.6 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авахаас болон ажлын хөлс төлөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

4.6.1 Гүйцэтгэгч удаа дараа буюу хоёроос дээш удаа ажлыг чанарын шаардлага хангахгүйгээр гүйцэтгэсэн;

4.6.2 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь доголдолтой, захиалагчийн шаардлагад нийцээгүй

4.7 Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш __________ сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.8 Хууль, тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.1 Гүйцэтгэгч нь ажлыг Захиалагчийн өгсөн батлагдсан зааварчилгаа, техникийн шаардлага, нөхцөлийн дагуу мэргэжлийн өндөр түвшинд тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5.2 Ажлын гүйцэтгэлийн явцад Захиалагчийн өгсөн төлөвлөгөө, зааварчилгаа, хяналт зэрэг нь хангалтгүй байна гэж үзвэл энэ талаар яаралтай арга хэмжээ авахыг Захиалагчаас шаардах эрхтэй.

5.3 Ажил гүйцэтгэх явцад байгаль, орчин, экологийг хамгаалах, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, галын болон бусад аюулгүйн ажиллагааны талаарх холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, заав症ыг чанд сахих үүрэг хүлээх ба ажил гүйцэтгэх бүрд өөрийн ажилчдад холбогдох зааварчилгааг өгч, хөдөлмөр хамгааллын хувцас, тоноглол, багаж хэрэгслийг шалган галын бусад аюулгүйн ажиллагааг хангасны үндсэн дээр ажлыг гүйцэтгэнэ.

5.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй байх бөгөөд ажлыг туршлагатай, чадварлаг инженер, мэргэжлийн ажилчдаас бүрдсэн багаар гүйцэтгүүлнэ.

5.5 Гүйцэтгэгч нь гэрээгээр заасан ажлыг гүйцэтгэх үүргийг хүлээнэ.

5.6 Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.

(*Гүйцэтгэгч нь ажлыг чанарын шаардлага хангасан өөрийн материал, техник хэрэгсэл, програм хангамжийг ашиглан хийж гүйцэтгэнэ.)*

5.7 Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.

5.8 Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд ажлыг хүлээлгэн өгөхөөс татгалзан, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.

5.8.1 Захиалагч энэхүү гэрээний 4.2 болон 4.4-т заасан үүргээ ноцтой зөрчсөн, уг зөрчлөөс шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон

5.8.2 Захиалагч нь гүйцэтгэгчийн энэ гэрээний 5.2 – т заасны дагуу гаргасан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй.

5.9 Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

5.10 Хууль, тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй

6.2 Ажлын гүйцэтгэлийн болон гэрээ дүгнэх үед Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл Гүйцэтгэгч доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэг хүлээнэ.

6.3 Доголдол гэдэгт Гүйцэтгэгч нь ажлыг батлагдсан заавар, техникийн даалгаврын дагуу гүйцэтгээгүйг ойлгоно.

6.4 Захиалагчийн буруутай үйл ажиллагаа шууд нөлөөлөөгүй нь батлагдсан тохиолдолд, Захиалагчийн тогтоосон хугацаанаас хоцорсон, ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс учирсан хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж, барагдуулах үүрэгтэй.

6.5 Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, Захиалагч төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд буруутай тал нь хугацаа хэтрүүлсэн хоног тутамд ______ хувийн алданги нөгөө талдаа төлнө.

6.6 Захиалагч нь энэхүү гэрээний 4.5-д заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд Гүйцэтгэгч нь захиалагчид гэрээний үнийн дүнгийн __ хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг төлөх үүрэг хүлээнэ.

6.7 Гүйцэтгэгч энэхүү гэрээний 5.7-д заасан үндэслэлээр гэрээг цуцлах тохиолдолд Захиалагч нь гүйцэтгэгчид гэрээний үнийн дүнгийн __ хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг төлөх үүрэг хүлээнэ.

6.8 Алданги торгууль төлсөн нь Талуудыг үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.9 Учирсан хохирол гэдэгт үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид гарахгүй байх байсан зарлагыг ойлгоно.

6.10 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.11 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэгтээ ямар ч тохиолдолд хүндэтгэлтэй хандах бөгөөд үндсэн болон дэд үүргээс үл хамааран аль нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан илүү зардал, нэмэлт төлбөрийг гэм буруутай тал хариуцна.

## ДОЛОО. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

7.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлөөлөгчид ажлын үр дүнг шалгуулан хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэнэ.

7.2 Ажил хүлээлгэн өгсөн актад гүйцэтгэсэн ажлын жагсаалт, холбогдох хөлсний дэлгэрэнгүй, ажлын шалгасан үр дүнг тусгана.

## НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.

8.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

8.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

8.4 Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## ЕС. НУУЦ ХАДГАЛАХ

9.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй байх, өөрийн болон бусад этгээдийн эрх ашгийн төлөө ашиглахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

9.2 Энэхүү гэрээний 9.1-р хэсэгт заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн төлнө.

## АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

10.1 Талуудын хооронд маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

11.1 Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болох ба нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

11.2 Санал хүлээн авсан тал хариугаа ажлын __ хоногийн дотор мэдэгдэх бөгөөд гэрээнд өөрчлөлт оруулах бол талууд хамтран бичгээр үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна. Энэхүү нэмэлт гэрээ нь гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

11.3 Гэрээний хавсралт, техникийн даалгавар, ажлын зааварчилгаа зэрэг нь гэрээний салшгүй хэсэг болно.

11.4 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

11.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

## АРВАН ХОЁР. ТАЛУУДЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ БАЙХ ҮЕИЙН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ, МЭДЭЭЛЭЛ

12.1. Захиалагч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

12.2. Гүйцэтгэгч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

12.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| --- | --- |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ______________________________________________________
*(захиалагч байгууллага, иргэний нэр, хаяг)*
_________________________________________________________________
(цаашид "Захиалагч" гэх) түүнийг төлөөлж _____________________________
*(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)*
Нөгөө талаас _____________________________________________________
*(ажил гүйцэтгэгч байгууллага, иргэний нэр, хаяг)*
(цаашид "Гүйцэтгэгч" гэх) түүнийг төлөөлөн _________________________
*(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)*
нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах
гэрээг харилцан тохиролцож байгуулав.

## 1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Ажлын нэр:

1.2. Гүйцэтгэх ажлын цар хүрээ:

1.3. Гэрээний хугацаа:

## 2. ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮН

2.1. Ажил гүйцэтгэсний хөлс _______ ₮ (үсгээр бичих) байна.

2.2. Ажилтны гүйцэтгэгчид төлөх хөлснөөс Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгана.

2.3. Ажил гүйцэтгэсний хөлсийг сард 2 хувааж төлнө. / Ажлын үр дүнг хүлээн авсны дараа төлнө.

## 3. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

3.1. Захиалагчийн эрх, үүрэг

3.1.1. Захиалагч тал нь хийгдэх ажлын хэмжээ, цар хүрээ, агуулгыг ажил гүйцэтгэгч талд танилцуулах үүрэгтэй.

3.1.2. Ажил гүйцэтгэсний хөлсийг энэхүү гэрээний 2.3-д заасан хугацаанд саадгүй олгох үүрэгтэй.

3.1.3. Ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах үүрэгтэй.

3.1.4. Ажил гүйцэтгэгчийн ажлын цаг, ажлын гүйцэтгэлд тухай бүрд нь хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулах эрхтэй.

3.1.5. Ажил гүйцэтгэгч энэхүү гэрээний 4.1-д заасан өдрөөр ажиллаагүй тохиолдолд ажиллаагүй цагийн хөлсийг хасч тооцох бөгөөд ажил саатуулсан шалтгаанаар өдрийн 0,2 хувийн алданги тооцох эрхтэй.

3.2. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.2.1. Захиалагчийг гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.2.2. Ажил гүйцэтгэгч нь 7 хоногт 5 өдөр ажиллаж Захиалагчийн захиалгат ажлыг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэх үүрэгтэй.

3.2.3. Ажил гүйцэтгэх аргын талаар Захиалагчийн өгсөн зааварчилгаа нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал эсхүл ажил гүйцэтгэгчээс үл хамаарах байдлаар ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх ямар нэгэн нөхцөл байдал бий болсон тохиолдолд нэн даруй Захиалагчид мэдэгдэх үүрэгтэй.

3.2.4. Ажил гүйцэтгэх явцад Захиалагчийн эд хөрөнгөнд ямар нэгэн эвдрэл, гэмтэл гаргасан тохиолдолд ажил гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлаж Захиалагчийг хохиролгүй болгоно.

3.2.5. Захиалагчийн захиалгат ажлыг энэхүү гэрээнд заасан цаг хугацаанд биелүүлээгүй тохиолдолд ажиллаагүй цагт ногдох хөлсийг хасуулж тооцуулна.

## 4. БУСАД

4.1. Энэхүү гэрээ нь Талуудын баталгаат гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

4.2. Гүйцэтгэхээр тохирсон ажлын үр дүн бүрэн биелснээр гэрээ дуусгавар болно.

4.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4.4. Талуудын хооронд маргаантай асуудал үүссэн тохиолдолд, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зөвшилцөх замаар, нэгдсэн тохиролцоонд хүрэхийг дээд зэргээр эрмэлзэнэ.

4.5. Талуудын хооронд маргаан гарвал талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн

Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

4.6. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж талууд тус бүрд нэг хувь хадгалагдах бөгөөд эхүүд ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ: |
| --- | --- |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## БАРИЛГАД ЗАСВАРЫН АЖИЛ ХИЙХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

_______________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Захиалагч" гэнэ/, түүнийг______________________________үндсэн дээр төлөөлөн

_______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

_______________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Гүйцэтгэгч" гэнэ/, түүнийг _____________________________ үндсэн дээр төлөөлөн

_______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах нөхцөлтэйгөөр байгуулав. Үүнд:

### 1. Нийтлэг заалт

1.1. Захиалагч нь батлагдсан төсөл, төсөв, ажлын зураг бүхий *(засвар хийх барилгын нэрийг бичих)* объектод засвар хийх даалгаврыг гүйцэтгэгчид өгнө.

1.2. Гүйцэтгэгч нь гэрээгээр тохиролцсон үндэслэл бүхий ажлыг хугацаанд нь гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.

### 2. Ажлын хөлс, хугацаа

2.1. Ажлын хөлсийг хоёр тал харилцан тохиролцож тогтооно. Нийт хөлс ________ төгрөг байна.

2.2. Засварын ажлыг 20__ оны ___ сарын ___-ны өдрөөс эхлэн 20__ оны ___ сарын ___-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж дуусгана.

### 3. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Гүйцэтгэсэн ажлыг захиалагчид мэдэгдсэнээс хойш ________ хоногийн дотор хүлээн авч тохиролцсон ёсоор хөлсийг төлнө.

3.2. Засвар хийхэд шаардагдах төсөл, төсвийн баримт бичиг, материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг гүйцэтгэгчид шилжүүлэн өгнө.

3.3. Засварын ажлын явцад хяналт тавих, хэрэв хүлээн авсан ажилд ямар нэг доголдол илэрвэл ажил хүлээн авснаас хойш ______ сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

3.4. ____________________________________________________________
____________________________________________________________

## 4. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1. Ажлыг захиалагчийн даалгавар, зураг, төсөл, төсвийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Захиалагчийн өгсөн баримт бичиг, материал, тоног төхөөрөмж засварын ажилд согог, дутагдалтай байвал түүнийг өөрчлөх, сольж өгөхийг шаардах эрхтэй.

4.3. Ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцна. (ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн зардал гэх мэт)

4.4. ____________________________________________________________
____________________________________________________________

## 5. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Гүйцэтгэгч ажлыг зохих ёсоор биелүүлээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _________ хувийн торгууль төлнө.

5.2. Гүйцэтгэгч ажлыг хугацаа хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн _______ хувийн торгууль төлнө.

5.3. Гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал нөгөө талд учирсан зардал, хохирлыг бүрэн хариуцна.

## 6. Маргаан шийдвэрлэх

6.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад Эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

7.1. А талын :

Оршин байгаа газар: ______________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________.

Утас: _____________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________.

7.2. Б талын:

Оршин байгаа газар: ______________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

7.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ________________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ____ дугаар сарын____ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Захиалагч" гэнэ/, түүнийг________________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

______________________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Гүйцэтгэгч" гэнэ/, түүнийг ______________________________ үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар Монгол Улсын Иргэний хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг удирдлага болгон дараах гэрээг байгуулав.

## 1. Нийтлэг заалт

1.1. Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төслийн дагуу (*барилгыг барих, өргөтгөх, өөрчлөх)* ажлыг хугацаанд нь гүйцэтгэж захиалагчид шилжүүлнэ.

1.2. Захиалагч нь шинжлэх ухаан, техник, эдийн засгийн шаардлага хангасан барилга, барилга байгууламжийн бэлэн болсон объектыг хүлээн авч эцсийн тооцоо хийнэ.

## 2. Гэрээний хугацаа

2.1. Хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтооно.

2.2. Барилгын ажлын ерөнхий хугацаа _______ жил (сар)

2.3. Барилгын ажлын үе шатны хэсэгчилсэн хугацааг (хавсралт 1)-т тодорхойлно.

## 3. Ажлын хөлс

3.1. Ажлын хөлсийг талууд харилцан тохиролцож тогтоох бөгөөд барилгын материалын тухайн үеийн зах зээлийн үнэ, хөлсийг удирдлага болгоно.

3.2. Барилгын ажлын нийт хөлс: ______________________________________________

3.3. Барилгын монтажийн хөлс: _______________________________________________

## 4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Барилгын зураг, төсөв, бусад зайлшгүй шаардлагатай баримт бичиг, тоног төхөөрөмж, материал, эд зүйлийг хугацаанд нь гүйцэтгэгчид шилжүүлэн өгнө.

4.2. Барилгын ажлын санхүүжилтийг ажлын үе шат бүрд тасралтгүй хийнэ.

4.3. Гүйцэтгэгчийн дотоод ажилд хутгалдан оролцохгүйгээр барилгын ажлын явц, түүний чанар, үр дүнд хяналт тавина.

4.4. Гүйцэтгэсэн барилгын ажилд гэмтэл, согог илэрвэл ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага тавих эрхтэй.

## 5. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1. Барилгын ажлыг батлагдсан зураг төсөл, титулын список, барилга монтажийн батлагдсан журмын дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.

5.2. Угсарсан тоног төхөөрөмжид турших ажилд оролцоно.

5.3. Туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, түүний үүргийг захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

5.4. Захиалагч гүйцэтгэсэн ажлыг хүндэтгэх шалтгаангүйгээр хүлээн авахгүй бол ажлыг гүйцэтгэсэнд тооцож эцсийн тооцоо хийх, учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.

5.5. ____________________________________________________________
____________________________________________________________

## 6. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаа хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутамд ______ хувийн алданги тооцож захиалагчид төлнө.

6.2. Захиалагчийн бэлтгэн өгсөн материал түүхий эд доголдолтой, захиалагчийн буруугаас тасалдсан бол сул зогссон хугацааны зардал, хохирлыг захиалагч хариуцна.

## 7. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 8. Маргаан шийдвэрлэх журам

8.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

8.2. Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

9.1. Барилгын ажил гүйцэтгэх явцад барилгын объект, үнэ, бусад нөхцөлд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

## 10. Нэмэлт нөхцөл

____________________________________________________________

____________________________________________________________

## 11. Бусад заалт

11.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдсэн хувь тус бүр ба хууль зүйн адил хүчинтэй болно.

11.2. Гэрээний хавсралт:

________________________________________________________

________________________________________________________

## 12. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

12.1. А талын :

Оршин байгаа газар: ___________________________________________.

Хаяг, индекс: ________________________________________________.

Утас: ____________ телетайп: _______________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _____________________________________.

12.2. Б талын:

Оршин байгаа газар: ___________________________________________________.

Хаяг, индекс: _________________________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _____________________________________.

12.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ________________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# ӨРӨМДЛӨГИЙН ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ ...........................................“ ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ , нөгөө талаас “................................” ХХК /цаашид “Захиалагч“ гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд“ гэх/ дор дурдсан нөхцөлөөр өрөмдлөгийн ажлыг /цаашид “Өрөмдлөг“ гэх / хийж гүйцэтгэхээр Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон тухайн харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг удирдлага болгон харилцан тохиролцож байгуулав.

## Нэг. Ерөнхий нөхцөл

1.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн .......................байрлах газарт /цаашид “Орд“ гэх/ өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.2. Энэхүү гэрээний дагуу хийж гүйцэтгэх өрөмдлөгийн ажлын хэмжээ нь .......уртааш метр ба цаашид дээжийн гарцаас хамаарч тодорхой хэмжээгээр нэмэгдэж болох ба анх гэрээлж өрөмдүүлэхээр тохиролцсон захиалгын тоо хэмжээ хасагдахгүй байна. Гэхдээ Захиалагчийн нэг цооногийн гүний хэмжээ ..........орчим уртааш метр байх ба гүний хэмжээ, азимут, өнцгийг геологийн өрөмдлөгийн ажлын даалгавар бүрд тодорхой бичиж Гүйцэтгэгчид өгнө. Өрөмдөж буй цооногуудын үр дүнг харгалзан дараагийн өрөмдөх цооногийг тухай бүрд нь зааж, гүйцэтгэгчийг хүлээлгэхгүй байлгана.

## Хоёр. Ажил гүйцэтгэх хугацаа

2.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу тээвэрлэлтийн зардал болон _____ ам.долларын урьдчилгааг Захиалагчаас авснаас хойш ажлын ___ хоногийн дотор ордын талбайд шаардлагатай техник, тоног төхөөрөмж болон ажилчдыг, тэдний амьдрах кемпийн хамт тээвэрлэн аваачиж суурилуулан бэлэн болгож, өрөмдлөгийн ажлыг эхэлнэ.

2.2. Гэрээнд гарын үсэг зурснаас хойш ___ хоногийн дотор ажлын талбайд очиж, түүнээс хойш .... хоногийн хугацаанд ажлыг хийж гүйцэтгэнэ.

## Гурав. Төлбөр хийх журам

3.1 Талууд ___ уртааш метр өрөмдлөгийн өртөгт ___ метр дээж зүсэлтийн, ___ ширхэг дээжийн хайрцгийн, өрмийн дурангийн ___ удаагийн хэмжилтийн үнийг шингээн энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтаар тохиров. Мөн коре ориентацийн цэг цохилтыг захиалагч талын хүсэлтээр цооног тус бүрд ___ удаа үнэгүй хийж өгөхөөр тохиролцов.

3.2 Энэхүү гэрээний өрөмдлөгийн ажлын нийт үнэ нь ___ ам. доллар болно. Энэхүү гэрээний үнэ нь эцсийн бөгөөд зөвхөн Талуудын тохиролцсоноор өөрчилж болно. Нийт үнэнд НӨАТ ороогүй бөгөөд хийгдсэн үйлчилгээний нэхэмжлэх тус бүрд НӨАТ бичигдэж байна.

3.3 Захиалагч нь энэхүү гэрээний төлбөрийг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.

Үүнд:

а/ Гэрээнд гарын үсэг зураад гэрээний үнийн дүнгийн 10 хувийг, тээврийн зардлын хамт

б/ Гэрээний үнийн дүнгийн үлдэгдэл төлбөрийг Захиалагч талын Ерөнхий геологич Захиалагч талаас цооног хүлээн авсан баримтад тулгуурлан, дараагийн геологийн даалгаврыг үндэслэн тухай бүр нэхэмжлэхийн дагуу урьдчилан Гүйцэтгэгчийн ___ банк дахь ___ тоот валютын дансанд шилжүүлнэ.

3.4. Захиалагч Гүйцэтгэгчийн техник, тоног төхөөрөмж болон ажилчдыг, тэдний амьдрах кемпийн хамт Улаанбаатараас Орд болон Ордоос Улаанбаатар хүргэх тээвэрлэлтийн хөлсийг гэрээ / Хавсралт №1 / байгуулснаас хойш ажлын ___ хоногт багтаан төлнө.

3.5. Захиалагч нь нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын ___ хоногт багтаан Гүйцэтгэгчийн дансанд мөнгийг шилжүүлнэ.

3.6. Захиалагч нь гэрээний дагуу хийж гүйцэтгэх ажлыг бүрэн дууссанаас хойш ___ хоногийн дотор үлдсэн бүх төлбөрийг Гүйцэтгэгчид төлж дуусгана.

3.7. Гүйцэтгэгчийн хийсэн ажлын хөлсийг Захиалагч гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө. Энэхүү алдангийн хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

## Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Орон нутгаас авах шаардлагатай бүх зөвшөөрлүүдийг хуулийн дагуу авч ажил эхлэхэд саадгүй бэлэн болгосон байна.

4.2. Захиалагч геологи өрөмдлөгийн ажлын даалгаврыг ажил эхлэхээс 3 хоногийн өмнө Гүйцэтгэгч талд бүрэн гаргаж өгнө. Технологийн процесст саатал доголдол гаргахгүй байх үүднээс геологи өрөмдлөгийн ажлын даалгаварт цооногийн гүн, гүний хэмжээ, цооног тавих өнцөг, азимутыг нарийн зааж өгнө.

4.3. Захиалагч өөрийн геологичдоор өрөмдлөгийн ажлын чанарт байнгын хяналт тавьж, цооног өрөмдөж дууссаны дараа уг цооногийг хүлээн авч өрөмдлөгийн рапортад гарын үсэг зурна. Өрөмдлөгийн ажлын чанарт мөрдөх үндсэн шаардлагууд:

4.3.1. Эрэл, эрэл үнэлгээний зориулалтаар өрөмдөх эхний ___ цооногт чөмгөний гарцыг өргөлт бүрд ___ хувиас доошгүй байлгах. Өрөмдлөгийн хүндрэлтэй нөхцөлд дээжийн гарцыг 90%-иас багагүй байлгаж, 2 талын актаар хүлээлцэнэ. /Хүндрэлтэй нөхцөлд шавар, шаварлаг хурдас, ан цавын орон зайг тооцно/

4.3.2. Ордны хүдрийн байрлал, шинж чанар тогтоогдсон нөхцөлд хүдрийн зурвас, биетэд дээжийн гарцыг тогтмол ___ %-иас багагүй, бусад чулуулагт ___ %-иас багагүй байлгана.Үүнд 4.3.1-д заагдсан хүндрэлтэй нөхцөл мөн үйлчилнэ.

4.3.3. Цооногоос авсан дээжийг дэс дугаар алдалгүйгээр хайрцаглаж, сайтар угааж цэвэрлэнэ.

4.4. Тус гэрээний 4.3.1, 4.3.2, 4.3.3-д заасан үндсэн шаардлагыг биелүүлсэн нөхцөлд уг цооногийг хүлээн авна.

4.5. Цооногт хийгдэх хазайлт, чиглүүлэлтийн зэрэг дагалдах ажлуудыг тухай бүрд нь гүйцэтгүүлэн, цооногийг хэдэн метрийн гүнд хаах, хүлээн авахыг захиалагч талын геологич энэхүү гэрээний 1.2-д заасан нөхцөлийн дагуу шийднэ.

4.6. Цооног өрөмдөж дууссан тохиолдолд хоёр талын хүлээн авсан акт үйлдэнэ.

4.7. Өрөмдлөгийн цооног хүрэх зам засалтын ажлыг захиалагч тал гүйцэтгэнэ.

4.8. Өрөмдлөгийн ажлыг найдвартай усаар хангахын тулд объектын талбайд гүний худаг өрөмдүүлэх ажлыг захиалагч тал хариуцан гүйцэтгүүлж, гарсан зардлыг хоёр тал тэнцүү хуваан төлнө.

4.9. Худаг өрөмдөх ажлаас гарсан зардлыг захиалагч санхүүжүүлж 3 талын гэрээ хийж, гүйцэтгэгчид ноогдох ___ %-ийн зардлыг гэрээт ажлын үнийн дүнгээс суутгана.

4.10. Захиалагч өөрийн геологичдыг дээж хүлээж авах ажилд өдөр тутам оролцуулж, өрөмдлөгийн репортод гарын үсэг зуруулна.

4.11. Захиалагчийн талаас томилогдсон геологичд нь архидалт, хэрэг зөрчилгүй, хөдөлмөрийн сахилга батыг чанд сахиж ажиллана. Хэрэв Захиалагчийн кемп дээр байгаа хүмүүс архидалт, хэрэг зөрчил, хөдөлмөрийн сахилга бат алдсан нөхцөлд түүнээс үүдэн гарах сул зогсолт болон бусад хохирлыг Захиалагч хариуцна.

4.12. Захиалагч нь өөрийн томилсон геологичдыг амьдрах байр, хоол хүнс, бусад шаардлагатай зүйлээр хангана.

4.13. Гүйцэтгэгчийн хамт Монгол улсын хөдөлмөрийн хууль, аюулгүй ажиллагаа ба Байгаль орчныг хамгаалах тухай хууль, дүрмийн заалтуудыг нягт мөрдөж, орон нутгийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй хамтарч ажиллана.

4.14. Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг тухай бүр саадгүй хийж гүйцэтгэнэ.

4.15. Мөн захиалагч нь гэрээт өрөмдлөгийг дууссаны дараа нэмэлт өрөмдлөг хийлгэхийг хүсвэл уг ажлыг дуусахаас ___ хоногийн өмнө асуудлаа гүйцэтгэгч талд бичгээр тавина.

4.16. Захиалагч дээжийг хүлээн авсны дараа чөмгийг зүсэх интервалуудыг зааж өгч, зүсүүлэн, бүрэн бүтэн байдлаар нь буцаан хүлээн авна.

4.17. Гүйцэтгэгчийн хийсэн өрөмдлөг нь гэрээгээр тохиролцсон хэмжээ, шаардлагыг хангаагүй бол тэр гүйцэтгэгчийн зардлаар доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.

## Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1. Цооногуудыг захиалагч талын геологичийн зааврын дагуу ___ градусын налуутай, өрөмдлөгийн диаметрийг HQ-ээр гүйцэтгэнэ. Хэрвээ цооногийн гүнийг ___ -гаас дээш метр болгон NQ-д шилжих тохиолдолд Захиалагч тал ___ хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

5.2. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн ажлын чанарт цаг ямагт анхаарч, энэхүү гэрээний 4.3-р зүйлийн 4.3.1, 4.3.2, 4.3.3-д заасан шаардлагыг хангана.

5.3. Өрөмдлөгийн ажлыг өрөмдлөгийн технологи, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд баримтлан чанартай, хурдан шуурхай, геологи өрөмдлөгийн ажлын даалгаврын дагуу хийж гүйцэтгэнэ.

5.4. Гүйцэтгэгч нь өрмийн ажилчдад зориулж цэвэр дулаан, тохь тухтай, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, эрүүл хоол хүнстэй кемпийг ажиллуулна.

5.5. Кемпэд элдэв зөрчил,гэмт хэрэг, архидан согтуурах явдал гаргахгүй байх ба гаднаас ирсэн бүх хүмүүс кемпийн дотоод журмыг хатуу мөрдөнө.

5.6. Захиалагчийн хамт Монгол улсын хөдөлмөрийн хууль, аюулгүй ажиллагаа ба байгаль орчныг хамгаалах тухай хууль, дүрэм заалтуудыг нягт мөрдөж, орон нутгийн удирдлага, холбогдох албаны хүмүүстэй хамтарч ажиллана.

5.7. Захиалагчийг энэхүү гэрээний дагуу төлбөрийг хугацаандаа хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

5.8. Захиалагч тал өрөмдөх цооногийг 1-ээс дээш хоногоор зааж өгөөгүй, төлбөр тооцоог хугацаанд нь хийхгүй, сул зогсоож хохирол учруулсан зэрэг тохиолдолд хэлэлцээрийн журмаар асуудлыг шийдэж чадаагүй бол өрөмдлөгийн ажлыг зогсоох эрхтэй.

## Зургаа. Хариуцлага

6.1. Захиалагчийн геологич, Гүйцэтгэгчийн мастерууд нар өрөмдлөгийн ажлын явцын тухай репорт хөтөлж өдөр тутмын гүйцэтгэлийг гаргаж, гарын үсгээр баталгаажуулалт хийж байна.

6.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас аль нэг талд хохирол учирвал Монгол Улсын холбогдох хуулийн дагуу буруутай тал хариуцлага хүлээнэ.

6.3. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгээгүй үнийн дүнд анз тооцох нь хохирол нөхөн төлөх үүргээс чөлөөлөхгүй.

## Долоо. Давтагдашгүй хүчин зүйл

7.1. Гэнэтийн аюул /дайн, газар хөдлөлт, халдварт өвчин, үер, гал түймэр, хэт халалт, хүйтрэлт, хүчтэй шуурга, төрийн эргэлт, онцгой байдал, аянга цахилгаан зэрэг/ болон хяналт тавих боломжгүй нөхцөл байдал үүссэн, өөрөөр хэлбэл урьдчилан тодорхойлох боломжгүй эрсдэлийн улмаас байдлаас гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон /форс-мажор/ тохиолдолд талууд энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу хугацаандаа биелүүлэх хариуцлагаас чөлөөлөгдөнө.

7.2. Өрөмдлөгийн ажлын үр дүнг захиалагчид шилжүүлэхээс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй, талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан, гэмтсэн тохиолдолд бий болох эрсдэлийг ажил гүйцэтгэгч хариуцна.

7.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч хугацаанд нь хүлээн аваагүй бол ажлын үр дүн ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байсан ч гэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болох үр дагаврыг захиалагч хариуцна.

## Найм. Бусад

8.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан маргааныг Талууд хэлэлцээрийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2. Талууд 30 хоногийн дотор тохиролцоонд хүрч эс чадвал энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, өөрчлөх, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитраар түүний Хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэрхүү нэмэлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

8.4. Энэхүү гэрээний тухай аливаа мэдээллийг аль нэг тал нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд мэдэгдэж үл болно.

8.5. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 эх хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

8.6. Энэхүү гэрээ нь түүнд оролцогч талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

## Ес. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

9.1. Гүйцэтгэгч талын :

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: ________________________________________________.

Утас: ____________ телетайп: ________________

Факс: _________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _______________________________.

9.2. Захиалагч талын:

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: ________________________________________________.

Утас: ____________ телетайп: ________________

Факс: _________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _______________________________.

9.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

<u>ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u> <u>ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u>

(гарын үсэг, тамга, тэмдэг)

*Нэр*
*Албан тушаал*

(гарын үсэг, тамга, тэмдэг)

*Нэр*
*Албан тушаал*

## ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Энэхүү Хөдөлмөрийн гэрээ (цаашид Гэрээ гэх)-г

Нэг талаас ________________________________________________________

хаягт байрлах, ________________ улсын бүртгэлийн дугаартай, __________________

/байгууллагын нэр/

түүнийг _____________________________________________________ үндсэн дээр төлөөлөн

_______________________________________________________________________

*/төлөөлсөн хүний албан тушаал, нэр/*

/цаашид Ажил олгогч гэх/,

Нөгөө талаас ______________________________________________________

хаягт оршин суух, __________________регистрийн дугаартай ____________овогтой ________________

/цаашид Ажилтан гэх/

нар (хамтад нь Талууд гэх) Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэн хэлэлцэн тохирч, энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Ажил олгогч болон Ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээний хавсралтууд болох Ажилтны зүгээс гаргасан нууцын баталгаа болон хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, гэрээний сунгалт зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### 2. Хөдөлмөрийн гэрээний хугацаа

2.1. Хөдөлмөрийн гэрээний эхлэх хугацаа: ........................

2.2. Гэрээний хүчинтэй хугацаа: .........................

2.3. Талууд гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах талаар хэн нэгэндээ санал тавиагүй бол энэхүү гэрээний хугацааг нэг жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно. Энэхүү нэг жилийн хугацаанд гэрээг талуудын аль нэгний саналаар цуцлаагүй бол уг гэрээний хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно.

## 3. Үндсэн нөхцөл

### 3.1. Гүйцэтгэх ажил үүрэг

3.1.1. Ажлын байр: ________________

3.1.2. Ажилтны албан тушаал:__________________

3.1.3. Ажилтны хариуцах ажил, үүрэг: Ажилтны эрхлэх ажил, албан тушаал дахь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэхээс гадна шууд болон шууд бус удирдлагаас өгсөн бусад үүрэг, даалгаврыг хийж гүйцэтгэнэ.

3.1.4. Хөдөлмөрийн нөхцөл: _________________

3.1.5. Ажлын цаг: _____________________

i. Ажлын өдөр _________ гарагаас ___________ гараг хүртэл _____ хоног байна.

ii. Хоногт ажлын ____ цагаар тооцон долоо хоногийн ___ цаг ажиллана.

iii. Ажил эхлэх цаг ___ цагт байна. Үдийн завсарлага___ - ___ цагт байна.

iv. Ажилтны ажлын цагийн хуваарь нь удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хүний нөөцийн бодлогын дагуу уян хатан байж болно.

v. Ажил тасралтгүй явагдах зарчмыг хангах зорилгоор Ажилтан хоцрох, эрт явах, ажил дээр байхгүй байх цагуудыг удирдлагад урьдчилан мэдэгдэнэ.

### 3.2. Цалин

3.2.1. Ажилтны нэг сарын үндсэн цалин ______ ₮ /___________________/ байна.

3.2.2. Ажилтны үндсэн цалингаас Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгана.

3.2.3. Ажил олгогч нь Ажилтны үндсэн цалинг сар бүрийн __ ба __-ны өдрүүдэд 2 (хоёр) хуваан олгоно. Хэрэв цалин олгох өдөр нь баярын болон амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөр олгоно.

3.2.4. Илүү цагаар ажилласан болон бүх нийтийн амралтын бусад өдрөөр ажилласан тохиолдолд нөхөж амраана.

### 3.3. Амралт

3.3.1. Амралтын өдөр, бүх нийтийн баярын өдрүүдээр Ажилтан амралт эдэлнэ. Ажлын шаардлага, нөхцөл байдлаас шалтгаалан ажилласан тохиолдолд нөхөж амраана.

3.2.2. Ажил олгогчийн баталсан ээлжийн амралтын журмын дагуу ээлжийн амралт олгоно. Ажилтан ээлжийн амралтыг биечлэн эдэлнэ.

## 4. Ажилтны эрх, үүрэг

4.1. Ажилтан дараах эрхийг эдэлнэ.

4.1.1. Ажилтан нь Ажил олгогчоос ажлын байранд эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлөөр хангуулах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай өрөө тасалгаа, техник хэрэгсэл, бичиг хэргийн материал зэрэг зүйлсээр бүрэн хангуулах эрхтэй.

4.1.2. Ажилтан нь Ажил олгогчоос гүйцэтгэх ажлын талаар заавар удирдамжаар хангуулах эрхтэй.

4.1.3. Ажилтан ажлын байран дээр ажил үүрэгтэй холбоотой асуудал болон түүний шийдлийн тухай шууд удирдлагад чөлөөтэй илэрхийлж, хэлэлцэх эрхтэй.

4.1.4. Гэрээгээр тохиролцсон цалин хөлсийг цаг тухай бүрд авах, амрах, “Хөдөлмөрийн тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ээлжийн амралтаа эдлэх, тэтгэвэр, тэтгэмж болон туслалцаа дэмжлэг авах;

4.2. Ажилтан дараах үүргийг хүлээнэ.

4.2.1. Хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахиж, өөрийн ажил үүрэгтэй холбогдсон бүх шаардлагыг бүрэн биелүүлж, боломжит өндөр бүтээмжээр ажиллах үүрэгтэй.

4.2.2. ....... хоног бүрээр ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэнэ.

4.2.3. Мэргэжил, ур чадвараа байнга дээшлүүлэн идэвх санаачилгатай ажиллах үүрэгтэй.

4.2.4. Хамт олны уур амьсгалыг эерэг байлгаж, дэг журмыг хангахад анхаарч, ёс зүйн минимум стандарт, харилцааны соёлтойгоор ажиллах үүрэгтэй.

4.2.5. Эрс илэн далангүй байх, энэрэнгүй байх зарчмыг баримтлан ажиллах үүрэгтэй.

4.2.6. Ажилтан нь байгууллагын дэг журмыг сахих ёстой бөгөөд байгууллагын нэр хүндийг унагасан үйлдэл хийхийг хориглоно.

## 5. Ажил олгогчийн эрх, үүрэг

5.1. Ажил олгогч дараах эрхийг эдэлнэ.

## 8. Энэ гэрээний онцгой нөхцөл.

____________________________________________________________

____________________________________________________________

____________________________________________________________

*(*Энд Худалдагч Ноу-Хау-г ашиглах талаар зөвлөгөө өгөх, Худалдан авагч Ноу-Хау-г хэрхэн ашиглаж буй талаар, Худалдагчид мэдээлэх зэрэг хамтын ажиллагааны нэмэлт нөхцөлүүдийг зааж болно*)*

## 9. Бусад нөхцөл.

9.1. Энэ гэрээний жинхэнэ эхийг хоёр хувь үйлдэж тал тус бүр нэг хувийг хадгална.

9.2. Энэ гэрээнд дурдаагүй асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.

9.3. Энэ гэрээнд гарын үсэг зурмагц түүнтэй холбогдуулан урьдчилан хийсэн бүх хэлцэл, бичиг захидал, зөвшилцөл, протоколууд хүчингүй болно.

## 10. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

10.1. Худалдагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

10.2. Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

10.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

## 11. Маргаан шийдвэрлэх журам

11.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

11.2. Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## ОЮУНЫ ҮНЭТ ЗҮЙЛ, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________________

__ *(оюуны үнэт зүйл, эд хөрөнгийг худалдаж буй этгээдийн овог, нэр хуулийн этгээд бол оноосон нэр)*

/цаашид "Худалдагч тал" гэнэ/, түүнийг______________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

______________________________________________________________

__ *(оюуны үнэт зүйл, эд хөрөнгийг худалдан авч буй этгээдийн овог, нэр хуулийн этгээд бол оноосон нэр)*

/цаашид "Худалдан авагч тал" гэнэ/, түүнийг ________________ үндсэн дээр төлөөлөн

(итгэмжлэл)

______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийн талаар тодорхойлбол:

   а) Оюуны үнэт зүйл, эд хөрөнгө нь ___ оны ___-р сарын ___-нд бүтээгдсэн

   ___оны.___р сарын___ -нд нийтийн хүртээл болсон, "_______" байгууллага, газарт ___ оны ___-р сарын ___ өдөр бүртгэгдэж, "______" нэр бүхий эрхийн баримт бичиг авч баталгаажсан болно.

   б) Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийн онцлог шинж байдал нь:

   ______________________________________________________________
   ______________________________________________________________
   ______________________________________________________________
   _________

2. Худалдагдаж буй оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг дээр дурдсан тодорхойлолтод тулгуурлан ______________ /*тоогоор* /__________/*үсгээр/* төгрөгөөр үнэлэн худалдах, худалдан авахаар тохиролцов.

3. Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг худалдан авагч талын эрх, үүрэг нь:

а) Худалдан авч буй оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх, ашиглах арга хэлбэр нь:

______________________________________________________________

____________________________________________байхаар талууд тохиролцов.

б) Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхдээ зохиогчийн нэрийг өөрчлөх эрхгүй бөгөөд түүнийг ашиглахдаа зохиогчийн нэрийг дурьдана.

в) Худалдан авагчаас оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхдээ уг эрхийг бүтээгч болон зохиогчийн нэр төр, алдар хүндэд харшлах үйл ажиллагаа явуулахгүй.

г) Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай монгол улсын хуульд заасан эрхийг худалдан авагч эдэлнэ.

д) Оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхэд агуулга, чанарын өөрчлөлт оруулах, үйл ажиллагаа явуулахад хүрвэл, худалдагч талтай зөвшилцөнө.

е) Худалдагч талаас гэрээнд заасан арга хэлбэрээр эрхийг хэрэгжүүлэхэд саад болох, эсвэл холбогдох баримт бичгийг шилжүүлэн өгөөгүйгээс эрх хэрэгжүүлэхэд саад учруулбал уг үйл ажиллагаагаа зогсоох, бичиг баримтыг шилжүүлэн өгөхийг шаардах эрхтэй.

Худалдагч тал шаардлагыг үл биелүүлбэл гэрээгээ цуцалж өөрт учирсан хохирлоо нэхэмжилнэ.

4. Худалдагч тал гэрээнд заасан дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

а) Худалдан авагч талаас оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхдээ энэ гэрээний 4-р зүйлд заасан арга хэлбэрээр ашиглахыг шаардах;

б) Худалдагдсан оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн эрхийг зориулалтаас өөр зүйлд ашиглаж, энэ нь олон түмэнд илтэд хохиролтой хийгээд худалдагч талын нэр хүндийг унагахад хүргэх байдал илэрвэл ийм байдлыг зогсоохыг шаардах, гэрээгээ цуцлах буюу хохирлоо нөхөн төлөхийг шаардах эрхтэй;

в) Худалдаж байгаа зүйлд холбогдох бусад этгээдийн эрх үүргийг худалдан авагч талд бүрэн тайлбарлаж, худалдан авагч талд эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах бичиг баримтыг шилжүүлэн өгөх;

5. Гэрээний талууд хүлээсэн үүргээ ___ оны ___-р сарын ___-ны дотор бүрэн биелүүлнэ. Хэрвээ үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол иргэний хуульд заасны дагуу харилцан хариуцлага хүлээнэ.

6. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

7. Гэрээ, байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

8. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

8.1 Худалдагч талын :

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

8.2 Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

8.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| --- | --- |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

_______________________________________________

(Тоног төхөөрөмжийг худалдаж буй этгээдийн овог, нэр хуулийн этгээд бол оноосон нэр)

/цаашид "Худалдагч тал" гэнэ/, түүнийг______________________________үндсэн дээр төлөөлөн

_______________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

_______________________________________________

(Тоног төхөөрөмжийг худалдан авч буй этгээдийн овог, нэр хуулийн этгээд бол оноосон нэр)

/цаашид "Худалдан авагч тал" гэнэ/, түүнийг ______________ үндсэн дээр төлөөлөн (итгэмжлэл)

_______________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар Иргэний хуулийн 243 дугаар зүйлд заасны дагуу дор дурьдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Гэрээний нөхцөлийн дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй,
   - _____ төрлийн /суудлын, ачааны, нийтийн тээвэр, тусгай гэх мэт/
   - _______ маркийн "__________" загварын

   | | | | | | | |
   |---|---|---|---|---|---|---|
   | | | | | | | |

   улсын бүртгэлийн дугаартай тээврийн хэрэгсэл түүнтэй холбоотой баримт бичгийг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх ба Худалдан авагч нь тэдгээрийг хүлээн авч, төлбөрийн тооцоо хийнэ.

2. Тээврийн хэрэгсэл нь_______________/тоогоор/ ______________ үсгээр төгрөгийн үнэтэй бөгөөд Худалдан авагч төлбөрийн тооцоог гэрээ байгуулснаас хойш _________________ хоногийн дотор хийнэ.

3. Тээврийн хэрэгсэл нь чанар, иж бүрдлийн хувьд бүрэн, улсын үзлэг тооллогод хамрагдсан байна.

4. Тээврийн хэрэгсэлд худалдагдсанаас хойш _____ (сар, жил) хугацаагаар баталгаа олгоно.

5. Худалдан авагч нь гэрээнд заагдсан шаардлага хангаагүй тээврийн хэрэгслийн доголдлын талаар Худалдагчид гомдлын шаардлага тавина.

6. Худалдагч гомдлын шаардлагыг хүлээн авснаас хойш доголдлыг 7 хоногийн дотор өөрийн хөрөнгөөр арилгах, гэрээний шаардлагад нийцэх ижил төрлийн тээврийн хэрэгслээр солих эсхүл худалдсан тээврийн хэрэгслийг буцаан авч, Худалдан авагчид төлбөрийг нь нэн даруй эргүүлэн олгоно.

7. Худалдагчийн буруугаас тээврийн хэрэгслийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд үнийн дүнгийн ___________ хувиар тогтоон Худалдан авагчид торгууль төлнө.

8. Худалдан авагч төлбөрийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд Худалдагчид хугацаа хэтрүүлсэн хоног тутам ___ хувийн алданги/*жич 0.5 хувиас бага байх*/ төлнө.

9. Худалдагдсан тээврийн хэрэгслийн үнэ тухайн үеийн ижил чанар, төрлийн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хөрөнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.

10. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, ирээдүйд олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотлоно.

11. Давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

12. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

13. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

14. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол гэрээнээс үүдэн гарсан буюу холбогдох гарсан аливаа маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу эцэслэн шийдвэрлүүлнэ.

15. Гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

16. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

## 17. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

17.1 Худалдагч талын :

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ___________________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

17.2 Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ___________________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

17.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ________________________________ | ________________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ________________________________________________________________

*(аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид"Худалдагч" гэнэ), түүнийг ______________________________үндсэн дээр төлөөлөн __________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

Нөгөө талаас _____________________________________________________________

*(аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид"Худалдан авагч" гэнэ), түүнийг _____________________________үндсэн дээр төлөөлөн _____________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

дараах гэрээг байгуулав. Үүнд:

### 1. Худалдах, худалдан авахаар тохирсон зүйлийн талаар.

1.1. _______________ аймаг, хот ____________ сум, хороо, багийн ________________ гудамж, талбайд дугаартай /хаягт/ орших, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн дугаартай, _________________ зориулалттай __________________________________

урт, _____ өндөр, ______ өргөнтэй, ______ давхар______ өрөө тасалгаа танхимтай _____ ашигтай талбайтай _______________________________

___________________________________________________________________

/барилга байгууламжийн нэрийг бичих/

______ урт______ өргөн________ өндөртэй нийтдээ ______ талбайтай хашаа, тохижуулсан хатуу хучилттай талбай, зам______________________

зүлэгжүүлсэн талбай, _____ төрлийн мод___ ширхэг, жимсний _____ мод, бут, сөөг______ ширхгийг тус тус худалдах, худалдан авахаар тохиролцов.

1.2. Гэрээний зүйл болох ________________________________ барилга, хашаа ашиглалтад ________ он _____-р сар_____ өдөр орсон, _____________________ _______________________________________ материалаар баригдсан.

1.3. Худалдагдаж буй үндсэн хөрөнгийн чанар: ______________________________ _______________________________________________________ эдэлгээний байдал ______________________ өнгө, үзэмж ___________ цаашид засвар, үйлчилгээ шаардлагатай. /шууд ашиглах боломжтой/

Эд хөрөнгийг шилжүүлэн өгөхөд шаардагдах стандарт, техникийн нөхцөл дараах байдлаар тодорхойлогдоно.

______________________________________________________________

______________________________________________________________

1.4. Талууд худалдах, худалдан авахаар тохиролцсон үл хөдлөх хөрөнгө болох___________________________ барилгыг __________________________ төгрөг, хашааг _______________төгрөг, тоног төхөөрөмжийг _______________ төгрөг, тохижилт бусад зүйлийг ________________ төгрөг, бүгд _____________ төгрөгөөр үнэлэхээр тохиролцов.

1.5. Худалдан авагчаас үнийг ______ оны ____ сарын ____-ны дотор _____________________ банк дахь ________ тоот дансанд төгрөг /валют/-аар шилжүүлнэ. /___________________ төгрөг, валют бэлнээр шилжүүлэн өгөв.

1.6. Гэрээнд заасан хөрөнгийг Худалдагчийн талаас __________________ Худалдан авагчийн талаас ___________________________ оролцсон бүрэлдэхүүнтэйгээр ______ оны ___ сарын ____ -ны өдрийн _____ цагт албан ёсоор гардуулан өгч авалцахаар тохиролцов. Ийнхүү хүлээлгэн өгөхдөө эд зүйлийн тоо хэмжээ, чанар, бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж, ус цахилгаан, холбооны суваг, үйлчилгээний байдал зэргийг тодорхой тусгасан баримтыг газар дээр нь үйлдэж, талуудыг бүрэн төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурна.

1.7. Гэрээнд заасан хугацааны дотор үүрэг гүйцэтгэх явцад худалдагдсан эд хөрөнгийн үнэнд болон мөнгөний ханшийн өөрчлөлт гарвал, энэхүү гэрээ байгуулсан өдрийн тохиролцсон үнээр тогтоох бөгөөд талууд үнийг дангаар өөрчлөх буюу өөрчлөхийг шаардах эрхгүй.

## 2. Худалдагчийн эрх үүрэг.

2.1. Худалдан авагч, худалдан авсан зүйлээ хүлээн авах буюу түүний үнийг төлөхөөр гэрээгээр тогтоосон хугацааг хожимдуулбал, түүнд үүргээ биелүүлэх болон биелэлтийг саатуулснаас учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхтэй.

2.2. Худалдагдсан эд хөрөнгийг шилжүүлэн өгөх хүртэл түүний бүрэн бүтэн байдлыг хариуцаж, гэрээний нөхцөлд заасан шаардлага хангахуйцаар засаж тохинуулж өгөх үүрэг хүлээнэ.

2.3. Гэрээний нөхцөлд тохирохгүй эд хөрөнгө шилжүүлэх, биелэлтийг саатуулах тохиолдол гарвал Худалдан авагчид учирсан хохирлыг нөхөн төлнө.

2.4. Эд хөрөнгийг шилжүүлэн өгөхөд түүнийг дагалдах бичиг баримт, хувийн хэрэг, паспорт, зураг, төсөв, газар эзэмших, ашиглах эрхийн бичиг,даатгал, төлбөр тооцооны бусад баримт,сантехник, ус цахилгаан, холбооны үйлчилгээ зэрэгт холбогдох баримт бичгийг хамтад нь гардуулан өгнө.

2.5. Энэхүү гэрээг байгуулахдаа худалдаж байгаа эд хөрөнгийн талаар хөлслөгч, барьцаалагч түрээслэгч зэрэг гуравдагч этгээд байхгүй болохыг мэдэгдэж байна.

/хэрэв бий бол тэдгээрийн эрхийн талаар зааж, тэдгээрт холбогдох асуудлыг хэрхэн зохицуулсныг тодорхойлно./

2.6. Дараах тохиолдлыг Худалдаж байгаа эд хөрөнгийн чанарын доголдол, согог гэмтэл гэж үзнэ. Үүнд: ____________________________ болно.

2.6.1. Эд хөрөнгийг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 6 сарын дотор дээр дурдсанаас өөр чанарын дутагдал илэрвэл уг дутагдлыг хариуцан арилгана.

2.6.2. Харин эдэлгээ, хадгалалт, хамгаалалтаас үүссэн буюу эд хөрөнгийг хүлээн авах үед мэдэгдэх ил дутагдлыг худалдагч тал хариуцахгүй.

### 3. Худалдан авагчийн эрх үүрэг.

3.1. Худалдан авсан эд хөрөнгийн үнийг тогтоосон хугацаанд дансаар болон бэлэн мөнгөөр шилжүүлэн өгнө.

3.2. Энэ гэрээнд заасан хугацаанд эд хөрөнгийг албан ёсоор хүлээн авна.

3.3. Үүрэг биелүүлэх хугацаа хожимдуулсан тохиолдолд түүнээс шалтгаалан гарсан зардал, хохирлыг Худалдагч талд төлж хохиролгүй болгоно.

3.4. Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй буюу гэрээний нөхцөлд түүнд үүргээ биелүүлэх, хугацаа хожимдуулснаас учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах эрхтэй.

3.5. Эд хөрөнгийг хүлээн авахдаа энэ гэрээнд заасны дагуу төлөөлөх бүрэн эрхтэй хүмүүсийн бүрэлдэхүүнээр оролцож, түүний иж бүрдэл, чанар байдал зэргийг шалгаж, дагалдах бичиг баримтын хамт авах ба хүлээн авах үед илэрсэн дутагдлыг талаар Худалдагч талтай тухайн үедээ хэлэлцэн, хэрхэхийг шийдвэрлэж, хүлээн авсан тухай баримтад тодорхой тусгана.

### 4. Давагдашгүй хүчин зүйл

4.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль / чөлөөлөгдөх үндэслэл болно.

4.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

### 5. Бусад зүйл

5.1. Энэхүү үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт _____ оны ____ сарын ____ өдрийн дотор ____________________________ нар хариуцан бүртгүүлнэ.

5.2. Худалдагдах эд хөрөнгө нь ____ оны ____ сар _____ өдөр хүртэл хугацаагаар _______________ -ын даатгалын байгууллагад ______________ төгрөгөөр үнэлж __________________ тохиолдол, нөхцөлүүдээр даатгалтай бөгөөд _____ оны _____ сар _____ өдөр олгосон _____________ дугаартай

гэрээ, баталгаа, хураамжийн баримтыг Худалдагч талд эд хөрөнгийн хамт шилжүүлэхээр тохиролцов.

5.3. Газар өмчлөгчийн өмчлөлд байсан үл хөдлөх эд хөрөнгийг худалдсанаас шалтгаалан дэвсгэр газрыг эзэмших ашиглах эрхийн талаар дараах тохиролцоонд хүрэв. Үүнд:_________________________________________

*5.4. Энэ эд хөрөнгийг худалдах тухай түүнийг хамтран өмчлөх эрхтэй гэр бүлийн бүх гишүүнтэй тохиролцсон бөгөөд тэдгээрийн бичгээр зөвшөөрсөн баримтыг хавсаргав.*

## 6. Гэрээ биелүүлэх баталгаа ба хариуцлага.

6.1. Гэрээ байгуулагч талууд үүргээ хугацаанд нь шударгаар биелүүлнэ. Хэрвээ гэрээ зохих ёсоор биелүүлээгүй бол Монгол Улсын Иргэний хуулийн 180, 205, 206 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Гэрээнд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй тал гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.5 хувиар тооцож хоног тутамд алданги төлөх боловч гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ________________ хувиас хэтрэхгүй байна. /50 хүртэл хувь байж болно./

6.3. Гэрээний аль нэг тал өөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргээ биелүүлэх тодорхой хугацаа заах бөгөөд тохиролцсон хугацаанд үүргээ хэрэгжүүлээгүй бол гэрээг цуцалж, гэрээ байгуулснаас учирсан хохирол, түүгээр тогтоосон анзыг төлүүлнэ.

6.4. Энэ гэрээг байгуулж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болов.

6.5. Гэрээг 4 хувь үйлдэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт, нотариатын байгууллагат тус бүр нэг хувийг хадгалуулж, талууд тус бүр нэг хувийг хадгалав.

## 7. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд байгуулах гэрээ, худалдагдсан зүйлийн талаар санал зөрөлдөөн гарвал иргэний хуульд заасан журмын дагуу гомдлын шаардлага гаргах, хариу өгөх зэргээр найрсгаар харилцаж маргааныг зохицуулна.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд тус гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 8. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

8.1. Худалдагч талын :

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ___________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ________________________________________.

8.2. Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________________.

Утас: _______________ телетайп: ___________________

Факс: _____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ________________________________________.

8.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| __________________________________ | ________________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## ҮНЭТ ЦААС, ХУВЬЦАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ____ дугаар сарын____ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________________

*/ хувьцаа болон үнэт цаас худалдаж буй этгээдийн нэр, хаяг /*

/ Цаашид "Худалдагч" гэнэ /,түүнийг ________________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________

*/ төлөөлсөн хүний албан тушаал, нэр /*

Нөгөө талаас:

______________________________________________________________

*/ хувьцаа болон бусад үнэт цаас худалдан авч буй этгээдийн нэр, хаяг /*

/Цаашид "Худалдан авагч" гэнэ/, түүнийг_____________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________

*/ төлөөлсөн хүний албан тушаал, нэр /*

нар дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

1. Дараах үнэ бүхий хувьцаа, үнэт цаасыг худалдагч, худалдан авагчийн өмчлөлд шилжүүлж, худалдан авагч түүнийг хүлээн авч зохих үнийг төлнө.

1.1. Хувьцаа, үнэт цаасны нэр : ________________________________________________

1.2. Хувьцаа, үнэт цаасны зэрэглэл : ___________________________________________

1.3. Ширхэг хувьцаа, үнэт цаасны нэрлэсэн үнэ : _______________________________

1.4. Хувьцаа, үнэт цаасны тоо : ________________________________________________

1.5. Хувьцаа, үнэт цаасыг худалдах үнэ : _______________________________________

1.6. энэ гэрээний нийт үнэ : ____________________________________________________

_____________________________________________________________төгрөг тус тус болно.

2. Худалдагч, худалдан авагчид энэхүү худалдаж буй хувьцаа ,үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэхийн тулд шаардагдах баримт бичгийг өгнө.

3. Худалдан авагч хууль тогтоомжид заасан ёсоор энэ гэрээг бүртгүүлж гэрээний 1-д заасан хувьцаа, үнэт цаасны үнийг бүрэн төлсний дараа уг хувьцаа, үнэт цаасыг өмчлөх эрхтэй болно.

4. Худалдагч, худалдан авагч талууд гүйлгээ хийсэн, хувьцаа, үнэт цаас худалдсан ба худалдан авсны төлөө ноогдох татварыг адил хэмжээгээр хуваан төлнө.

5. Гэрээний үйлчлэх хугацаа: Энэ гэрээнд талууд гарын үсэг зурснаас хойш______

өдрийн дотор худалдагч үнэт цаасыг худалдан авагчид өгч, худалдан авагч уул үнэт цаасыг хүлээн авч үнийг нь төлнө.Гэрээнд дурдсан үүргээ биелүүлээгүй тал нь хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

6. Худалдагч, худалдан авагч талууд энэ гэрээг бүртгэсэн байгууллагад энэ гэрээний үнийн дүнгийн 0.05 хувийн хэмжээтэй тэнцэх хэмжээгээр бодож тал тус бүр ____________төгрөг төлөхөөр тохиролцов.

Гэрээг цуцалсан тохиолдолд энэ мөнгийг буцааж авахгүй бөгөөд харин тэр нь гэрээ цуцлахад хүргэсэн буруутай тал арилгавал зохих хохиролд багтана.

7. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

8.Энэ гэрээний үндсэн эхийг 2 хувь үйлдсэн бөгөөд гэрээ нь хууль зүйн ижил хүчинтэй болно.

9.Энэ гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

10.Энэ гэрээний дагуу талууд “гэрээнийхээ үүргээ бүрэн биелүүлсэн болох нь” энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох “хүлээлгэн өгч, авсан тухай” актаар батлагдана.

11. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

11.1 Худалдагч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

11.2 Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

11.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| --- | --- |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр                                   Улаанбаатар хот

Нэг талаас:

_______________________________________________________________

/ хуулийн этгээд, иргэний нэр, хаяг /

/цаашид “Худалдагч” тал гэнэ, /түүнийг____________________үндсэн дээр төлөөлөн______________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас:

_______________________________________________________________

(хуулийн этгээд, иргэний нэр, хаяг)

/цаашид “Худалдан авагч” тал гэнэ/, түүнийг _____________үндсэн дээр төлөөлөн

(итгэмжлэл)

_______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар Иргэний хуулийн 243 дугаар зүйлд заасны дагуу дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний агуулга

1.1. Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй барааг бэлдэж Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.

1.2. Барааны нэр, төрөл________________

1.3. Барааны үйлдвэрлэгч_______________

1.4. Барааны байршил_________________

1.5. Барааны тоо хэмжээ________________

1.6. Худалдагч бараанд холбогдох аливаа баримт бичгийг Худалдан авагчид барааг __________/ачуулснаар, хүлээлгэн өгөх/-ээр шилжүүлнэ.

1.7. Энэхүү гэрээний Хавсралтад дурдсан графикаар барааг дурдсан хугацаанд нийлүүлсэн байна.

## 2. Чанар

2.1. Худалдагчийн нийлүүлэх барааны чанар дараах шаардлагыг хангасан байна: (барааны чанарыг тодорхойлох улсын стандарт, техникийн нөхцөл, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, загвар гэх мэт)

2.2. Худалдагч барааны чанарыг _________/ баримт бичгийн нэр / -аар тодорхойлно.

2.3. Баталгаат хугацаа__________ / үйлдвэрлэсэн огноо, барааг худалдсан, нийлүүлсэн огноо /-аас эхэлж__________ -д дуусна.

2.4. Худалдагч баталгаат хугацаанд барааны аливаа дутагдал доголдол, гэмтлийг арилгана. Аливаа гэмтэл дутагдал, доголдол илэрснээс хойш _________ /сар, өдөр, цаг/-ийн дотор мэдэгдэж заасан хугацаанд худалдагчид мэдэгдсэн бол өөр бараагаар солино.

## 3. Иж бүрдэл

3.1. Худалдагчийн нийлүүлэх барааны иж бүрдлийг ___________/улсын стандарт, загвар журам, техникийн нөхцөл, бусад эрх зүйн акт/-аар тодорхойлно.

3.2. Барааны иж бүрдлийн нэмэлт шаардлага нь ________________________________________________________________
________________________________________________________________

## 4. Нийлүүлэх хугацаа, нөхцөл

4.1. Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид __________ /төлбөр төлсөн, гэрээний нөхцөл, бусад/-ийн дараа__________ /цаг, өдөр, долоо хоног, сар, жил/-ийн дотор ________ газарт нийлүүлнэ.

4.2. Худалдагч гэрээнд заасан нийлүүлэлтийн хугацаанаас өмнө барааг нийлүүлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд Худалдан авагчид нийлүүлэлтийн тухай мэдэгдсэн байна. /Энд ийнхүү мэдээлэх тухай бусад шалтгааныг бичиж болно./

4.3. Барааг дараах нөхцөлөөр нийлүүлнэ: ИНКОТЕРМС 2000, 2010 ________________________________________________________________

## 5. Үнэ төлбөр

5.1. Барааны нэгжийн үнэ ____________ /валют төгрөг / болно.

5.2. Гэрээгээр худалдах барааны нийт үнэ __________ /валют төгрөг/ болно.

5.3. Худалдан авагч нь гэрээ байгуулмагц урьдчилгаа төлбөрийг төлж барааг хүлээн авмагц _________хугацааны дотор үлдэгдэл төлбөрийг бүрэн төлнө.

5.4. НӨТ энэхүү гэрээнд дурдсан үнэд ороогүй болно. /гэхдээ, НӨТ-ийг гэрээний үнэд шингээсэн бол энэ тухай гэрээндээ заана./

5.5. Үнэ нэмэх, валютын үнэ унах зэрэг энэхүү гэрээний нийт үнийг өөрчлөх үндэс болохгүй.

## 6. Төлбөр төлөх ажиллагаа

6.1. Худалдан авагч ___________- ий дараа __________ /сар, өдөр/-ийн дотор гэрээнд заасан нийт үнийн ____________хувийг урьдчилж төлнө.

6.2. Худалдан авагч __________-ий дараа _________/огноо/-д барааны нийт үнийг бүрэн төлж дуусна.

6.3. Төлбөрийн хэрэгсэл___________________

6.4. Төлбөрийн төрөл:_____________ /бэлнээр, банкны шилжүүлэг, аль алинаар/

6.5. Худалдан авагч Худалдагчид төлбөрийг хийсэн тухай __________-ээс хойш-_________ий дотор _________ /шуудан, факс гэх мэт/-аар мэдэгдэнэ.

6.6. Энэхүү гэрээний 7.3-д заасан нэмэлт төлбөрийг үндсэн төлбөрийн ажиллагаагаар хийнэ.

6.7. Энэхүү гэрээний 5.3- зүйлд заасан барааны иж бүрдлээс бүрдэх зүйлсийг нийлүүлэх төлбөр дараах байдлаар үйлдвэрлэгчээс шилжинэ.

___________________________________________________________________________

___________________________________________________________________________

## 7. Сав баглаа боодол

7.1. Худалдагч барааг аюулгүй сав баглаа боодолд хийж, Худалдан авагч барааг хүлээн авах хүртэл гэмтэл эвдрэл, устахаас сэргийлж баталгаажуулна.

7.2. Сав баглаа боодол дараах байдлаар хийгдэнэ.

___________________________________________________________________________

___________________________________________________________________________

7.3. Сав баглаа боодлын үнэ барааны үнэд орсон /ороогүй болно.

7.4. Сав баглаа боодлыг буцаан илгээх нөхцөл, хугацаа _____________________

7.5. Сав баглаа боодлыг буцаах төлбөрийн нөхцөл _________________________

## 8. Шошго

8.1. Барааны шошгыг дараах байдлаар хийнэ: /шошгын зураг, шошгон дээр бичсэн зүйлийг хавсаргана, улсын стандарт шошго хэрэглэх нөхцөлийг хавсаргана./

## 9. Ачаалах, тээвэрлэх

9.1. Ачаалах газар________________

9.2. Худалдагч барааг __________-ээс хойш __________-/сар, өдөр/аас хэтрүүлэлгүйгээр ачаалж, илгээнэ.

9.3. Тээврийн хэрэгсэл___________________

9.4. Тээвэрлэх бараан хамгийн доод хэмжээ нь _____________ /тээвэрлэлт бүрийн тээвэрлэх барааны хамгийн доод хэмжээ/

9.5. Барааны тээвэрлэлтэд тавигдах тусгай шаардлага______________________

9.6. Худалдагч Худалдаг авагчид барааны тээвэрлэлтийн тухай ___________-ий дараа ______________/сар, өдөр, долоо хоног/-ийн дотор ____________ /шуудан, телеграм, факс/-аар мэдэгдэнэ. Энэ мэдээлэлд дараах зүйлсийг тусгана: ачаалах огноо, тээвэрлэлтийн бичиг, тээврийн хэрэгслийн тоо, дугаар /усан онгоц/машин/онгоц/галт тэрэгний дугаар, нэр/ гэрээний дугаар, огноо, нэр, барааны тоо хэмжээ/

## 10. Барааг хүлээн авах

10.1. Худалдагч нь Худалдан авагчид _____________ /хүлээн авах газар/-т барааг хүлээлгэн өгнө.

10.2. Талууд хүлээн авах цэг дээр барааны тоо хэмжээ, чанарыг хуульд заасан арга ажиллагааны дагуу шалгана.

10.3. Худалдан авагч Худалдагчид ___________ий дараа______________дотор /өдөр,цаг, сар/___________/телеграм, факс/-аар мэдэгдэнэ.

10.4. Талууд барааг хүлээлцэхдээ барааны тоо чанарын талаар маргаан гарч болзошгүй гэж үзвэл МҮХАҮТанхимын шинжээчдийг оролцуулан бараанд дүгнэлт гаргуулж болно.

## 11. Гэрээний хүчин төгөлдөр байдал

11.1. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээ нь үүргийг бүрэн гүйцэтгэх хүртэл хүчин төгөлдөр байх боловч аль ч тохиолдолд ____________ оны_________сарын__________өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

## 12. Талуудын үүрэг хариуцлага

12.1. Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа олох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох хохирлыг хуулийн дагуу төлнө.

12.2. Худалдан авагч дараах үүрэг хүлээнэ:

a) _________________тохиолдолд, ______________/гэрээний үнэ эсвэл өр төлбөрийн дүн/-ийн хувийн төлбөрийг Худалдагчид төлнө.

b) ___________________тохиолдолд, Худалдагчид_____________/гэрээний үнэ эсвэл өр төлбөрийн хэмжээ/-ийн хувийн торгуулийг төлнө.

12.3. Худалдагч энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ. ___________________тохиолдолд, _____________/гэрээний үнэ эсвэл өр төлбөрийн дүн/-ийн хувийн төлбөрийг Худалдан авагчид төлнө.

12.4. Хэрэв аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний хүчин төгөлдөр хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлэхээс татгалзвал, нөгөө талдаа __________ торгууль төлнө.

12.5. Энэхүү гэрээний бусад нөхцөлийг зөрчсөн тал дараах хариуцлага хүлээнэ:

## 13. Давагдашгүй хүчин зүйл

13.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

13.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 14. Гэрээний гүйцэтгэлийг хангах арга

______________________________________________________________

______________________________________________________________

(Энд гэрээний гүйцэтгэлийг хангах арга болох баталгаа, дэнчин, анз, торгууль зэргийг тусгаж болно.)

## 15. Маргаан шийдвэрлэх журам

15.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

15.2. Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 16. Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх

16.1. Энэхүү гэрээний нөхцөлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу өөрчилж, нэмж болно.

16.2. Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

## 17. Талуудын хоорондох харилцаа

17.1. Энэ гэрээтэй холбоотой асуудлаар харилцах Талуудын эрх бүхий төлөөлөгчдөөр доорх хүмүүсийг томилов:

| А талын: | Б талын : |
| --- | --- |
| Нэр: | Нэр: |
| Албан тушаал: | Албан тушаал: |
| Утасны дугаар: | Утасны дугаар: |
| Цахим шуудангийн хаяг: | Цахим шуудангийн хаяг: |

## 18. Тусгай нөхцөл

______________________________________________________________________

______________________________________________________________________

## 19. Бусад нөхцөл

19.1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.

19.2. Монгол Улсын Иргэний хуулиар энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг зохицуулна. /Энд өөр хууль тогтоомжийн актыг дурдаж болно/

19.3. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.

## 20. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

20.1. Худалдагч талын :
Оршин байгаа газар: _______________________________________________.
Хаяг, индекс: _____________________________________________________.
Утас: _____________ телетайп: ________________
Факс: __________________
Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.
20.2. Худалдан авагч талын:
Оршин байгаа газар: _______________________________________________.
Хаяг, индекс: _____________________________________________________.
Утас: _____________ телетайп: ________________
Факс: __________________
Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.

20.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

## 21. Гэрээний хавсралт

21.1. Барааны тухай мэдээллийг заасан хавсралт нь тус гэрээний салшгүй хэсэг болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

*БУСДЫН ЭЗЭМШИЛ АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ*

# АЖЛЫН БАЙР ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ______________________________________________________________

*/барилга байшинг өмчлөгч буюу захиран зарцуулах эрх бүхий байгууллагын нэр/*

/цаашид “Түрээслүүлэгч” гэнэ/, түүнийг____________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________________

*/төлөөлсөн хүний албан тушаал, нэр/*

Нөгөө талаас ____________________________________________________________

*/байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг/*

/цаашид “Түрээслэгч” гэнэ/, түүнийг______________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________________

*/төлөөлсөн хүний албан тушаал, нэр/*

нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хуулийн 318-326 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав. Үүнд:

## 1. Нийтлэг үндэслэл

1.1. Түрээслүүлэгч талын эзэмшилд буй байрны ________________ зориулалттай өрөөг ____ оны ___ дугаар сарын ____-ны өдрөөс эхлэн ___________ жилийн хугацаагаар Түрээслэгчид эзэмшүүлж ______________________________ зориулалтаар ашиглуулахаар тохиролцов.

1.2. Талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд аль нэг талын шаардсанаар гэрээг өөрчлөх буюу цуцалж болно.

1.3. Гэрээнд тусгагдаагүй шалтгаан, бусад үндэслэлээр аль нэг тал гэрээг дангаар өөрчлөх буюу цуцалж болно.

1.4. Түрээслүүлсэн өрөөний талбайн хөлс болон бусад төрлийн хөлсний хэмжээг талууд тохиролцон тогтооно.

## 2. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчих, түрээсэлсэн байраа зориулалтын бусаар ашиглах, бусдад хууль бусаар шилжүүлэх, төлбөрийн чадваргүй болох, эд хөрөнгө эзэмших чадваргүй болсон тохиолдолд гэрээг дангаараа цуцлах, учирсан хохирлыг Түрээслэгчээс нэхэмжлэх эрхтэй.

2.2. Түрээсэлсэн байрны тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээнд осол гэмтэл, эвдрэл гарвал цаг тухайд нь засварлаж, засвараас гарсан зардлыг Түрээслэгчээр төлүүлнэ.

2.3. Түрээслүүлэгчийн үйл ажиллагаанаас хамаарч түүнд хохирол учрах нөхцөл байдал бий болоход Түрээслэгч нь энэ тухай мэдсээр байгаад Түрээслүүлэгчид зохих анхааруулга өгөөгүй, арга хэмжээ аваагүй бол учирсан хохирлыг Түрээслэгчээс нэхэмжлэх буюу гэрээг цуцална.

2.4. Түрээсийн гэрээг цуцлахыг хүсвэл цуцлах тухай саналаа Түрээслэгчид цуцлахаас 2 сарын өмнө мэдэгдэнэ.

2.5. Түрээслүүлсэн барилгын инженерийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг Түрээслэгчид актаар хүлээлгэн өгнө.

2.6. Тухайн барилгын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн ашиглалт, бүрэн бүтэн байдал болон гадна орчны ариун цэвэр, тохижилтод байнгын хяналт тавина.

2.7. Байрны шугам сүлжээ, инженерийн тоног төхөөрөмж, эд хөрөнгөнд норматив хугацаа болсон тохиолдолд их засвар хийх бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийж, түүний засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг Түрээслэгчээс гаргуулна.

## 3. Түрээслэгчийн эрх, үүрэг

3.1. Түрээслүүлэгчээс гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй нөхцөлд биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.2. Түрээсэлж буй байр, эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах талаар Түрээслүүлэгчид санал, хүсэлт тавих эрхтэй.

3.3. Түрээсэлсэн байраа гэрээнд заасан зориулалтаар нь эзэмшиж, ашиглах бөгөөд гадна орчны цэвэрлэгээ, тохижилтыг бүрэн хариуцна.

3.4. Гэрээнд заасны дагуу Түрээслүүлэгчээс тавьсан шаардлагыг тухай бүрд нь биелүүлнэ.

3.5. Түрээсийн төлбөрийг тохиролцсон хэмжээгээр сар бүрийн___________-ний дотор Түрээслүүлэгчид бэлнээр буюу дансаар төлөх бөгөөд төлбөрийн хугацааг хожимдуулсан хоног тутамд төлбөрийн дүнгийн__________хувиар бодож торгууль төлнө.

3.6. Гэрээний хугацаа дуусгавар болсон буюу гэрээг цуцалсны дараа түрээслэн авсан байр, эд хөрөнгийг Түрээслүүлэгчид хүлээлгэн өгнө.

3.7. Түрээсийн гэрээг цуцлахыг хүсвэл тэр тухай саналаа нөгөө талд ийнхүү цуцлахаас 2 сарын өмнө мэдэгдэнэ.

## 4. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

4.1. Талууд түрээсийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүсвэл, энэ тухай саналаа нөгөө талдаа мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

## 5. Давагдашгүй хүчин зүйл

5.3. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт /-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

5.4. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 6. Маргаан шийдвэрлэх

7.1. Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв талууд эвийн журмаар шийдвэрлэж чадахгүй тохиолдолд гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 8. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

8.1. Түрээслүүлэгч талын :

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.

8.2. Түрээслэгч талын:

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.

8.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

___________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*
*Нэр*
*Албан тушаал*

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

___________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*
*Нэр*
*Албан тушаал*

## ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ТҮРЭЭСЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас_____________________________________________________________
*(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*
(цаашид "Түрээслүүлэгч" гэнэ), түүнийг ____________________ үндсэн дээр төлөөлөн ___________________________________________________________________________
*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*
Нөгөө талаас ___________________________________________________________________________
*(байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*
(цаашид "Түрээслэгч" гэнэ), түүнийг __________________ үндсэн дээр төлөөлөн ___________________________________________________________________________
*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*
нар дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

### 1. Гэрээний агуулга

1.1 Түрээслүүлэгч дор дурдсан тоног төхөөрөмж (цаашид "Түрээсийн эд хөрөнгө" гэнэ)-ийг түр хугацаагаар эзэмшүүлэн ашиглуулахаар шилжүүлэн өгч, Түрээслэн авагч түүнийг хүлээн авна:

1.1.1 Нэр: Энэ гэрээний 1-р хавсралтад дурдсан.

1.1.2 Түрээсээр шилжүүлэн өгөх үед түрээсийн эд хөрөнгийн байдал (чанар): ________________________________________ байв.

### 2. Түрээсийн зорилт

2.1 Түрээслэн авагч нь Түрээсийн эд хөрөнгийг үйлдвэрлэлд ашиглах зориулалтаар түрээслэн авсан болно.

### 3. Эд хөрөнгийг түрээсээр шилжүүлэн өгөх журам

3.1 Энэ гэрээнд гарын үсэг зурснаас хойш 10 хоногийн дотор Түрээсийн эд хөрөнгийг Түрээслүүлэгч шилжүүлэн өгч, Түрээслэн авагч хүлээн авна.

3.2 Түрээсийн эд хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах ажлыг талуудын мэргэжилтнүүд зохих акт үйлдэж гүйцэтгэнэ.

### 4. Түрээсийн хугацаа

4.1 Түрээсийн эд хөрөнгийг шилжүүлэн өгсөн хугацааг хүлээлгэн өгөх, хүлээн авах актад гарын үсэг зурсан өдрөөс эхлэн тоолно.
4.2 Түрээсийн хугацаа нь тийнхүү актаар хүлээлгэн өгч, хүлээн авсан өдрөөс хойш __________________ жил (сар, хоног) болно.
4.3 Түрээсийн хугацааг зөвхөн талуудын тохиролцсоноор богиносгож болно.

## 5. Түрээсийн төлбөр болон тооцоо хийх журам

5.1 Түрээсийн төлбөрийн хэмжээ: ____________________________ хугацаанд __________________________________________________ төгрөг болно (нэмүү өртгийн татварыг оруулаад).
5.2 Түрээсийн төлбөрийг бэлэн бусаар, Түрээслүүлэгчийн банк дахь тооцооны дансанд ______________________________________ (улирал бүрт дараагийн улирал эхлэхээс 5 хоногийн өмнө гэх мэтээр) хугацаанд шилжүүлэн өгнө.
5.3 Түрээсийн төлбөрийн хэмжээг Талууд тохиролцсоны үндсэн дээр ____________________________ хугацаанд (жилд нэг удаа гэх мэтээр) хянан үзэж болно.

## 6. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

6.1 Түрээслүүлэгч Түрээсийн эд хөрөнгийг энэ гэрээний заалт ёсоор ашиглаж байгаа эсэхийг шалган үзэх эрхтэй.
6.2 Түрээслүүлэгчийн үүрэг:
6.2.1 Түрээсийн эд хөрөнгийг ажиллуулж ашиглах техникийн дүрэмтэй Түрээслэн авагчийг танилцуулах, шаардлагатай үед ашиглаж буй газар дээр нь мэргэжилтнээ явуулан зохих зааварчилга өгөх;
6.2.2 Түрээсийн эд хөрөнгийг зөв ашиглах талаар мэдээлэл, зөвлөлөө өгч дэмжлэг үзүүлэх.

## 7. Түрээслэгчийн эрх, үүрэг

7.1 Түрээслэн авагчийн үүрэг:
7.1.1 Түрээсийн эд хөрөнгийг энэ гэрээний 2-д дурдсан зориулалтаар ашиглах;
7.1.2 Түрээсийн төлбөрийг цаг тухайд нь төлөх;
7.1.3 Түрээсийн эд хөрөнгийг зохих техникийн баримт бичигт заасан ашиглах, хадгалах журмыг хатуу сахиж хэрэгжүүлэх;
7.1.4 Мэргэжилгүй хүмүүсийг Түрээсийн эд хөрөнгө дээр ажиллуулахгүй байх;
7.1.5 Түрээсийн эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах.

## 8. Түрээслүүлэгчид эд хөрөнгийг буцаан өгөх журам

8.1 Түрээслэн авагч түрээсийн хугацаа дуусcанаас хойш ________ хоногийн дотор Түрээсийн эд хөрөнгийг Түрээслүүлэгчид зохих баглаа боодолтойгоор техникийн баримт бичгийн хамт иж бүрнээр хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай актаар хүлээлгэн өгнө.
8.2 Түрээсийн эд хөрөнгийг буцаан хүлээлгэн өгөх, хүлээн авах актыг хоёр талын зохих мэргэжилтнүүд гүйцэтгэнэ.

8.3 Түрээсийн эд хөрөнгийг Түрээслүүлэгчид хэвийн элэгдэл хорогдлыг тооцон, бүрэн бүтэн, ердийн ажиллагаатайгаар хүлээлгэн өгнө.
8.4 Түрээслэн авагч Түрээсийн эд хөрөнгийг бүрэн буюу хагас хэмжээгээр хоёр талын гэрээ тохиролцоонд дурдсан нөхцөл, журмын үндсэн дээр худалдан авч болно.

## 9. Талуудын хариуцлага

9.1 Түрээслэн авагч энэ гэрээгээр дараах хариуцлага хүлээнэ:
9.1.1 Түрээсийн эд хөрөнгийг хүлээн авах хугацааг хожимдуулсан бол уг эд хөрөнгийн үнийн _____ хувьтай тэнцэх хэмжээгээр алдангийг тийнхүү хугацаа хожимдуулсан өдөр бүрд төлнө.
9.1.2 Түрээсийн төлбөр төлөх хугацааг хожимдуулсан бол өрийн дүнгийн _____________ хувьтай тэнцэх хэмжээгээр алдангийг хожимдуулсан өдөр бүр төлнө.
9.1.3 Түрээсийн эд хөрөнгийг зориулалт бусаар ашигласан бол түрээсийн жилийн төлбөрийн дүнгийн ______ хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль төлнө.
9.1.4 Түрээсийн эд хөрөнгийг бүтнээр буюу түүний зарим хэсгийг Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дахин түрээслүүлсэн бол ______________ төгрөгийн торгууль төлнө.
2.3. Хадгалагч эд хөрөнгийг хадгалахаар хүлээн авмагц хадгалуулагчид агуулахын баримт олгоно. Агуулахын баримтад ( олгосон огноо, бүртгэлийн дугаар, гэрээний талуудын нэр хаяг, эд хөрөнгийг хадгалах газар, хадгалах эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт, хадгалалтын хөлс, бусад зайлшгүй зардлын хэмжээ, эд хөрөнгийг даатгах бол даатгалын үнэ, гэрээний хугацаа, хадгалагчийн гарын үсэг, тамга, тэмдэг) шаардлагатай зүйлийг заавал тусгана.

2.4. Хадгалуулагч агуулахын баримт бичгийн үндсэн дээр эд хөрөнгөө буцаан авах бөгөөд хадгалагч энэ баримтыг үндэслэн хадгалсан эд хөрөнгийг буцаан өгнө.

2.5. Хадгалуулагч хүсвэл эд хөрөнгө болон түүний баглаа боодлыг ломбодож болох бөгөөд энэ тохиолдолд ломбоны зураг, ломбодсон аргыг бичиж гэрээнд хавсаргана.

## 3. Талуудын эрх, үүрэг

3.1. Хадгалагч энэ гэрээний 1.4-д заасан хадгалах нөхцөлийг сахиж биелүүлнэ.

3.2. Хадгалуулагчийн төлөөлөгч эд хөрөнгөө үзэж, хянахын тулд хадгалсан газарт орох, бараагаа буцаан авах боломжоор хангах үүргийг хадгалагч тал хүлээнэ.

3.3. Эд хөрөнгийг хадгалж байх үед талуудын аль нэг нь эд хөрөнгө, түүний баглаа боодол, ломбо эвдэрч гэмтсэн, эсвэл үгүй болсныг илрүүлбэл энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Бараа үгүй болсон үед хоёр тал хамтран акт үйлдэж үгүй болсон эд хөрөнгө, түүний үнийг тогтоон тодорхойлно.

Хадгалагч эд хөрөнгө үгүй болсон тухай акт бичигдсэн өдрөөс хойш ___ хоногийн дотор уг үгүй болсноос болж учирсан хохирол, түүний дотор олох ёстой байсан орлогыг хадгалуулагчид төлж өгнө.

3.4. Хадгалагч эд хөрөнгөнд ямар нэгэн гаж буруу (эвгүй үнэр, радио идэвхийн нөлөөлөл г.м) байдал байгааг илрүүлбэл энэ тухай хадгалуулагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдсэн тухай баримтыг өөртөө авч үлдэнэ. Хэрэв

хадгалуулагч илэрч буй гаж буруу байдлыг арилгах боломжгүйн дээр хадгалагч шаардаж байгаа нөхцөлд дээрх мэдэгдлийг хүлээн авснаас хойш ….хоногийн дотор уг эд хөрөнгийг хадгалсан газраас зайлуулах үүрэг хүлээнэ. Энэ нөхцөлийг хадгалуулагч биелүүлэхгүй тохиолдолд хадгалагч дангаар уг эд хөрөнгийг хадгалсан газраас зайлуулж, энэ тухайгаа хадгалуулагчид мэдэгдэх эрхтэй. Ийм тохиолдолд гэрээ хүчингүй болсонд тооцогдох бөгөөд хадгалагч барааны бүрэн бус байдлын төлөө хариуцлага хүлээхгүй.

3.5. Иргэний хуулийн зүйл 429.6–429.10-т зааснаар хадгалагч зөвшөөрсөн бол хадгалуулагч агуулахын баримтыг бичилт хийж гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

3.6. Хэрэв хууль хяналтын болон захиргааны байгууллагаас хадгалалтад байгаа эд хөрөнгийн баглаа, лац , ломбо тогтоосон журам зөрчиж байгаатай холбогдуулан үзлэг, шалгалт хийх шаардлага тавьбал, хадгалагч энэ тухай хадгалуулагчид нэн даруй мэдэгдэнэ.

## 4. Тооцоо хийх журам

4.1. Хадгалуулагч эд хөрөнгийг хадгалуулсны хөлсөнд хадгалагчид ___________ төгрөгийн хөлс төлнө.

4.2. Төлөх хугацаа: _____ он ___ сар ____ өдөр

4.3. Төлбөр төлөх хэлбэр: Хадгалагчийн ___________________ банкны ________ салбар дахь ________________________ тоот дансанд шилжүүлэх эсвэл бэлнээр төлөх (доогуур нь зурах)

4.4. Энэ гэрээний 4.2-т заасан төлбөр төлөх хугацааг хожимдуулсан тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн _________ хувьтай тэнцэх алданги төлнө.( хоногт тооцох алдангийн хэмжээ 0,5 хувиас хэтрэхгүй байна)

4.5. Хадгалуулагч гэрээгээр тохирсон хугацаанд эд хөрөнгөө буцаан авах үед хадгалагчийн буруутайгаас эд хөрөнгөө авч чадаагүй хугацаа хожимдсон бол учирсан хохирлоо төлүүлэхээр шаардах эрхтэй.

4.6. Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр Иргэний хуулийн зүйл 429.17-т зааснаар хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

## 5. Давагдашгүй хүчин зүйл

5.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

5.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 6. Маргаан шийдвэрлэх

6.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Бусад нөхцөл

7.1. Хадгалалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, хугацаа тогтоогоогүй бол эд хөрөнгө хадгалуулахаар шилжүүлсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор хадгалагч эд хөрөнгөө буцаан авахыг хадгалуулагчаас шаардах эрхгүй.

7.2. Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын бичиг баримт эзэмшигч буюу хадгалуулагч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд 14 хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй.

7.3. Дээрх эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хадгалалтын явцад гарсан зайлшгүй зардал, хөлсийг хасаж, үлдсэн хэсгийг хадгалуулагчид шилжүүлнэ.

7.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх бөгөөд энэ нь бичгийн хэлбэрээр илэрхийлэгдэн гарсан байна.

7.5. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг 2 хувь үйлдэж, талууд нэг нэг хувийг хадгална.

## 8. Гэрээний хавсралт

8.1. Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

8.2. Хавсралт ¹ ____________________________________ хуудас.

8.3. Хавсралт ¹ ____________________________________ хуудас.

Хавсралтыг үйлдсэн ______ он ___ сар ___ өдөр

## 9. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

9.1. Хадгалуулагч талын :

Оршин байгаа газар: _________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: ______________ телетайп: __________________

Факс: ____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________________.

9.2. Хадгалагч талын:

Оршин байгаа газар: _____________________________________________________.

Хаяг, индекс: ___________________________________________________________.

Утас: ______________ телетайп: __________________

Факс: ____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________________.

9.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХАДГАЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХАДГАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ________________________________ | ________________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр                                        Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Иргэний хуулийн 380-398 дугаар зүйлд зааснаар ачаа тээвэрлэлтийн гэрээг дагалдах бичгийн хэлбэрээр байгуулна.

1.2. Дагалдах бичгийг гурван хувь үйлдэж, талууд гарын үсгээ зурж эхний хувийг ачаа илгээгчид үлдээж, хоёр дахь хувийг ачаанд хавсаргаж, гурав дахь хувийг тээвэрлэгчид өгнө.

1.3. Ачаа нь хэд хэдэн тээврийн хэрэгслээр, эсхүл өөр өөр төрөл буюу тодорхой хэсэгт хуваагдаж тээвэрлэгдэхээр бол тээвэрлэгч, ачаа илгээгч талууд ачааны төрөл, тээврийн хэрэгслийн тоогоор дагалдах бичиг үйлдэнэ.

1.4. Дагалдах бичиггүй, түүнийг дутагдалтай үйлдсэн, эсхүл үрэгдүүлсэн тохиолдолд Иргэний хуулийн 386 дугаар зүйлийн 4 дэх заалтыг баримтална.

1.5. Дагалдах бичгийг зарим тохиолдолд барааны зарлагын падаан, ачааг тээвэрлэлтэд хүлээлгэн өгсөн бусад баримтаар орлуулж болно.

### Хоёр. Тээврийн дагалдах бичиг

2.1. Дагалдах бичигт доорх зүйлийг тусгана:

2.1.1. үйлдсэн газар, он, сар, өдөр:

2.1.2. тээврийн хэрэгслийн нэр, төрөл, дугаар:

2.1.3. ачаа илгээгчийн нэр, хаяг: ______________________________________________

______________________________________________________________________

2.1.4. тээвэрлэгчийн нэр, хаяг: ______________________________________________

______________________________________________________________________

2.1.5. ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр, газар:______________________
ачааг хүргэх газар ____________________________________________________

______________________________________________________________________

2.1.6. Хүлээн авагчийн нэр, хаяг ____________________________________________

______________________________________________________________________

2.1.7. ачааны болон сав, баглаа, боодлын ердийн нэр, түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед түүний нийтээр хүлээн зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээ

______________________________________________________________________

______________________________________________________________________

______________________________________________________________________

2.1.8. тээвэрлэх ачааны тоо, хэмжээ, тэмдэг, дугаар:

______________________________________________________________________

______________________________________________________________________

______________________________________________________________

______________________________________________________________

2.1.9. ачааны жин буюу хэмжээний талаарх бусад тэмдэглэл:

______________________________________________________________

______________________________________________________________

2.1.10. тээвэрлэлттэй холбогдсон зардал (тээврийн хөлс, нэмэлт зардал, гаалийн хураамж ба гэрээ байгуулснаас ачааг хүргэх хүртэл гарах бусад зардал)

______________________________________________________________

______________________________________________________________

______________________________________________________________

2.1.11. бусад нөхцөл (тухайлбал, ачуулсан барааны нийт үнэ, тээвэрлэгчийн хариуцлагыг тодруулан зааж болно)

__________________________________________________________________

__________________________________________________________

2.2. Шаардлагатай гэж үзвэл талууд дагалдах бичигт дараах зүйлийг тусгаж болно:

2.2.1. ачааг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэх, ачихыг хориглосон заалт

2.2.2. тээвэрлүүлэгч хариуцах зардал

2.2.3. ачаа илгээх үед төлөх нэмэгдэл үнийн хэмжээ

2.2.4. ачааны өртөг, түүнийг дурдсан газарт хүргэх онцгой сонирхол

2.2.5. тээвэрлүүлэгчээс ачааг даатгуулах тухай тээвэрлэгчид өгсөн заалт

2.2.6. тээвэрлэлтийг дуусгахаар тохиролцсон хугацаа

2.2.7. тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт

## Гурав. Давагдашгүй хүчин зүйл

3.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

3.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## Дөрөв. Маргаан шийдвэрлэх

4.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

| **Тээвэрлэгч:** | **Ачаа илгээгч:** |
|---|---|
| *(Нэр)* | *(Нэр)* |
| Хаяг: ____________________________ | Хаяг: ____________________________ |
| ____________________________________ | ____________________________________ |
| ____________________________________ | ____________________________________ |
| Утас: ______________________________ | Утас: ______________________________ |
| Гарын үсэг:______________________ | Гарын үсэг:________________________ |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |

# ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭЭВЭР-ЭКСПЕДИТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ.

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр                                Улаанбаатар хот

Нэг талаас

_______________________________________________________

*(тээвэр-экспедиторын үйлчилгээ үзүүлж буй байгууллагын нэр)*

(цаашид "Ажил гүйцэтгэгч" гэнэ), түүнийг ____________ үндсэн дээр төлөөлөн

_________________________________________________________________

_____,

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

нөгөө талаас

___________________________________________________________

*(компани, үйлдвэр, байгууллагын нэр)*

(цаашид “Захиалагч” гэнэ), түүнийг _________________ үндсэн дээр төлөөлөн

_________________________________________________________________

_____,

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

бид дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний агуулга.

1.1 Энэхүү гэрээ нь Ажил гүйцэтгэгч Захиалагчийн даалгавар, түүний жагсаалтаар ачуулж буй гадаад худалдааны ачааг тээвэрлүүлэх болон тээвэр-экспедиторын үйлчилгээ үзүүлэхэд хоёр талын харилцааг зохицуулна.

1.2 Захиалагч гадаадад гаргах, гадаадаас оруулах ачаа бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, Монгол Улс болон бусад улсын нутаг дэвсгэр дээрх далайн ба гол мөрний боомт, Ажил гүйцэтгэгчийн бааз, тээвэр-экспедиторын төв, төмөр замын хилийн станц, авто замын зангилаа, Монгол болон бусад улсын нутаг дээрх олон улсын нисэх онгоцны буудал дээр тээвэр-экспедиторын үйлчилгээ хийх даалгаврыг Ажил гүйцэтгэгчид өгч, Ажил гүйцэтгэгч уг даалгаврыг хүлээн авч байна.

## 2. Талуудын үүрэг.

2.1 Ажил гүйцэтгэгчийн үүрэг:

2.1.1. Захиалагчийн захиалгаар гадаад худалдааны ачааг тээвэрлүүлэх болон түүнд тээвэр-экспедиторын үйлчилгээ үзүүлнэ.

2.1.2. Захиалагчид гадаад худалдааны ачааг тээвэрлүүлэхэд ашиглах тээврийн хэрэгслийн төрөл, явах маршрут, тээвэрлүүлэх арга, тээвэр-экспедиторын үйлчилгээ явуулах, баглаа боодол хийх, эдгээрийг зөв шийдвэрлэсэн үндсэн дээр тээвэрлэлтийн үр дүнг дээшлүүлэх, ачих, буулгах зардлыг

бууруулах, эдгээр асуудлаар гэрээний нөхцөлийг томьёолоход нь зөвлөлөө өгнө.

2.1.3. Захиалагчийн захиалгаар гадаадын фирмтэй байгуулах тээврийн гэрээний нөхцөлийг боловсруулна.

2.1.4. Гадаад худалдааны ачааг тээврийн төрөл бүрийн хэрэгслээр тээвэрлэх сар, улирал, жилийн төлөвлөгөөг боловсруулна.

2.1.5. Гадаад худалдааны ачааг тээвэрлэх сарын төлөвлөгөөний талаар бүх төрлийн тээвэрлэгч нартай, түүний дотор чингэлгийн, нэвтрүүлэн гаргах болон төмөр зам, усан тээвэр холилдсон тээврийнхэнтэй тогтоосон журмаар тохиролцож, Захиалагчид тээврийн сарын тохиролцсон төлөвлөгөөг гардуулна.

2.1.6. Гадаадад гаргах ачааг усан боомт, Ажил гүйцэтгэгчийн бааз, тээвэр-экспедиторын үйлчилгээний төв, төмөр замын нэвтрүүлэн гаргах болон дамжуулах станцуудад ачиж оруулах нэмэлт даалгаврын талаар холбогдох этгээдүүдтэй тохиролцож, тийнхүү ачиж оруулахаар тохиролцсон хэмжээг Захиалагчид мэдэгдэнэ.

2.1.7. Захиалагчийн тусгайлсан даалгавар, зардлаар түүнээс тогтоосон хугацаанд далайн боомтод барааг дахин баглаж боох, дахин шошго тэмдэг хийх, ачааг жинлэж хэмжих, барааны чанарыг тодорхойлох, загвар сонгон авах, баримт бичиг үйлдэх, ачааг зохих газар дээр нь хүлээлгэн өгөх болон гадаад худалдааны ачааг зөөхтэй холбогдсон бусад үйл ажиллагааг зохих байгууллагуудад захиалга өгөн зохион байгуулна.

2.1.8. Захиалагчийн даалгавар, түүний зардлаар усан боомт буюу бусад тээврийн байгууллагуудтай ачааг ачих, буулгах, агуулахад хадгалах, ачааг тээврийн янз бүрийн хэрэгслээр зөөх, тээвэрлэх, түүнчлэн ачааг төмөр зам дээр шууд хүргэж өгөхөөс бусад, тус гэрээний 2.1.7-д дурдсан үйлчилгээ үзүүлсний тооцоог хийнэ.

2.1.9. Захиалагчийн даалгавраар зохих зөвшөөрөгдсөн жагсаалтад дурдсан экспортын барааг боомтоос ачуулсан гадаадын пүүстэй тооцоо хийхэд шаардагдах баримт бичгийг үйлдэж, зохих банкны орон нутгийн байгууллагад банкны заавар, Захиалагчийн даалгаварт дурдсан хугацаанд өгнө.

2.1.10. Захиалагчийн даалгавар, зардлаар тээвэрлэлтийн болон барааг дагалдан явах, тэрчлэн тооцоо хийх баримт бичгүүдийг банканд, гадаадын пүүсэд тус тус явуулах бөгөөд барааг ачуулсан тухай гадаадын пүүст явуулах мэдээллийг даалгаварт заасан хугацаанд (төмөр зам дээр шууд хүргэсэн ачаа үүнд хамаарахгүй) өгнө.

2.1.11. Гадаад худалдааны ачааг боомт дээр зөөх, агуулахад оруулах, хадгалах ажлыг зөв зохистой гүйцэтгэж байгаа эсэхэд сонголтын журмаар хяналт хийнэ.

2.1.12. Ачааг усан боомтоор болон дамжуулан өнгөрүүлэх цэгүүд, автомашины замын зангилаагаар тээж өнгөрөх, тэрчлэн ачааг гадаадад гаргах ба гадаадаас оруулж ирэхээр Ажил гүйцэтгэгчийн тээвэр-экспедиторын төв (ТЭТ), бааз дээр ирэхэд шуурхай бүртгэл хөтөлнө.

2.1.13. Гадаадад гаргаж буй болон гадаадаас оруулж буй барааны талаар Захиалагчид баримт бичгүүдийг ямар хугацаанд явуулахыг жич бичгээр тохиролцон, түүнийг гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг ______-р хавсралт болгоно.

Шаардагдах бүх баримт бичгийг боомт буюу тээвэрлэгчээс цаг тухайд нь хүлээн авах арга хэмжээ авна.

2.1.14. Гадаад худалдааны барааг боомт дээр буулгах, зөөхтэй холбогдсон болон онгоц, вагонд ачаа ачих, буулгах ажил саатах, түүнчлэн ачаа хэвийн биш байдалтай ирсэн (сав, баглаа боодол нь задарсан, тээврийн баримт бичигтэй тулган үзэхэд ачааны тоо илүүдсэн (дутагдсан), норсон, гэмтсэн, баримт бичиггүй) үед акт үйлдэхэд Захиалагчийн төлөөлөгч оролцоно.

Боомтод орж ирсэн ачааны чингэлгийг задлах үед уул ачааны чанар байдлын талаар хяналт шинжилгээний акт тавиулахаар Захиалагчийн даалгавар, зардлаар шинжээч дуудна.

2.1.15. Шаардлагатай бол боомтод орж ирсэн ачаанд хортон шавьж устгах утлага хийх нь чухал болох тухай Захиалагчид мэдэгдэнэ.

Захиалагчийн даалгавар, зардлаар боомт дээр уг утлага хийхтэй холбогдсон ажлыг зохион байгуулах, тэрчлэн энэ ажлын зардал, хөлсийг төлөх, онгоцны жолоодох бүрэлдэхүүнийг байрлуулах, хооллох асуудлыг зохицуулна. Захиалагчийн даалгаврын үндсэн дээр тогтоосон журам ёсоор гадаад худалдааны ачааг хамгаалах, хорио цээр, ариун цэврийн дэглэмийг хэрэгжүүлэх (Захиалагчийн зардлаар) ажлыг хийнэ.

2.1.16. Захиалагчийн хүсэлтээр түүнд ачааны тээвэрлэлтийн үнэ тогтоон, тооцоо хийж төлбөр өгөхөд шаардагдах олон улсын хэмжээн дэх ачаа тээврийн үнэ тарифын хэмжээ, гадаадын боомт, хилийн станцууд дээр ачааг буулгах, зөөх, хураах, цэгцлэх зэргээр боловсруулалт хийхэд баримталж буй үнийн талаар мэдээлэл өгнө.

Захиалагчийн хүсэлтээр түүнд ачаа тээвэрлүүлэх нөхцөл, маршрут, тээвэрлэлтэд холбогдох баримт бичиг, тэрчлэн хилийн чанад дахь тээвэр-экспедиторын нөхцөл, түүний дотор тээвэрлэлтийн үнэ, ачаа дээр ажилласан, сав, баглаа боодол, шошго тэмдэг хийсэнтэй холбогдох зардлын талаар заавар, зөвлөгөө боловсруулна.

2.1.17. Захиалагчийн хүсэлтээр арбитрт асуудал оруулахад хэрэг болох тээвэрлэлтийн болон барааг дагалдах баримт бичгүүдийг (төмөр замаар шууд явсан ачааныхаас бусад) 30 хоногийн дотор ирүүлнэ.

2.1.18. Ачаа ачихад зориулан тээврийн хэрэгсэл тавих, ачаалах сарын график, сарын урьдчилсан төлөвлөгөө үйлдэнэ.

Тогтоосон журмаар тохиролцсон сарын график, сарын урьдчилсан төлөвлөгөөг тэдгээрт гарын үсэг зурснаас хойш 3 хоногийн дотор Захиалагчид явуулна.

Захиалагчийн даалгавраар ачаа ачих тоннаж (тэвш) байрлуулах графикт орох бүх нэмэлтийг холбогдох байгууллагатай тохиролцон боловсруулж, түүнийг Захиалагч, боомт дахь Ажил гүйцэтгэгчийн контор, хилийн чанадах Худалдааны төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

Ачаа тээвэрлэх графикийн биелэлтэд өдөр тутам хяналт тавьж, тэдгээрийг биелүүлэх арга хэмжээ авч, онгоц болон ачааг солих асуудлын талаар тогтоосон журмаар тохиролцож байна.

2.1.19. Тоннаж (тэвш) тавигдаагүй бол даалгавар (ордер)-ын бүртгэл хөтөлж, нэмэлт тоннаж (тэвш)-ийг графикт оруулан тавиулах арга хэмжээ авна.

2.1.20. Тогтоосон журмаар сарын график болон урьдчилсан төлөвлөгөөнд орох өөрчлөлтийн асуудлаар тохиролцоно. Энэ тухай Захиалагчид мэдэгдэнэ.

2.1.21. Далайн болон гол мөрний боомтод гадаад худалдааны ачаа дээр ажиллаж, тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээ хийх үед Захиалагчийн даалгавар биелүүлнэ. Үүнд:

a. Ачаа ачих газар (цэг) дээр гадаадад гаргах ачаа бүхий тээврийн хэрэгслийг байрлуулах, зохих этгээдэд захиалгын наряд (баримт хуудас) болон гадаадад гаргахаар ачуулах ачааны жагсаалтыг өгөх, тээврийн хэрэгсэлд ачаа байрлуулах төлөвлөгөө (усан онгоцонд бол Каргоплан) боловсруулахад оролцох;

b. Шаардлагатай үед ачааг дахин хэмжиж жинлэх, тээврийн хэрэгсэл нь гадаадад гаргах ачаа ачихад тохирох эсэхийг тодорхойлоход оролцох, Захиалагчийн даалгавраар гадаадад гаргах ачааг тээврийн хэрэгсэлд ачиж буй байдал, хураалт, ангилан ялгалт нь зөв болж буй эсэхэд хяналт тавих;

Захиалагчтай зөвшилцсөн үндсэн дээр ачааг ангилан ялгах, бэхлэх ажлын бэлтгэл зохих ёсоор болсныг батлах;

c. Ачаа ачих, буулгах газар (цэг) дээр гадаадаас оруулж ирсэн ачааг тээврийн хэрэгслээс буулгахад зохих журмаар зөвшилцөх бөгөөд энэ тухай Захиалагчид мэдэгдэнэ.

2.1.22. Зарим тохиолдолд Захиалагчийн хүсэлт, зардлаар ачаа ачих буулгах газар (цэг)-т оруулж ирсэн ачааг буулгуулахаар тээврийн хэрэгсэл орж ирсэн өдөр, тээврийн хэрэгслийн нэрийг Захиалагчид мэдэгдэнэ.

Тээврийн хэрэгсэл ирүүлэх сарын тохиролцоог өөрчилж, тээврийн хэрэгслийг солих үед Захиалагчийн өгсөн гүйцэтгэх даалгаврыг Ажил гүйцэтгэгчийн конторт хүргүүлнэ.

2.1.23. Захиалагчийн заалтаар гадаадад гаргах, гадаадаас орж ирсэн болон шууд төмөр замын зангилаа дээр авчирсан ачааг ачиж явуулах даалгаврыг Ажил гүйцэтгэгчид өгнө.

2.1.24. Ачааг ачих буулгах газар (цэг)-аас хүнд жинтэй болон овор багатай ачааны ноорог зураглалыг шилжүүлэн өгөх, ачаа ачих зураглал, бэхлэх тооцоог бэлтгэх үйл ажиллагаа тохиролцсон тээвэрлэлтийн нөхцөлд нийцэж буй эсэхийг тогтоосон журмаар хянана.

Ачаа ачих буулгах газар (цэг)-т гадаадаас оруулж ирэх овор багатай, хүнд жинтэй, урт хэмжээтэй ачааг ноорог зураглалгүй ирүүлбэл, түүнийг Захиалагчийн зардлаар нөхөн хийнэ.

2.1.25. Ачааг бэхлэх цэг, хэрэгслийг ачаа ачих газар (цэг) цаг тухайд нь бэлтгэж байгаа эсэх, тэрчлэн хөдлөх бүрэлдэхүүнийг цаг тухайд нь өгч буй эсэх, овор багатай, хүнд жинтэй, урт хэмжээтэй ачааг ачиж буй байдалд хяналт тавих;

2.1.26. Тээврийн хэрэгсэлд даац, багтаамжид нь ханатал ачаа ачаагүйн төлөө өгөх торгууль болон ачаанд тусгай бэхэлгээ хийсний төлөө өгөх төлбөр тооцоонд хяналт тавьж, зөв болохыг батална.

2.1.27. Захиалагчийн даалгавраар, түүний нэрийн өмнөөс ачаа тээвэрлүүлэх тухай холбогдох этгээдтэй гэрээ байгуулна.

2.1.28. Ачаа ачих, буулгах газар (цэг)-т гадаад худалдааны ачааг жил бүр, тэрчлэн сонголт хийх замаар тоолоход оролцох;

2.1.29. Ачааг ачих, буулгах газар (цэг) дээр тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээг олон улсын усан ба төмөр замын, тэрчлэн дамжуулан өнгөрүүлэх зангилаа дээр шууд тээвэрлэн авчирсан бараанд хийнэ.

2.1.30. Шаардлагатай тохиолдолд дамжуулан өнгөрүүлэх зангилаа дээр авчирсан ачаанд тээвэрлэлтийн ба барааг дагалдан явах бичиг баримтыг дахин үйлдэнэ.

Захиалагчийн захиалга нь ачааны тоо хэмжээ, явуулах чиглэл, хилийн станц, ачаа ачих буулгах газар (цэг)-ын талаар урьд тохиролцсон олон улсын хэмжээний тээвэрлэлтийн нөхцөл, тээвэрлэлтийн протоколтой тохирч буй эсэхэд хяналт тавина.

2.1.31. Захиалагчийн даалгавраар, түүний нэрийн өмнөөс төмөр замын хилийн станц дээрх тээвэрлэлт-экспедиторын конторуудтай тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээ хийлгэх гэрээ байгуулна.

2.1.32. Төмөр замын хэмжээнд зарласан, гадаадад гаргах ачааг тээвэрлэхтэй холбогдон тавигдсан хорио цээрийг бүртгэх, тэдгээрийн үйлчлэх хугацааг Захиалагчид цаг тухайд нь мэдэгдэнэ.

2.1.33. Ачааг гадаад улсын нутаг дэвсгэр дээр тээврийн төрөл бүрийн хэрэгслээр тээвэрлүүлэх болон, тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээ явуулах тухай гэрээг гадаад, дотоодын тээврийн ба тээвэрлэлт-экспедиторын байгууллагуудтай байгуулна.

2.1.34. Хилийн чанадах төмөр зам болон тээвэрлэлт-экспедиторын ачаа тээвэрлүүлсэн болон тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээ хийлгэсний төлөө пүүсүүдтэй хийх тооцоо, төлбөрийн явц байдалд хяналт тавьж, Ажил гүйцэтгэгчид төлөх төлбөрийн тооцоо ба олгох урамшлын тухай санал, тооцооны баримтыг Захиалагчид ирүүлнэ.

2.1.35. Гадаад худалдааны ачааг гадаадын төмөр замаар дамжуулан ачуулсны төлбөрийг зөв төлж буй эсэхэд хяналт тавьж, хэрэв төлбөрийн хэмжээ зөрүүтэй (илүү, дутуу) байгаа бол нэхэмжлэл гарган, дахин тооцоо хийх тухай мэдэгдлийг гадаадын төмөр замд хүргүүлэхээр дотоодын зохих байгууллагад өгнө.

2.1.36 Ачааг автомашинаар гадаадын нутаг дэвсгэр дээгүүр тээвэрлэсний төлөө төлбөрийг Захиалагч төлөх нөхцөлд, тэдгээр улсуудын тээврийн зохих байгууллагуудтай төвлөрсөн тооцоог хийнэ.

2.1.37. Автомашинаар тээвэрлэсэн ачаа хил нэвтэрснээс хойш ажлын нэг өдрийн дотор тийнхүү хил нэвтэрснийг Захиалагчид телекс буюу цахилгаанаар мэдэгдэнэ.

2.1.38. Тээвэр-экспедиторын үйлчилгээг олон улсын нисэх онгоцны буудлууд дээр үзүүлнэ. Энэ үед:

- Ачаа ирсэн тухай болон байгаа тухай, тэрчлэн түүний цаашдын хөдөлгөөний тухай мэдэгдэх;

- Гадаадад гаргах ачаанд зориулан тоннаж (тэвш)-ийг захиалан бэлтгэх;
- Тээвэрлэлтийн баримт бичгийг дахин үйлдэх зэрэг.

2.1.39. Захиалагчийн нэр дээр төмөр замын станцуудад гадаадаас ирсэн ачааг хүлээн авч, эзэнд нь хүргэж өгнө.

2.1.40. Улирлын (сарын хуваарьтай) нарийвчилсан захиалгын үндсэн дээр гадаадаас орж ирэх ачааг Ажил гүйцэтгэгчийн ТЭТ болон баазаас ачих вагоныг төлөвлөн бэлтгэнэ.

2.1.41. Дотоодын замд явж байгаа гадаадын хоосон чингэлгүүдийг гадаад худалдааны ачааг тээвэрлэхэд ашиглана.

2.1.42. Захиалагчид зориулан ТЭТ-д болон баазын хаягаар далайн болон гол мөрний усан онгоц, автомашин, вагоноор ирсэн гадаад худалдааны барааг хүлээн авах, нэгтгэн бөөгнөрүүлэх (концентрация), хадгалах, буулгаж зөөх, тордож янзлах, цаашид ачуулах болон тээвэрлэлт-экспедиторын боловсруулалт хийнэ.

Захиалагчийн даалгавар, зардлаар ТЭТ болон бааз дээр ачааг задалж шалгах, задалж шалгасан ачааг гадаадад гаргахад саадгүй болгон янзлах, барааг чанарын талаар (шинжээчийг оролцуулан) шалган хүлээж авах, дээж, загвар авах, хорио цээрийн болон ариун цэвэр, утах, цэвэршүүлэх ажлыг зохих байгууллагуудад захиалга өгч гүйцэтгүүлнэ.

2.1.43. Талуудын тохиролцооны үндсэн дээр энэ гэрээнд дурдсан журмаар Захиалагчийн бусад даалгаврыг түүний зардлаар гүйцэтгэж болно.

2.2 Захиалагчийн үүрэг:

2.2.1 Төмөр замын хилийн станцууд дээрх Ажил гүйцэтгэгчийн удирдлагад буюу тээвэр-экспедиторын конторт тээвэр-экспедиторын ажиллагаа явуулах болон гэрээ байгуулах эрхийн итгэмжлэх бичиг олгох.

2.2.2 Захиалагч тээвэрлэлтийн ажлын шаардлагаас үндэслэн Ажил гүйцэтгэгчид маш тодорхой захиалга, даалгавар, төлөвлөгөө, эдгээртэй адилтгах бусад баримт бичгийг тодорхой цагт өгч байх гол үүрэгтэй бөгөөд чухам ямар захиалга, даалгавар, төлөвлөгөө, бусад баримт бичгийг ямар хугацаанд, хэнд өгөхийг Талууд жич бичгээр нарийвчлан тогтоож, энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг (__-р хавсралт) болгоно.

2.2.3 Ажил гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр ТЭТ болон баазад бараа оруулахгүй.

2.2.4 Хэрэв захиалга нь Ажил гүйцэтгэгчийн баталсан гадаадад гаргах ачааны сарын төлөвлөгөөнөөс хэтэрсэн, вагон сул зогссон бол Захиалагч ТЭТ буюу баазад хэмжээ хэтрүүлэн вагон сул зогсоосноос учирсан жинхэнэ хохирлыг төлж өгнө.

2.2.5 Гадаад худалдааны ачааг ачуулах даалгавар өгсөн аргаас (шуудангаар, телексээр, цахилгаанаар) хамаарахгүйгээр түүнийг Захиалагч зохих нэгдсэн хэлбэрээр өгнө.

2.2.6 Хэрэв Захиалагч ачааг ачуулах (хүлээн авах)-д бэлтгэх, тээвэрлэлтийн баримт бичгийг үйлдэх боломж хангахуйц чухал мэдээлэлгүй даалгавар болон даалгавар-паданыг ирүүлсэн бол, тэдгээрийг Ажил гүйцэтгэгчийн ТЭТ буюу бааз, конторт хүлээн аваагүйд тооцох бөгөөд харин энэ тухайг Захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

2.2.7 Хилийн ТЭТ буюу төмөр замын хилийн станцын даргад Олон улсын төмөр замын зангилаанд ачаа хүргүүлэх тухай даалгавар буюу даалгавар-падааныг бичгээр болон цахилгаан (телекс)-аар өгч болно.

2.2.8 Ажил гүйцэтгэгчийн ТЭТ болон конторт гадаадад гаргах ачаа ачуулсны төлөө гадаадын пүүсүүдтэй тооцоо хийх тухай зааварчлахыг цаг тухайд нь өгнө.

Ажил гүйцэтгэгчид өгсөн даалгавар, гүйцэтгэсэн ажилд зохицсон хөлсийг цаг тухайд нь тогтоосон журмаар олгоно.

2.2.9 Ажил гүйцэтгэгчийн зөвлөснөөр Гадаадын худалдан авагч (худалдагч) пүүсүүдтэй байгуулах гэрээнд гадаад улсын нутаг дэвсгэр дээр тээвэрлүүлсэн, гадаадад гаргасан, мөн гадаадаас оруулах ачааны техник-эдийн засгийн үндэслэлийг Ажил гүйцэтгэгч, тээвэрлэлт-экспедиторын пүүс, баглаа боодлын болон бусад пүүсүүдтэй хамтран тусгана.

2.2.10 Ажил гүйцэтгэгчтэй хамтран гадаадын пүүсүүдтэй байгуулах худалдах, худалдан авах тухай гэрээний тээвэрлэлтийн нөхцөлийг боловсруулж тусгана.

2.2.11 Тээвэрлүүлэх ачаанд Улсын стандарт болон тээврийн байгууллагатай хийсэн тохиролцоонд нийцүүлэн, тээвэрлэлтийн замд, тэрчлэн буудлууд дээр ачих буулгах үед ачааг гэмтэж муудахаас хамгаалж чадах баглаа боодол хийнэ.

2.2.12 Онцгой нөхцөл шаардах болон тээвэрлэлтийн дүрэмд тусгайлан заагаагүй гадаад худалдааны болон дамжин өнгөрөх тодорхой төрлийн ачаанд ТЭЧ хийх, ачих, буулгах, хадгалах, тээвэрлэх тусгай зааварчлахыг Ажил гүйцэтгэгчийн ТЭТ, бааз, конторт өгнө.

2.2.13 Гадаадад гаргах болон гадаадаас оруулах ачааг гадаадын хилийн төмөр зам, усан боомт, (газар) цэгт нэвтрүүлэх зөвшөөрөл, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн гэрчилгээ болон бусад ачааг дагалдан явах баримт бичиг, аюул осол бүхий ачааг тээвэрлүүлсэн бол тэдгээрийн ангиллыг заасан баримт бичгийг цаг тухайд нь өгч, уул ачааг төлөвлөсөн хугацаандаа хүрч ирэх боломжийг хангана.

2.2.14 Ажил гүйцэтгэгчийн ТЭТ, бааз, конторт тодорхой даалгаврыг биелүүлэхтэй холбогдон гарсан зардал, тэрчлэн ачаатай холбогдуулан гадаадын пүүсэд явуулсан баримт бичгийг хилийн чанадад шуудангаар хүргүүлэх болон телекс (цахилгаан)-ээр мэдээлэл өгөхөд гарсан зардлыг төлж өгнө.

2.2.15 Ажил гүйцэтгэгчид ачааг тээвэрлүүлэх, ТЭЧ хийлгэх, тэрчлэн Захиалагчид өгөхөөр усан боомт, Ажил гүйцэтгэгчийн ТЭТ, баазад ирсэн ачааг хүлээн авахад гаргасан зардлыг төлж өгөхөөс гадна мөн Комиссын ажиллагаа хийсний төлөө шагналыг ______________________________ хэмжээгээр төлж өгнө.

## *3.* Тооцоо хийх журам.

3.1. Захиалагч тээврийн бүх төрлийн хэрэгслээр ачаа тээвэрлэхэд гарсан зардал, түүний дотор гадаадын валютыг, Ажил гүйцэтгэгчээс өгсөн тээвэрлэгч, экспедиторуудын төлбөрийн баримтуудыг хавсаргасан тооцоог үндэслэн төлнө.

Төлбөрийг Ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл өгснөөр тогтоосон журмаар гүйцэтгэнэ.

3.2. Гадаад худалдааны ачааг тээвэрлэсэн, ТЭЧ хийсний үнийн хэмжээг энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох _______ хавсралтад заасан тариф, хэмжээгээр тогтооно.

3.3. Захиалагч төлбөрийг үйлчилгээ үзүүлсэн Ажил гүйцэтгэгчийн байгууллагад шууд төлнө.

## 4. Талуудын хариуцлага.

4.1. Ерөнхий байдал:

4.1.1 Талууд хууль тогтоомжид нийцсэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээнэ.

4.1.2 4.1.2. Аль ч тал нөгөө талдаа бүхий л бололцоогоор дэмжлэг үзүүлэн, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлнэ.

4.1.3 4.1.3. Гэрээний үүргээ зөрчсөн тал уг зөрчлийг нэн даруй арилгана.

4.1.4 4.1.4. Энэ гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлсэн тал, хэрэв уг этгээд үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн төлөө нөгөө талын өмнө хариуцлага хүлээнэ.

4.1.5 4.1.5. Талууд хэрэв давагдашгүй хүчний улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

4.2. Ажил гүйцэтгэгчийн хариуцлага:

4.2.1 Ажил гүйцэтгэгч буюу түүний орон нутгийн байгууллага Захиалагчид хохирол учруулсан дор дурдсан нөхцөлд хариуцлага хүлээнэ:

a) Захиалагчаас Ажил гүйцэтгэгчид түр хадгалуулахаар шилжүүлэн өгсөн ачааг өөрийн буруугаас үрэгдүүлсэн буюу гэмтээсэн;

b) Ажил гүйцэтгэгчийн агуулахад ачааг зохих ёсоор хадгалаагүйгээс чанарыг нь дордуулсан бол.

4.2.2 Ажил гүйцэтгэгч дор дурдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй:

a) Тээврийн хэрэгсэл дээр гарсан ашиглан шамшигдуулах гэмт хэргээс болон сав, баглаа боодол бүтэн байгаа ачааг задлан тоолоход дутагдал гарч, хохирол учирсан тохиолдолд;

b) Тээвэрлэлтийн баримт бичгийг зохих ёсоор бүрдүүлсэн байхад ачаа тээвэрлэх хугацаа зөрчигдсөн үед.

4.2.3 Ажил гүйцэтгэгч ачаа гэмтээсэн, дутагдуулсан бол, тэрхүү ачааны үнийн хэмжээгээр хариуцлага хүлээх боловч, нэг килограмм ачаанд _______________________________________ төгрөгөөс илүүгүй хэмжээгээр төлбөр төлнө.

4.2.4 4.2.4. Хэрэв Ажил гүйцэтгэгч энэ гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн хариуцлага нь түүний үйлчилгээ үзүүлсний төлөө авсан (авах) шагналын хэмжээгээр хязгаарлагдана.

4.3. Захиалагчийн хариуцлага:

Захиалагч Ажил гүйцэтгэгчид учруулсан хохирлыг төлж өгнө. үүнд:

a) Энэ гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлээгүй бол;
b) Тээвэрлүүлэх ачааны тухай зохих журмаар мэдээлээгүй бол тээврийн байгууллагын шаардлагаар ________________________________________ хэмжээний торгууль;
c) Тээврийн хэрэгслийг сул зогсоосон бол тээврийн байгууллагын нэхэмжлэлээр ________________________________ хэмжээний торгууль;
d) Ажил гүйцэтгэгчид төлбөр өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан буюу түүнийг цаг тухайд нь өгөөгүй бол.

## 5. Нэхэмжлэх.

5.1. Энэ гэрээтэй холбогдсон нэхэмжлэхийг уг нэхэмжлэх гаргах үндэслэл бий болсноос хойш 2 сарын дотор гаргана.

5.2. Нэхэмжлэх явуулсан захидлыг шуудангийн байгууллага хүлээн авч, тэмдгээ дарсан өдрийг нэхэмжлэл гаргасан өдөр гэж үзнэ.

5.3. Нэхэмжлэх хүлээн авсан тал тийнхүү хүлээн авснаас хойш 1 сарын дотор түүнийг хянан үзэж, тодорхой хариу (нэхэмжлэлийг бүрэн буюу зарим хэсгийг зөвшөөрөх, эсвэл бүрэн буюу зарим хэсгийг эс зөвшөөрөх) өгнө.

5.4. Талууд хэрэв нэхэмжлэх мөнгөний хэмжээ ________________________________ ________________________________ төгрөгөөс хэтрэхгүй бол харилцан нэхэмжлэхгүй.

5.5. Ажил гүйцэтгэгчид хандаж гаргасан нэхэмжлэхийг тээвэрлэлт-экспедиторын үйлчилгээ шууд үзүүлсэн байгууллага хянан үзнэ.

## 6. Маргааныг хянан шийдвэрлэх журам.

6.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Бусад нөхцөл.

7.1. Энэ гэрээ нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, ________ ________________________________ хүртэл үйлчлэх болно.

7.2. Хэрэв Талууд гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө нөгөө талдаа уг гэрээг цуцлах хүсэлтээ бичгээр гаргаагүй бол, гэрээний үйлчлэх хугацааг урьдын гэрээний хугацаагаар сунгасанд тооцно.

7.3. Энэ гэрээнд зөвхөн Талуудын эрх бүхий төлөөлөгчдийн гарын үсэг зурсан бичгийн тохиролцооны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулна.

## 8. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

8.1. Ажил гүйцэтгэгч талын :

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: __________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

8.2. Захиалагч талын:

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: __________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: _________________________________.

8.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# ДААТГАЛЫН ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас "Даатгагч" ______________________________________________

*(даатгалын байгууллагын нэр)*

түүнийг ______________________________ үндсэн дээр төлөөлөн

__________________________________________________________________

*(албан тушаал, овог нэр)*

Нөгөө талаас "Даатгуулагч" _____________________________________________

*(даатгуулагч үйлдвэрийн нэр эсвэл гэрээ байгуулагч иргэний овог нэр)*

түүнийг ___________________________________ үндсэн дээр төлөөлөн

__________________________________________________________________

*(албан тушаал, овог нэр)*

бид Монгол Улсын Иргэний хуулийн 431-444 дүгээр зүйлд заасныг үндэслэн дор дурдсан гэрээ байгуулав. Үүнд:

## 1. Нийтлэг үндэслэл.

1.1. Даатгуулагч нь өөрийн

_________________________________________________________________

*(үнэ бүхий машин техник, тоног төхөөрөмж зэргийн нэрийг бичих)*

тэрчлэн гуравдах этгээдийн өмнө хүлээх хариуцлага (цаашид хариуцлага гэнэ)-ыг заавал даатгуулах, Даатгагч нь уг даатгалыг хийх үүрэг хүлээв.

1.2. Даатгагч,Даатгуулагч нь Монгол Улсын даатгалын үйл ажиллагаанд удирдлага болгох хууль тогтоомж, бусад баримт бичгийн (тэдгээрийн нэрийг бичих) заалтыг мөрдлөг болгоно.

## 2. Даатгуулагчийн үүрэг.

2.1 Даатгуулах эд зүйл, хариуцлагын даатгалын тодорхойлолтыг зохих журмын дагуу үйлдэж гэрээнд хавсаргав (1-р хавсралт).

2.2 Даатгалын хураамжийг ____ оны __-р сарын __-ны өдрийн дотор Даатгагчид төлнө.

2.3 Даатгалтай агаарын хөлгийн талаар Даатгагчаас шаардсан мэдээ материалыг цаг тухайд нь гаргаж өгнө.

## 3. Даатгуулагчийн эрх.

3.1. Даатгалтай эд зүйл, гуравдах этгээдэд учирсан хохирлыг тогтоосон хугацааны дотор нөхүүлэх, энэ талаар нэхэмжлэх, шаардах.

3.2. Даатгалын нөхцөл, үнэлгээ, хураамжийн хувь хэмжээний талаар нэмэгдэл тодруулалт шаардах.

### 4. Даатгагчийн үүрэг.

4.1 Даатгалтай эд зүйл, гуравдах этгээдэд учирсан хохирлыг холбогдох акт материалыг бүрдүүлж ирүүлснээс хойш 30 хоногийн дотор Даатгуулагчид нөхөн олгоно.

### 5. Даатгагчийн эрх.

5.1. Гарсан хохирлыг газар дээр нь шалгах, эрх бүхий комиссоос хохирол гарсан шалтгаан, түүний хэмжээг тогтооход оролцох.
5.2. Даатгалтай холбогдсон мэдээ материал шаардах.
5.3. Зохих үндэслэл байвал тогтоосон журмын дагуу хохирлыг нөхөхөөс бүрэн буюу зарим хэмжээгээр татгалзах.

### 6. Үнэлгээ, хураамж.

6.1. Даатгуулах эд зүйл, хариуцлагын үнэлгээ, хураамжийн хэмжээ.

| *1* | *үнэлгээ* | *Хураамжийн* | |
|---|---|---|---|
| | | *Хувь* | *дүн* |
| *1.* | | | |
| *2.* | | | |
| *3.* | | | |

6.2. Даатгуулагчийн өөрөө хүлээх хариуцлагын хэмжээ.
a. Даатгуулсан эд зүйл тус бүрээр:

| *1* | *Нэр* | *Дүн* |
|---|---|---|
| *1.* | | *ам.доллар (төгрөг)* |
| *2.* | | *ам.доллар (төгрөг)* |
| *3.* | | *ам.доллар (төгрөг)* |

b. Даатгуулагчийн өөрөө хүлээх хариуцлагын хэмжээг тусгай нөхцөлөөр даатгав.Үүнд:
_______________________________________________________________.

6.3. Хариуцлагын даатгалын нэг удаагийн тохиолдлоор даатгагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээ:

| 1 | *Нэг удаагийн тохиолдлоор* | *Даатгуулсан тодорхой эд зүйлийн нэр* | *Дүн* |
|---|---|---|---|
| *1.* | *Нийт дүнгээр* | | *ам.доллар (төгрөг)* |
| *2.* | *Холбогдох нэгжийн тоог ачих* | | *ам.доллар (төгрөг)* |
| *3.* | | | *ам.доллар (төгрөг)* |

## 7. Маргааныг шийдвэрлэх

7.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 8. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

8.1. Даатгагч талын :

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: ________________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

8.2. Даатгуулагч талын:

Паспортын дугаар_____________ Регистрийн дугаар______________

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: ________________________________________________.

Утас: ______________ телетайп: _________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

8.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

ДААТГУУЛАГЧ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

**ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД АЧАА ТЭЭВРИЙН ШУУРХАЙ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр                    Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________________

*(мэдээллээр хангах байгууллагын нэр)*

/цаашид "Гүйцэтгэгч тал” гэнэ/, түүнийг____________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

______________________________________________________________

*(Компани, Үйлдвэр, байгууллагын нэр)*

/цаашид “Захиалагч тал” гэнэ/, түүнийг _______________ үндсэн дээр төлөөлөн

(итгэмжлэл)

______________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

**1.Гэрээний агуулга ба Талуудын үүрэг**

1.1. Гүйцэтгэгч Захиалагчийн хүсэлтээр түүнийг Олон Улсын хэмжээнд ачаа тээвэрлэлтийн үнийн тухай мэдээлэл өгөх, тэрчлэн энэ гэрээнд нийцсэн бусад үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээнэ.

Энэ зорилгоор:

1.1. Гүйцэтгэгчийн үүрэг:

1.1.1. Захиалагчид дараах мэдээлэл өгнө:

а) Хилийн цаана үйлчилж буй тарифаар олон улсын хэмжээнд төрөл бүрийн тээврийн хэрэгслээр ачаа тээхэд төлж буй үнийн хэмжээ;

б) дотоодын болон гадаадын усан буудлууд, хил нэвтрэх уулзваруудад ачаа боловсруулах (ачаа буулгах, зөөх, хураах) үнэ, тэрчлэн энэ үйл ажиллагаанд баримтлах дүрэм, зан заншил;

в) Гадаадад гаргах, гадаадаас оруулах ачааны даатгалын шагналын тариф.

1.1.2. Гадаад худалдааны хэлцлийн тээвэрлэлтийн нөхцлийн талаар зөвлөлгөө өгөх.

1.1.3.Талуудын тохиролцсоноор бусад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

1.1.4.Мэдээллийг Захиалагчийн шаардлагаар ямар нэгэн хэлбэрээр. дараах хугацаанд өгнө:

а) амаар тавьсан асуултанд тэр өдөр нь;

б) бичгээр тавьсан асуултанд 5 хоногийн дотор;

в) хэрэв Гүйцэтгэгч зохих мэдээлэл авахын тулд гадаад орны тээвэрлэгч, агент, төлөөлөгчийн газарт хандах шаардлагатай асуултад 15 хоногийн дотор.

1.1.5. Асуулт тавих телефон утасны дугаар:

а) ________________________________________ далайн тээврийн:

б) төмөр замын тээврийн: _________________

в) автомашины, гол мөрний, агаарын тээврийн:____________________________________________________________

1.2. Захиалагчийн үүрэг:

1.2.1. Гүйцэтгэгчээс хүлээн авсан мэдээллийг зөвхөн өөрийн зорилгод ашиглах бөгөөд уг мэдээллийг Гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад тараах эрхгүй.

## 2.Тооцооны болон бусад нөхцөл

2.1 Захиалагч энэ гэрээний 1-р бүлэгт дурьдсан үйлчилгээ үзүүлсний төлөө Гүйцэтгэгчид_______ төгрөгийг доорхи журмаар төлнө.

а)гэрээ байгуулснаас хойш ______________________хоногийн дотор урьдчилгаанд____________________________________________________ төгрөг;

б)_________________ үлдсэн мөнгийг сарын туршид сар бүрд ижил хэмжээгээр;

в) Хэрэв Захиалагч төлбөрийн хугацаа хожимдуулбал,, тийщүү хугацаа; хожимдуулсан төлбөрийн дүнгийн_______хувийн хэмжээгээр алдангийг Ажил гүйцэтгэгчид нэмэн төлнө

2.2 Хэрэв Захиалагч энэ гэрээний 2.1-д дурьдсан төлбөрийг зохих хугацаанд мь өгөхгүй бол, Гүйцэтгэгч мэдээллийн үйлчилгээ үзүүлэх ажлын төлбөр хийсэн тухай мэдээг хүлээн авах хүртэл зогсооно.

2.3 Энэ гэрээ Талууд гарын үсэг зурмаил хүчин төгөлдөр болох бөгөөд ________ сарын турш үилчлэх болно Хэрэв Талуудын аль нэг гэрээнээс татгалзахаа илэрхийлээгүй бол уг гэрээг дараачийн ________сард үйлчлүүлэхээр хугацаа сунгасанд тооцно.

2.4. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

2.5 Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдсэн бөгөөд нэгийг Захиалагч, нөгөөг Гүйцэтгэгч тус тус хадгалав.

### 3. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

3.1 А талын :

Оршин байгаа газар: ________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________.

Утас: ____________ телетайп: ______________

Факс: ________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.

3.2 Б талын:

Оршин байгаа газар: ________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________.

Утас: ____________ телетайп: ______________

Факс: ________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________.

3.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

### 4. Маргаан шийдвэрлэх журам

4.1 Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцох замаар эвийн журмаар шийдвэрлэнэ.

4.2 Хэрэв Талууд аливаа маргаантай асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд уг маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

__________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

__________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

**ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар___

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас
____________________________________________________________ /
*үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, хаяг/*
/цаашид "Захиалагч" гэнэ /, түүнийг__________________________________үндсэн дээр
төлөөлөн
______________________________________________________________________
__ */ төлөөлсөн хүний албан тушаал, нэр /*
Нөгөө
талаас____________________________________________________________ /
*байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг /*
/цаашид "Гүйцэтгэгч" гэнэ /, түүнийг_________________________________үндсэн дээр
төлөөлөн
______________________________________________________________________
__ */төлөөлсөн хүний албан тушаал, нэр/*
нар дор дурдсан гэрээг байгуулав.

## 1. Гэрээний зүйл

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчид _______________энэ гэрээний хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч болон гэрээ байгуулагч бусад этгээдийг сонгон авах, тэдэнтэй гэрээ байгуулах талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх үүргийг хүлээнэ.

1.2. Гүйцэтгэгч, захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд тохиролцож болох гэрээний нөхцөл болон уг тохиролцооны томьёоллыг боловсруулан бэлтгэнэ.

1.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үйлчилгээ үзүүлсний нь төлөө захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчийн хооронд байгуулсан гэрээний үнийн _____хувьтай тэнцэх хэмжээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## 2. **Гүйцэтгэгчийн үүрэг**

2.1. Энэ гэрээний хавсралтад дурдсан байгаа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх/ худалдан авах / боломж бүхий гэрээ байгуулагчдыг олохын тулд зах зээлд судалгаа явуулах

2.2. Захиалагч ба гэрээ байгуулагчдын хооронд төлөөлөгчдийн хооронд уулзалт, хэлэлцээр зохион байгуулах

2.3. Захиалагч гэрээ байгуулагчдын хооронд харилцан ашигтай гэрээ байгуулахад

дэмжлэг үзүүлэх

2.4. Захиалагчийн байгуулж буй гэрээтэй холбогдох эрх зүй болон худалдааны асуудлаар зөвлөгөө өгөх

2.5. Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс түүнтэй хамтран үйлдвэр, хоршоо байгуулах, сонирхол бүхий үйлдвэр, түүний дотор гадаадын үйлдвэр олох, эдгээр асуудлаар захиалагч гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх.

## 3. Захиалагчийн үүрэг

3.1. Захиалагч ба түүнтэй гэрээ байгуулагчдын хооронд зохих гэрээ байгуулагдсанаас хойш  хоногийн дотор гүйцэтгэгчид зохих хэмжээний шагнал олгоно.

3.2. Чухал тохиолдолд өөрийн төлөөлөгчдийг гүйцэтгэгчээс гэрээ байгуулагч талтай хэлэлцээр хийхэд оролцуулах, гүйцэтгэгчийг мөн техникийн ба худалдааны зохих материалаар хангах;

3.3. Гүйцэтгэгчид түүний энэ гэрээнд заасны дагуу санал болгосон талтай байгуулсан гэрээний хуулбарыг өгөх.

## 4. Ажиллах нөхцөл

4.1. Талууд ажиллахдаа гэрээний агуулгад дурдсан асуудлаар бие биедээ өгсөн үнэлэлт, зөвлөмжийг анхааралдаа авна.

4.2. Талууд шаардлагатай арга хэмжээг авхуулах зорилтын үүднээс гүйцэтгэхэд саад болж буй бэрхшээлийн тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ.

4.3. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хагас, эсвэл зохих хугацаанд биелүүлж чадахгүй бол талууд энэ тухай бие биедээ бичгээр мэдэгдэнэ.

4.4. Хэрэв Захиалагч үндэслэлгүйгээр энэ гэрээг биелүүлэхийг зогсоовол үүнээс болж гүйцэтгэгчид учирсан хохирлыг төлж өгнө. Гүйцэтгэгч өөрийн буруугаар гэрээнд заасан үүргээ биелүүлж чадаагүй бол үүнээс болж өөрт учирсан хохирлыг төлүүлэхээр бусдаас нэхэмжлэх эрхгүй.

4.5. Захиалагч зохих талтай гэрээ байгуулж, гарын үсэг зурмагц энэ гэрээнд дурдсан ажлыг бүрэн биелэгдсэнд тооцно.

4.6. Энэ гэрээний нэгдүгээр хавсралтад дурдсан зүйлийг захиалагчаас гүйцэтгэгчид өгсөн захиалгын үндсэн дээр тогтоосон журмын дагуу хянан үзэж нарийвчлан тогтооно.

4.7. Энэ гэрээний үүргийг биелүүлэх явцад гүйцэтгэгч захиалагчийн төлөөлөгчийн нэгэн адил ажиллана. Гүйцэтгэгч энэ гэрээний хүрээнд захиалагчийн итгэмжлэх бичиггүйгээр захиалагчийн ашиг сонирхлын үүднээс, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх, бусад ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд харин захиалагчийн нэрийн өмнөөс гэрээнд гарын үсэг зурах эрхгүй байна.

## 5. Нууцыг хадгалах

5.1. Талууд энэ гэрээний дагуу хүлээн авсан мэдээлэл, баримт бичгийн нууцыг чанд хадгална.

5.2. Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын чанартай мэдээлэл, баримт бичигтэй захиалагч, гүйцэтгэгч зөвхөн гэрээний дагуу хийж байгаа ажилтай шууд холбоо бүхий хүмүүс танилцана.

## 6. Тооцооны журам

6.1. Захиалагч үйлчилгээ хийсний төлөө гүйцэтгэгчид өгөх төлбөрийг гүйцэтгэгчийн харилцах дансанд шилжүүлэх журмаар төлнө.

## 7. Хариуцлага

7.1. Захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

7.2. Гүйцэтгэгч нь захиалагчийн бусадтай байгуулсан гэрээг бүрэн биелүүлээгүйтэй холбогдох хариуцлагыг хүлээхгүй.

## 8. Давагдашгүй хүчин зүйл

8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт /-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

8.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 9. Маргаан шийдвэрлэх

9.1. Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

9.2. Хэрэв талууд хамтран шийдвэрлэж чадахгүй тохиолдолд гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 10. Бусад заалт

10.1. Энэ гэрээний дагуу хийсэн ажлыг шаардлагатай гэж үзвэл талуудын хамтран үйлдсэн акт (протокол) болон үйлчилгээ үзүүлсэн тухай бусад баримт бичигт тусган тодорхойлно.

10.2. Талуудын гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелсэн, харилцан хийх тооцоог зохицуулж дууссан нөхцөлд гэрээг биелж дууссанд тооцно.

10.3. Гэрээнд талууд гарын үсэг зурмагц хүчин төгөлдөр болно.

10.4. Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

## 11. Талуудын хууль ёсны хаягийн мэдээлэл

Түрээслүүлэгч:

Хаяг:________________________________________________________________

Утас:________________________________________________

Факс:________

Түрээслэгч:

Хаяг:________________________________________________________________

Утас:________________________________________________

Факс:________

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Түрээслүүлэгч: | Түрээслэгч: |
| --- | --- |
| __________________________ | ______________________ |
| /гарын үсэг/ | /гарын үсэг/ |
| тэмдэг | тэмдэг |

***ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ***

# АГЕНТЫН ГЭРЭЭ

Дугаар __

___ оны __ дугаар сарын __-ний өдөр Улаанбаатар хот

Нэг талаас
______________________________________________________________

*(гадаадын оролцогчийн нэр)*

(цаашид "Компани" гэнэ), түүнийг ____________________ үндсэн дээр төлөөлөн
_____________________________________________________________,

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

Нөгөө талаас
______________________________________________________________

*(Монголын оролцогчийн нэр)*

(цаашид “Агент” гэнэ), түүнийг _______________________ үндсэн дээр төлөөлөн
______________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

бид дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний агуулга.

1.1. Компани Агентад зах зээл болон компанийн (Энэ гэрээний хавсралтад дурдсан) бүтээгдэхүүнийг борлуулах боломжийг Монгол Улсын зохих нутаг дэвсгэр дээр (цаашид орон нутаг гэнэ) судлах талаар онцгой биш эрх олгоно.

## 2. Агентын үүрэг.

2.1. Энэ гэрээний агуулгатай нийцүүлэн Агент дор дурдсан үүрэг хүлээнэ:

2.1.1. Компанийн бүтээгдэхүүнийг борлуулахад компаниас өгсөн сурталчлах, танилцуулах материалыг ашиглан зохих дэмжлэг үзүүлэх, тэрчлэн компанийг Монгол улсын орон нутагт бүтээгдэхүүнээ худалдах гэрээ байгуулахад идэвхтэй туслалцаа үзүүлэх;

2.1.2. Орон нутагт компанийн бүтээгдэхүүнийг захиалах чадамж бүхий захиалагчийг эрж олох зорилгоор судалгаа хийх;

2.1.3. Чадамж бүхий захиалагчид тэдний төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах зөвшөөрөл буй эсэх, тэдний төлбөрийн чадвар ямар болоход судалгаа хийх;

2.1.4. Компанийн бүтээгдэхүүнтэй холбогдох сурталчлах материалыг тараах, бүтээгдэхүүнийг байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.1.5. Компанид хэлцэл хийх нь чухал болсон тухай мэдэгдэх;

2.1.6. Компани, Захиалагчийн төлөөлөгчийн хооронд уулзалт, техник-худалдааны хэлцэл зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.1.7. Компани, Захиалагчийн хооронд харилцан ашигтай гэрээ байгуулахад туслалцаа үзүүлэх;

2.1.8. Компанитай хийсэн гэрээтэй холбогдуулан орон нутагт экспорт-импортыг зохицуулах, худалдаа эрх зүйн асуудлаар зөвлөлдөх.

2.2. Агент компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах эрхгүй.

2.3. Агент өөрийн үйл ажиллагааг бие даан явуулна.

2.4. Агент үнэ, бэлтгэн нийлүүлэх нөхцөл, төлбөрийн талаар компанийн удирдамжийг хатуу баримтлах үүрэгтэй.

2.5. Агент зөвхөн компанийн зөвшөөрлийн үндсэн дээр Захиалагчид хандан худалдааны асуудлаар санал тавих эрхтэй.

## 3. Компанийн үүрэг.

3.1. Энэ гэрээний агуулгатай нийцүүлэн, компани дор дурдсан үүрэг хүлээнэ:

3.1.1. Агентыг бүтээгдэхүүнтэй холбогдох шаардлага бүхий сурталчлах, танилцуулах материалаар хангах;

3.1.2. Агентыг бүтээгдэхүүний үнийн баримжааны тухай мэдээллээр хангах;

3.1.3. Агентаар дамжуулан түүний олсон Захиалагчид худалдааны талаар санал өгөх;

3.1.4. Агентад түүний дэмжлэгтэйгээр хийсэн худалдааны тухай мэдээлэл, энэ гэрээнд нийцүүлэн компани, Захиалагч хоёрын хооронд байгуулсан гэрээний хуулбарыг өгөх;

3.1.5. Агентын үйл ажиллагааны үр дүнд буюу тэдний оролцоотойгоор хийгдсэн төсвөөр техникийн болон худалдааны хэлэлцээ хийх;

3.2. Компани энэ гэрээ ёсоор Агентад төлөх төлбөр (шагнал)-ыг цаг тухайд нь бүрэн төлнө.

## 4. Төлбөр (шагнал)-ийн хэмжээ.

4.1. Компани нь Агентад, түүний хийсэн ажлын төлөө, өөрөөр хэлбэл, Агентын үүрэгтэй холбоотойгоор байгуулсан гэрээний үндсэн дээр борлуулсан үнийн дүнгийн _______ хувьтай тэнцэх хэмжээгээр төлбөр шагнал олгоно.

4.2. Агент хэрэв компанийн бүтээгдэхүүнийг худалдан авсан (гадаадаас бараа оруулагч болсон) тохиолдолд, энэ гэрээний 4.1-д дурдсан заалт нэгэн адил үйлчилнэ.

4.3. Компани нь Захиалагч худалдан авсан барааныхаа үнийг түүнд валютаар төлснөөс хойш _______ хоногийн дотор Агентад зохих төлбөр (шагнал)-ийг олгоно.

4.4. Төлбөр (шагнал)-ийг Агентын банканд буй тооцооны дансанд шилжүүлнэ. Агент төлбөр (шагнал)-ийг авсан тухай банкны баталгаа нь Компани үүргээ биелүүлсний нотолгоо мөн.

4.5. Компани, Агентад зориулан түүнд энэ гэрээгээр олгох шагналд оролцуулан шаардлагатай тоног төхөөрөмж, машин, хэрэгсэл болон бусад бүтээгдэхүүн олж авахаар тохиролцож болно. Ийм бүтээгдэхүүний тодорхой жагсаалтыг Талууд жич тохиролцоно.

## 5. Төгсгөлийн заалт.

5.1. Энэ гэрээ нь Компани, Агент нар гарын үсэг зурмагц хүчин төгөлдөр болж, ______________________________________________ хугацаанд үйлчилнэ.

5.2. Гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас 2 сарын өмнө Талуудын аль нэг нь нөгөөдөө уг гэрээнээс татгалзах тухайгаа мэдэгдээгүй бол гэрээний үйлчилгээ ______________________________ хугацаагаар аяндаа сунгагдсанд тооцогдоно.

5.3. Талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах тухай нөгөө тал бичгийн мэдэгдэл өгсөн бол, түүнээс хойш _____ хоногийн дотор хүчингүй болно.

5.4. Энэ гэрээний бүх хавсралт нь түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

5.5. Талууд гэрээний үүргээ харилцан биелүүлж, тооцоо хийж дууссан нөхцөлд гэрээний үйлчлэл дуусгавар болсон гэж үзнэ.

5.6. Энэ гэрээнд заасан зүйлүүд болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал, Талууд түүнийг хэлэлцээний замаар шийдвэрлэхийн тулд бүхий л арга хэмжээ авна.

5.7. Хэрэв маргаантай асуудлаар Талууд зохих тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

5.8. Энэ гэрээний үндсэн эхийг тус бүр хоёр хувь, Монгол, _________________ _____________________ хэл дээр хийсэн бөгөөд Талууд хоёр хэл дээр нэг, нэг хувийг хадгалав.

5.9. Талуудын хууль ёсны хаяг:

Компани:

Хаяг, индекс: ____________________________________________________________

Утас ________________________ факс _________________

Тооцооны дансны дугаар ________________________

Агент:

Хаяг,индекс: _____________________________________________________________

Утас ________________________ факс __________________

Тооцооны дансны дугаар_________________________

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Компани:

_____________________________

*(гарын үсэг)*

*тэмдэг*

Агент:

_________________________

*(гарын үсэг)*

*тэмдэг*

# БАРААГ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГААР ДАМЖУУЛАН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "А тал" гэнэ/, түүнийг______________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

______________________________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Б тал" гэнэ/, түүнийг _____________________________ үндсэн дээр төлөөлөн

(итгэмжлэл)

______________________________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Нийтлэг заалт

1.1. Зуучлагч дараах бараа бүтээгдэхүүнийг (цаашид энэхүү гэрээний салшгүй хэсэг болох барааны нэрийн жагсаалт, тусгай тодорхойлолт – жагсаалтад "бараа" гэх) бэлтгэн нийлүүлэх үүрэг хүлээнэ.

1.2. Худалдан авагч нийлүүлсэн барааг хүлээн авч үнийг төлнө.

1.3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа, журмыг талууд сар бүр тохиролцож энэхүү гэрээний салшгүй хэсэг болох графикт тодорхойлно.

1.4. Зуучлагч барааг тохиролцсон барааны нэрийн жагсаалтын дагуу тавьж олгоно.

1.5. Барааг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан шаардлагын дагуу зэрэглэн ялгаж, баглаж, бэлтгэн нийлүүлнэ.

1.6. Худалдан авагч барааны баглаа боодлыг дараах хугацаанд буцаан олгоно: _______________________________________________________________ .

## 2. Бараа бэлтгэн нийлүүлэх байгууллага

2.1. Худалдан авагч Зуучлагчид агуулахаар бэлтгэн нийлүүлэх барааны тодорхойлолт – жагсаалтыг 2 хувь үйлдэж сар бүрийн ____________-ний дотор хүргүүлнэ.

2.2. Зуучлагч тодорхойлолт – жагсаалтыг хүлээн аваад гарын үсэг зурж бэлтгэн нийлүүлэх хугацаа эхлэхээс _______________ хоногийн өмнө буцааж өгнө.

2.3. Шаардлагатай бол Зуучлагч Худалдан авагчтай тохиролцсон хугацаа, хэмжээгээр нэмэлт барааг бэлтгэн нийлүүлнэ.

2.4. Баглаа боодол бүхий барааны бэлтгэн нийлүүлэлт дараах журмаар явагдана: ________________________________________________________________.

2.5. Худалдан авагч барааг хүлээн авахын тулд Зуучлагчид албан ёсны бичгээр үйлдсэн захиалга өгнө. Зуучлагч захиалгыг хүлээн авснаас хойш ____________ ____________________________________ -ны дотор Худалдан авагчид шаардсан барааг нь илгээнэ.

2.6. Худалдан авагч тодорхойлолт – жагсаалтад заасан барааг татгалзах, эсвэл хугацааг өөрчлөх эрхтэй бөгөөд энэ тухайгаа Зуучлагчид бэлтгэн нийлүүлэх хугацаанаас _______________ хоногийн өмнө заавал мэдэгдэнэ.

2.7. Зуучлагч Худалдан авагчид тодорхойлолт – жагсаалтад заасан болон барааг бэлтгэн нийлүүлэхтэй холбогдсон төрөл бүрийн үйлчилгээ үзүүлнэ.

2.8. Худалдан авагч Зуучлагчид үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг тухайлсан ажил үйлчилгээ эхлэхээс ___________________ хоногийн өмнө гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

2.9. Ажлын гүйцэтгэлд алдаа дутагдал гарвал Зуучлагчийн бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулан дахин шалгалт хийгдэнэ.

2.10. Зуучлагч алдаа дутагдлыг дахин шалгалтаас хойш ___________ хоногийн дотор засаж залруулна.

## 3. Тооцоо хийх журам

3.1. Төлбөрийг талуудын улирал тутам тохиролцож энэ гэрээний салшгүй хэсэг болох протоколд тэмдэглэсэн үнээр хийнэ.

3.2. Үйлчилгээ үзүүлсний төлбөрийг Худалдан авагч дараах журмаар хийнэ: ________________________________________________________________

3.3. Худалдан авагч төлбөрийг сар тутам Зуучлагчийн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш __ хоногийн дотор хийнэ.

## 4. Нэмэлт нөхцөл

________________________________________________________________________

________________________________________________________________________

_______________________________________________________________________ .

## 5. Талуудын хариуцлага

5.1. Дутуу буюу чанарын шаардлага хангаагүй бараа бэлтгэн нийлүүлсэн, эсвэл хугацаа хожимдуулсан бол Зуучлагч дутуу буюу чанарын шаардлага хангаагүй барааны үнийн дүнгийн ________ хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлөх ба, нийт торгуулийн үнийн дүн ______________ төгрөгөөс илүүгүй байна.

5.2. Төлбөр төлөх хугацааг хожимдуулсны бол Худалдан авагч хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн ________ хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлөх ба, нийт торгуулийн үнийн дүн ______________ төгрөгөөс илүүгүй байна.

5.3. Талууд үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

## 6. Маргаан шийдвэрлэх

6.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож эвийн замаар шийдвэрлэнэ.

6.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Гэрээний үйлчлэх хугацаа

7.1. Гэрээ нь 202__ оны ___ сарын ___-ний өдрөөс хүчин төгөлдөр болж 202__ оны ___ сарын ___-ний өдөр хүртэл үйлчилнэ.

## 8. Гэрээний хавсралт

8.1. Хавсралт ¹ ____ . ________________________________ хуудас.

8.2. Хавсралт ¹ ____ . ________________________________ хуудас.

## 9. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

9.1. Зуучлагч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

9.2. Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

9.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| <u>ЗУУЧЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u> | <u>ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u> |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УДААН ХУГАЦААНД АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДАГУУ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ________________________________________________
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)
(цаашид “Бэлтгэн нийлүүлэгч” гэнэ), түүнийг _________________________
(итгэмжлэл)
үндсэн дээр төлөөлөн ________________________________________
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
нөгөө талаас ______________________________________________
(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)
(цаашид “Худалдан авагч” гэнэ), түүнийг ___________________________
(итгэмжлэл)
үндсэн дээр төлөөлөн ________________________________________
(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)
дараах гэрээг байгуулав.

### 2.1 Бэлтгэн нийлүүлэх зүйл

1.1. Бэлтгэн нийлүүлэгч дараах бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх ба Худалдан авагч түүнийг хүлээн авч үнийг төлөх үүрэг хүлээнэ:

| 1 | Нэр | Хэмжих нэгж | Бэлтгэн нийлүүлэх хэмжээ | Бүгд | ____ он<br>____ он |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

1.2. Бараа бүтээгдэхүүний нэрийн жагсаалт (ассортимент) болон тоо хэмжээг талууд хэлэлцэж энэ гэрээний салшгүй хэсэг болох тусгай тодорхойлолт – жагсаалтаар тохиролцоно.

1.3. Гэрээний үнэ ____________________________________________
_______________________________________________ төгрөг (валют) байна.
(үсгээр)

1.4. Худалдан авагч хүлээн авах бүтээгдэхүүний тодорхойлолт – жагсаалтыг _______________________________________________ хугацаанд
(хугацааг заах)

Бэлтгэн нийлүүлэгчид гаргаж өгнө.

1.5. Худалдан авагчийн тодорхойлолт – жагсаалтыг Бэлтгэн нийлүүлэгч хүлээн авснаас хойш ______________________ хоногийн дотор эс зөвшөөрч, үл

(хугацааг заах)

ойлголцлыг шийдвэрлүүлэх талаар хариу мэдэгдээгүй бол уг тодорхойлолт – жагсаалтыг хүлээн авсанд тооцно. Саналын зөрүүг хянан үзэж шийдвэрлэх хүртэл бэлтгэн нийлүүлэх ажлыг талуудын тохиролцсон тодорхойлолт – жагсаалтын дагуу явуулна.

## 2.2 Чанар, иж бүрдэл

2.1 Бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл нь: ________________________________________________________________

(хэм хэмжээ тогтоосон техникийн баримт бичиг: стандарт, техникийн нөхцөл болон бусад баримт бичиг, тэдгээрийн дугаар, индекс)-д нийцсэн байна.

2.2 Батлагдсан (тохиролцсон) техникийн баримт бичигт дурдаагүй чанар, иж бүрдлийн талаар тавих нэмэлт шаардлага болон техникийн шинж чанарыг нарийвчлан тогтоох талаар талууд дор дурдсан журмаар тохиролцов. ________________________________________________________________

(Чанарыг сайжруулах, иж бүрдэлд өөрчлөлт оруулах талаар саналын хуудас, зураг зэргийг нэг талаас нөгөө талдаа илгээх, түүнийг талууд авч хэлэлцэх журам, хугацааг заах )

2.3 Бэлтгэн нийлүүлэгч өөрийн бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний чанар, найдвартай байдлыг тогтоосон ________________________________________________________________

(баталгаат хугацааг тогтоосон хугацаанд батлан хариуцна. стандарт, техникийн нөхцөл болон бусад баримтын нэр, дугаарыг заах)

2.4 Бүтээгдэхүүний шошгын талаар тавигдах нэмэлт шаардлага:

________________________________________________________________ болно.

2.5 Бэлтгэн нийлүүлэгчээс бүтээгдэхүүний чанарыг хариуцан гаргасан нэмэлт баталгаа: ________________________________________________________________.

2.6 Баталгаат хугацааны дотор бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, угсрах, ашиглах үед согог дутагдал илэрвэл Бэлтгэн нийлүүлэгчийн төлөөлөгчийг заавал дуудна.

2.7 Согог дутагдлыг арилгах эсвэл өөр бүтээгдэхүүнээр солих хугацаа: ________________________________________________________________ _________________ байна.

## 3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа, журам

3.1. Бараа бүтээгдэхүүнийг энэ гэрээнд хавсаргасан тодорхойлолт – жагсаалтад дурдсан хугацаанд бэлтгэн нийлүүлнэ. Бэлтгэн нийлүүлэгч тогтоосон хугацаанаас өмнө бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх эрхтэй. Бэлтгэн

нийлүүлэгч хэрэв бололцоо байгаа бол Худалдан авагчаас бүтээгдэхүүнийг яаралтай (хугацаанаас өмнө) бэлтгүүлэх захиалга хүлээн авч болох бөгөөд уг захиалгыг хүлээн авсан тухайгаа хариу мэдэгдэнэ. Бараа бүтээгдэхүүнийг яаралтай бэлтгэнэ гэдэг нь захиалга өгсөн өдрөөс хойш ____________ хоногийн дотор бэлтгэн нийлүүлэхийг хэлнэ.

3.2. Бараа бүтээгдэхүүнийг _______________________________________________

(тээврийн хэрэгслийн төрөл, бүтээгдэхүүн ачих арга болон ачиж илгээх графикийг тохиролцох журам) _______________ ачиж илгээнэ.

3.3. Ачиж илгээх доод хэмжээ нь ____________________________________ байна.

(вагон, чингэлэг, бусад тээврийн хэрэгсэлд ачих ачааны доод хэмжээ)

3.4. Худалдан авагчийн захиалгын дагуу тодорхойлолт – жагсаалтад орсон ачуулах доод хэмжээнээс бага хэмжээтэй бүтээгдэхүүнийг уг жагсаалтад зааснаар бэлтгэн нийлүүлнэ.

3.5. Бэлтгэн нийлүүлэгч бараа бүтээгдэхүүнийг хэсэг хэсгээр ачуулж болно.

3.6. Бараа бүтээгдэхүүн нь тодорхойлолт – жагсаалтад заасан дугаар, индекс бүхий стандарт, техникийн нөхцөлд нийцсэн баглаа боодолтой байна. Үүнд: ____________________________________________________________________

(ачиж илгээх үед бүтээгдэхүүнийг баглаж боох хэрэгсэл, тусгай чингэлэгт, эсвэл ачааг бэхлэх зорилгоор төмөрлөг болон бусад хэрэгслээр боох эсэх, буцаах журам, хугацаа, тооцоо хийх нөхцөл гэх мэтийг заах)

## 4. Үнэ, тооцоо хийх журам

4.1. Худалдан авагч Бэлтгэн нийлүүлэгчид бүтээгдэхүүний үнийг талуудын ________________________________________________________________

(үнийн хэмжээ)

___________________________________________________________________________
____________________________- ээр

( үнийн талаар тохиролцсон протоколын огноо, дугаар)

тохирсон хэмжээгээр төлнө.

4.2. Төлбөр төлөх хугацаа: _______________________________________________ .

4.3. Бараа бүтээгдэхүүний бөөний үнэд доорх нэмэлт төлбөр, хөнгөлөлт тогтооно. ________________________________________________________________
________________________________________________________________

4.3.1. Захиалгыг яаралтай гүйцэтгэсний нэмэлт төлбөр нь бэлтгэн нийлүүлсэн бөөний үнийн __________ хувь байна.

4.3.2. ____________________________________________________________

(шаардлагатай бол талууд тохиролцсоны үндсэн дээр тогтоосон нэмэлт төлбөрийн төрөл, хэмжээг заах, эсвэл ийм тохиролцоонд хүрсэн албан ёсны баримт бичгийг заах)

4.4. Талуудын хоорондын тооцоог _________________________________________

______________________________________________________хийнэ.

( тооцоо хийх арга замыг заах)

4.5. Бүтээгдэхүүний тооцоог (бүтээгдэхүүнийг бүхэлд нь хүлээн авсны эцэст тоног төхөөрөмж, техник оруулсан хэмжээгээр ) ____________________________________________

4.6. Тусгай баглаа боодол, мөн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд зориулан хийсэн хэрэгслийн өртгийг үндэслэн Бэлтгэн нийлүүлэгчийн тооцоолон тодорхойлсон үнийг Худалдан авагч төлнө.

## 5. Талуудын удаан хугацааны аж ахуйн харилцааг хангах хамтын ажиллагаа

5.1. Бэлтгэн нийлүүлэгч: ________________________________________________________

(бэлтгэн нийлүүлэлтийг хугацаанд нь хийх,

______________________________________________________________________

_______________________________

техникийн нөхцөл, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх зэрэг Бэлтгэн нийлүүлэгчийн үүргийг заах,

______________________________________________________________________

_______________________________

мөн Худалдан авагчид үзүүлэх нэмэлт үйлчилгээ: бүтээгдэхүүнийг бэлтгэх болон тээвэрлэх

______________________________________________________________________

_______________________________

хугацааг мэдээлэх, бүтээгдэхүүнийг угсрах, ашиглах явцад техникийн туслалцаа үзүүлэх

______________________________________________________________________

_____________ үүрэг хүлээнэ.

баталгаат болон техникийн үйлчилгээ г.м. )

5.2. Захиалагч: ______________________________________________________

______________________________________________________________________

______________________________________________________________________

______________________________________________________________________

______________________________________________________________________

__________________________________________ үүрэг хүлээнэ.

5.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хамтын ажиллагааг алдагдуулахгүй байх, ажил хэрэгч харилцааг дэмжих, аж ахуйн хэлхээ холбоог хөгжүүлэх, үр дүнг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## 6. Эд хөрөнгийн хариуцлага

6.1. Гэрээгээр тогтоож буй нэмэлт хариуцлага: ______________________________________________

## 7. Маргааныг шийдвэрлэх

7.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ. Арбитрын шийдвэр Талуудад эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэр байна.

## 8. Нэмэлт нөхцөл

______________________________________________________________________

______________________________________________________________________ .

## 9. Бусад нөхцөл

9.1. Энэхүү гэрээнд оруулах бүх нэмэлт өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр байна.

9.2. Гэрээ нь 200__ оны ___ сарын ___ өдрөөс хүчин төгөлдөр болж 200__ оны ___ сарын ___ хүртэл үйлчилнэ.

9.3. 9.3. Талуудын албан ёсны хаяг, харилцах дансны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд ________________ өдрийн дотор харилцан бие биедээ мэдэгдэнэ.

## 10. Гэрээний хавсралт

10.1 Хавсралт ¹ ____ . ________________________________ хуудас.

10.2 Хавсралт ¹ ____ . ________________________________ хуудас.

## 11. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

11.1. Бэлтгэн нийлүүлэгч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

11.2. Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: _______________________________________________.

Хаяг, индекс: _________________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: ___________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

11.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр                                        Улаанбаатар хот

Нэг талаас ________________________________________________________________

*(аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид "Бэлтгэн нийлүүлэгч" гэнэ), түүнийг ___________________________________ үндсэн дээр төлөөлөн

____________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

Нөгөө талаас

______________________________________________________________________

*(аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид “Худалдан авагч” гэнэ), түүнийг ________________ үндсэн дээр төлөөлөн

__________________________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

дараах гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний агуулга.

1.1. Бэлтгэн нийлүүлэгч нь тодорхой бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн, худалдан авагчийн өмчлөлд тогтмол шилжүүлэн өгч, худалдан авагч уул бараа бүтээгдэхүүнийг цаг тухайд нь хүлээн авч, гэрээнд заасан нөхцөл, хугацаанд түүний үнийг төлнө.

1.2. Энэ гэрээгээр дор дурдсан бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлнэ. Үүнд:

1.2.1. ____________________________________________________________

1.2.2. ____________________________________________________________

1.2.3. ____________________________________________________________

## 2. Бэлтгэн нийлүүлэх тоо хэмжээ, хугацаа.

| 1 | Нэр | Нэгж Хэмжүүр | _____ оны 1-р улиралд | _____ оны 2-р улиралд | ___ оны 3-р улиралд | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | | | | | |

## 3. Нэр төрөл.

3.1. Бараа бүтээгдэхүүний нэр төрөл ямар байхыг энэ гэрээний бүрэлдэхүүн хэсэг болсон 1-р хавсралт-тодорхойлолтод дурдсан.

3.2. Худалдан авагч, хэрэв бараа бүтээгдэхүүний нэр төрөлд зарим нэг өөрчлөлт оруулах нь чухал гэж үзвэл, энэ тухай тохиролцох зорилгоор шинэ тодорхойлолтоо үйлдэн, гэрээ ёсоор бэлтгэн нийлүүлэх шинэ хугацаа эхлэхээс _______ сар (хоногийн) өмнө бэлтгэн нийлүүлэгчид өгнө.

3.3. Хэрэв бэлтгэн нийлүүлэгч шинэ тодорхойлолтыг хүлээн авснаас хойш _____ сар (хоногийн) дотор татгалзаж байгаагаа мэдэгдээгүй бол уг саналыг зөвшөөрсөнд тооцно.

## 4. Чанар, иж бүрдэл.

4.1. Бэлтгэн нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдэл нь ______________________________________________________________

*(Улсын стандарт, техникийн нөхцөл, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, загвар зэргийн алинд нийцсэн болохыг бичих)*

_________________________________________-ийн заалтад нийцсэн байна.

4.2. Бэлтгэн нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдлийг ______________________________________________________________

*(бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдлийн тухай*

__________________________________________________________-ээр

батална. */баримт бичгийн нэрийг бичнэ/*

4.3. Бараа бүтээгдэхүүний иж бүрдэлд нэмж оруулах зүйл: ________ ______________________________________________________________

4.4. Бараа бүтээгдэхүүний иж бүрдлээс худалдан авагч хэрэгцээгүй дор дурдсан зүйлийг хасав:

______________________________________________________________

______________________________________________________________

4.5. Энэ гэрээний 4.1; 4.3; 4.4-д дурдаагүй бараа бүтээгдэхүүний чанар, иж бүрдлийн талаар нарийвчилсан тодорхойлолт, нэмэлт шаардлагуудыг талууд тусад нь хэлэлцэн шийдвэрлэнэ.

## 5. Баталгаат хугацаа.

5.1. Бэлтгэн нийлүүлэгч өөрийн бэлтгэн нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний чанар, найдвартай байдлыг _________ үеэс хойш ___________ жил (сар, хоног)-ийн хугацаанд дааж хариуцна.

5.2. Хэрэв бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, эмхэлж угсрах, ашиглах үед бараа бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн согог дутагдал илэрсэн бөгөөд энэ нь баталгаат хугацааны дотор бол худалдан авагч бэлтгэн нийлүүлэгчийн төлөөлөгчийг заавал дуудна.

5.3. Бэлтгэн нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүний согог дутагдал (иж бүрдэл дутуу)-ыг илрүүлснээс хойш _______ хоног (цагийн) дотор тэрхүү согог дутагдлыг арилгаж, эсвэл солих буюу иж бүрдлийг гүйцээнэ.

## 6. Бэлтгэн нийлүүлэх хугацаа, журам.

6.1. Бараа бүтээгдэхүүнийг ____ оны __-р сарын __-ны дотор бэлтгэн нийлүүлнэ. (Тогтмол, удаан хугацаагаар бэлтгэж нийлүүлэх зүйлийн хугацааг улирлын эхний сарын 15-ны дотор гэх мэтээр заана)

6.2. Бэлтгэн нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанаас өмнө нийлүүлэх эрхтэй бөгөөд тэгэхдээ энэ тухайгаа ачуулан явуулснаас хойш ____________ хоног *(цагийн), (эсвэл өөр үйл явдал болсон өдрөөс хойш ч гэж болно)* дотор худалдан авагчид заавал мэдэгдэнэ.

## 7. Үнэ.

7.1. Худалдан авагч нь энэ гэрээний 1-р хавсралтад тодорхойлсон үнийг бэлтгэн нийлүүлэгчид төлнө.

7.2. Гэрээний хавсралтад дурдсан үнэ нь нэмэгдэл өртгийн татварыг оролцуулаагүй *(оролцуулсан)* болно.

## 8. Тооцооны журам.

8.1. Бэлтгэн нийлүүлсэн хэсэг бараа бүтээгдэхүүн бүрийн үнийг худалдан авагч ________________________________________________________________

*(хүлээн авсан, эсвэл ачуулсан өдрөөс хойш гэх мэтээр)*

үеэс хойш ______________ хоногийн дотор бэлэн бишээр төлнө.

*(Энд урьдчилан төлөх төлбөрийн тухай дурдаж болно)*

8.2. Төлбөрийн журам:

___________________________________________. *(цахилгаанаар, шуудангаар)*

8.3. Тооцооны хэлбэр:

____________________________________________________.

*(төлбөрийн даалгавар, чек, нэхэмжлэл, аккредитив)*

8.4. Худалдан авагч, мөнгө төлөх бүрдээ энэ тухайгаа ____________ ___________-ээс хойш __________ хоног (цаг)-ийн дотор бэлтгэн нийлүүлэгчид ______________________________ мэдэгдэнэ.

*(цахилгаан буюу факсаар зэргээр)*

**9. Бэлтгэн нийлүүлэх**

**(бараа бүтээгдэхүүнийг хүргэж өгөх) нөхцөл.**

*9.1.* Бараа бүтээгдэхүүнийг дараах нөхцөлөөр хүргэж өгнө: *(Энд агуулахад буюу вагонд үнэ төлбөргүй хүргэж өгөх гэх мэтээр тодорхойлно).*

9.2. Бараа бүтээгдэхүүнийг өмчлөх эрх:

______________________________________________ үеэс шилжинэ.

9.3. ___________________ үеэс бараа бүтээгдэхүүнд аюул учирч болох нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

**10. Ачуулах газар (цэг).**

10.1. Бараа бүтээгдэхүүнийг ачуулах газар (цэг) нь: ________________ ________________________ болно.

**11. Баглаа боодол.**

11.1. Бэлтгэн нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг худалдан авагч хүлээн авах хүртэл хугацаанд гэмтэх, устахаас хамгаалж чадахуйцаар баглаа боодол хийнэ.

11.2. Бараа бүтээгдэхүүнийг дор дурдсан байдлаар боож баглах буюу хайрцаг саванд хийсэн байна. ________________________________________ ______________________________________________________________

11.3. Баглаа боодлын үнэ нь бараа бүтээгдэхүүний үнэнд орно. (орохгүй)

11.4. Баглаа боодлыг буцаан өгөх журам, хугацаа: ________________________ ______________________________________________________________ ______________________________________________________________

11.5. Баглаа боодлыг буцаах үед тооцоо хийх нөхцөл:

______________________________________________________________

______________________________________________________________

**12. Шошго.**

12.1. Бараа бүтээгдэхүүнд дор дурдсан шошго хийнэ:

______________________________________________________________

______________________________________________________________

*(Энд баглаа боодол дээр зурах зураг, бичих зүйлийг өгүүлэх буюу улсын стандартыг нэрлэн дурдана.)*

## 13. Ачуулах, тээвэрлэх.

13.1. Ачуулах илгээх газар (цэг): ________________________________ болно.

13.2. Ачуулж илгээх хугацаа: Бэлтгэн нийлүүлэгч бараа бүтээгдэхүүний хэсэг бүрийг ________________________-ээс хойш __________________ улирал (сар, хоног, цаг)-ийн дотор ачуулна.

13.3. Тээврийн хэрэгслийн төрөл:

__________________________________________

13.4. Ачуулах доод хэмжээ:

_________________________________________________.

*(вагон, чингэлэг гэх зэргээр)*

13.5. Ачуулж илгээх онцлог:

________________________________________________

_______________________________________________

13.6. Бэлтгэн нийлүүлэгч нь бараа бүтээгдэхүүнийг ачуулах бүрт энэ тухайгаа ____________-ээс хойш __________ хоног (цаг)-ийн дотор ________________ замаар (цахилгаан буюу факс зэргээр) худалдан авагчид мэдэгдэнэ. (Мэдэгдэлд ачуулсан хугацаа, падаан (дагалдах хуудас)-ы дугаар, вагоны дугаар, (хөлөг онгоцны нэр, автомашины дугаар, рейсийн дугаар), гэрээний дугаар, он, сар, өдөр, бараа бүтээгдэхүүний нэр тоог тусгана.)

## 14. Бараа бүтээгдэхүүнийг гардуулан өгөх.

14.1. Бараа бүтээгдэхүүнийг гардуулан өгөх авах газар \цэг\ дээр гүйцэтгэнэ.

14.2. Бараа бүтээгдэхүүнийг зохих тоо, чанартайгаар хүлээн авах, өгөх ажлыг талууд хууль тогтоомжид заасан журмаар гүйцэтгэнэ.

14.3. Худалдан авагч бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсан тухайгаа ________________-нээс хойш ______________ хоног (цаг)-ийн дотор (цахилгаанаар буюу бусад аргаар) бэлтгэн нийлүүлэгчид мэдэгдэнэ.

## 15. Гэрээний үйлчлэх хугацаа.

15.1. Энэ гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, ____ оны __-р сарын __ хүртэл үйлчилнэ.

15.2. Хэрэв аль нэг тал гэрээг хүчингүй болгох буюу өөрчлөх тухай саналаа уг гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас ______________ хугацааны өмнө гаргаагүй бол энэ гэрээг __________________________ хугацаагаар сунгасанд тооцно.

## 16. Талуудын хариуцлага.

16.1. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал түүнээс болж нөгөө талдаа учирсан бүх хохирол, түүний дотор олох ёстой байсан орлогыг хууль тогтоомжид заасан журмаар төлж өгнө.

16.2. Худалдан авагч энэ гэрээгээр дор дурдсан хариуцлага хүлээнэ.Үүнд: ______________________________________________________бол үнийн

*(гаргасан тодорхой зөрчлийн тухай бичих)*

дүнгийн _________ хувийн хэмжээгээр нөгөө талд анз (торгууль) төлнө.

*(нийт үнийн буюу төлөх өрийн)*

16.3. Энэ гэрээгээр бэлтгэн нийлүүлэгч дор дурдсан хариуцлага хүлээнэ. ______________________________________________________бол үнийн

*(гаргасан тодорхой зөрчлийн тухай бичих)*

дүнгийн__________ хувийн хэмжээгээр нөгөө талд анз (торгууль) төлнө.

*(нийт үнийн буюу төлөх өрийн)*

16.4. Хэрэв гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө өөрийн үүргийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр нэг талын журмаар татгалзсан буруутай тал нөгөө талдаа ____________ хэмжээгээр анз (торгууль) төлнө.

16.5. Гэрээний бусад нөхцөлийг зөрчсөн буруутай тал дараах хариуцлага хүлээнэ.Үүнд:

______________________________________________________

______________________________________________________________

___________________________________________________________

## 17. Давагдашгүй хүчин зүйл

17.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль / чөлөөлөгдөх үндэслэл болно.

17.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 18. Гэрээний үүргийг хангах арга.

18.1. ____________________________________________________________

*(Энд барьцаа, дэнчин, батлан даалт, баталгаа зэргийг дурдаж болно)*

___________________________________________________________________

**19. Маргааныг шийдвэрлэх.**

19.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

**20. Гэрээний нөхцөлийг өөрчлөх.**

20.1. Энэ гэрээний нөхцөлийг зөвхөн хоёр талын бичгээр үйлдсэн тохиролцооны үндсэн дээр өөрчилнө.

20.2. Гэрээний аль ч тал нөгөө талынхаа бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээний эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй.

**21. Талуудын хооронд холбоо барих нөхцөл.**

21.1. Энэ гэрээний асуудлаар холбоо барьдаг байх талуудын эрх бүхий төлөөлөгчид нь:

| Бэлтгэн нийлүүлэгчийнх: | Худалдан авагчийнх: |
|---|---|
| Нэр: | Нэр: |
| Албан тушаал: | Албан тушаал: |
| Утасны дугаар: | Утасны дугаар: |
| Цахим шуудангийн хаяг: | Цахим шуудангийн хаяг: |

**22. Гэрээний онцгой нөхцөл.**

22.1. ___________________________________________________________________
___________________________________________________________________

**23. Бусад нөхцөл.**

23.1. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдсэн бөгөөд тал бүр нэг хувийг хадгална.

23.2. Энэ гэрээнд тодорхойлон заагаагүй асуудлыг шийдвэрлэхдээ талууд Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийн холбогдох заалтыг удирдлага болгоно. (Эсвэл тодорхой нэгэн эрх зүйн баримт бичгийг заан нэрлэж болно)

23.3. Энэ гэрээнд гарын үсэг зурмагц түүнтэй холбогдуулан хийсэн бүхий л урьдчилсан хэлэлцээ, тохиролцоо, гэрээ, бичиг захидал, ямар нэгэн протокол дахь тохиролцоонд зөрүүтэй байдал үүсвэл энэхүү гэрээг баримтална.

## 24. Энэ гэрээ байгуулах үе дэх талуудын хууль ёсны хаяг, банк дахь болон ачаа тээшний үзүүлбэр.

24.1. Худалдан авагч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

Ачаа тээшний тухай томьёолбор (код) бүхий реквизитүүд:

4. Вагоноор ачуулахад зориулан: ____________________________________.
5. Чингэлгээр ачуулахад зориулан: __________________________________.
6. Агаарын тээврээр ачуулахад зориулан: _____________________________.

24.2. Бэлтгэн нийлүүлэгч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ______________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

Ачаа тээшний тухай томьёолбор (код) бүхий реквизитүүд:

4. Вагоноор ачуулахад зориулан: ____________________________________.
5. Чингэлгээр ачуулахад зориулан: __________________________________.
6. Агаарын тээврээр ачуулахад зориулан: _____________________________.

Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

24.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

24.4. Худалдан авагчаас өөрийн ачаа тээвэртэй холбогдох баримт бичигт оруулсан өөрчлөлтийн мэдэгдлийг тухайн үеийн бэлтгэн нийлүүлэх ажиллагаа эхлэхээс

_______ хоногийн өмнө өгсөн нөхцөлд түүнийг бэлтгэн нийлүүлэгч биелүүлэхээр хүлээн авна.

24.5. Бэлтгэн нийлүүлэгчийн өөрийн банк дахь баримт бичигт орсон өөрчлөлтийн тухай мэдэгдлийг төлбөр хийх хугацаа эхлэхээс ______ хоногийн өмнө өгсөн нөхцөлд худалдан авагч түүнийг төлбөр хийхдээ хэрэгжүүлэхээр хүлээн авна.

**25. Гэрээний хавсралт.**

25.1. 1-р хавсралт. Бараа бүтээгдэхүүний тодорхойлолт ___ хуудас.

Хавсралт нь энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ МАТЕРИАЛ, ТҮҮХИЙ ЭДИЙГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ____ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ____________________________________________________________

(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид“Бэлтгэн нийлүүлэгч”гэнэ),түүнийг ________________________________

(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн ____________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нөгөө талаас ___________________________________________________________

(иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг)

(цаашид “Дахин боловсруулагч” гэнэ), түүнийг______________________________

(итгэмжлэл)

үндсэн дээр төлөөлөн ____________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

дараах гэрээг байгуулав.

## 1. Нийтлэг заалт

1.1. Бэлтгэн нийлүүлэгч Дахин боловсруулагчид түүхий эд материал (цаашид “түүхий эд” гэх) нийлүүлэх, Дахин боловсруулагч түүхий эдийг бэлтгэн Бэлтгэн нийлүүлэгчид дараах бүтээгдэхүүнийг шилжүүлнэ:

______________________________________________________________________

___________________________________________________ .

1.2. Түүхий эд болон бүтээгдэхүүний хэмжээ, чанар, нэрсийн жагсаалтыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох талуудын сар бүр тохиролцох тодорхойлолт – жагсаалтад тэмдэглэнэ.

1.3. Түүхий эд болон бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, түүвэрлэх хугацааг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох талуудын сар бүр хамтран батлах графикт тодорхойлно.

## 2. Чанарын дагуу, тогтоосон хэмжээгээр хүлээн авах

2.1. Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг __________________________

______________________________________________________________________

(бараа ашиглах баримт бичиг, чанарын гэрчилгээ, түргэн муудах түүхий эд, бүтээгдэхүүний чанарын шинжилгээний дүгнэлт) дагалдана.

2.2. Шинжилгээний дүгнэлт ирээгүй тохиолдолд түүхий эд, эсвэл бүтээгдэхүүнийг хүлээн авагч нь нөгөө талын төлөөлөгчийг байлцуулан түүний зардлаар шаардлагатай шинжилгээг хийнэ. Хэрвээ нөгөө тал төлөөлөгчөө явуулаагүй бол эрх бүхий хөндлөнгийн байгууллагаас төлөөлөгч авна.

## 3. Тооцоо хийх журам

3.1. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн түүхий эдээс бүтээгдэхүүн бэлтгэсэн ажлын төлбөрийг өмнөх сарын _____________ дотор тохиролцсон үнээр сар бүрийн ________________-аас хэтрэхгүй хугацаанд хийнэ.

3.2. Төлбөрийг Дахин боловсруулагчийн тооцооны дансанд шилжүүлэх замаар хийнэ.

3.3. Хэрвээ Бэлтгэн нийлүүлэгч бэлэн болсон бүтээгдэхүүнийг түүвэрлэх ажлыг __________________ хоногоор хожимдуулбал Дахин боловсруулагч түүвэрлээгүй бүтээгдэхүүнийг борлуулах эрх эдэлнэ.

3.4. Баглаа боодлын тооцоог дараах журмаар хийнэ: _______________________

_____________________________________________________________________ .

3.5. Шинэ улирал эхлэх бүр сарын ____________ дотор өмнөх улирлын ажлыг хэлэлцэж дүнг тооцох бөгөөд протоколд тэмдэглэнэ.

## 4. Эд хөрөнгийн хариуцлага

4.1. Дутуу буюу чанарын шаардлага хангаагүй түүхий эд бэлтгэн нийлүүлсэн, эсвэл бэлтгэсэн бүтээгдэхүүний төлбөр хийх хугацааг хожимдуулсан бол Бэлтгэн нийлүүлэгч дутуу буюу чанарын шаардлага хангаагүй түүхий эдийн эсвэл хугацаанд нь төлбөр төлөөгүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн ____ хувьтай тэнцэх хэмжээний, гэхдээ ________________________________________________ төгрөгөөс илүүгүй торгууль төлнө.

4.2. Хэрвээ Дахин боловсруулагч Бэлтгэн нийлүүлэгчийн түүхий эдээс бэлтгэсэн бүтээгдэхүүнийг түүнийг түүвэрлэх ажил ____________ хоногоор хойшилсноос бусад тохиолдолд борлуулсан бол бэлтгэсэн бүтээгдэхүүний үнийн дүнгийн ____________ хувийн хэмжээтэй торгууль төлнө.

4.3. Дахин боловсруулагч чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, өөрөө бие даан борлуулахдаа түүхий эдийн төлбөр хийх хугацаа хожимдуулсан бол тийнхүү чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүний үнийн дүнгийн ____________ хувийн хэмжээтэй торгууль төлнө.

4.4. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол олох байсан ашгийг тооцон барагдуулна. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотолно.

4.5. ______________________________________________________________________

## 5. Нэмэлт нөхцөл

_______________________________________________________________________________
_______________________________________________________________________________
____________________________________________________________________ .

## 6. Маргаан шийдвэрлэх журам

6.1. Маргаан үүсэх тохиолдолд талууд асуудлыг зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа

7.1. Гэрээ нь гарын үсэг зурсан үеэс хүчин төгөлдөр болж ___________ хүртэл үйлчилнэ.

7.2. Гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө __________ хоногийн дотор аль нэг талаас гэрээг цуцлах санал тавихгүй бол гэрээг _____________ хугацаатай сунгасанд тооцно.

## 8. Гэрээний хавсралт

8.1. Хавсралт [1] ____ . ___________________________________ хуудас.

8.2. Хавсралт [1] ____ . ___________________________________ хуудас.

## 9. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

9.1. Бэлтгэн нийлүүлэгч талын :

Оршин байгаа газар: _____________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________________.

Утас: ______________ телетайп: __________________

Факс: ____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________________.

9.2. Дахин боловсруулагч талын:

Оршин байгаа газар: _____________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________________.

Утас: ______________ телетайп: __________________

Факс: ____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ______________________________________.

9.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧ <u>ТӨЛӨӨЛЖ:</u>

________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

ДАХИН БОЛОВСРУУЛАГЧ <u>ТӨЛӨӨЛЖ:</u>

________________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

# ГАДААДААС ХҮНСНИЙ БАРАА ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас

______________________________________________

*(гадаадын компани, пүүсийн нэр, хаяг)*

(цаашид "Худалдагч" гэнэ), түүнийг _______________ үндсэн дээр төлөөлөн _______________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

Нөгөө талаас Монгол Улсын

____________________________________

*(Монгол Улсын байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид "Худалдан авагч" гэнэ), түүнийг ___________ үндсэн дээр төлөөлөн _______________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

нар дор дурдсан гэрээ бичгийг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний агуулга

1.1. Худалдагч ________________________________ үйлдвэрт үйлдвэрлэсэн ______________________________ нэр бүхий барааг _______________________ хэмжээгээр худалдаж, Худалдан авагч түүнийг худалдан авахаар тохиролцов.

1.2. Худалдагч нь Худалдан авагчийн зөвшөөрөлтэйгөөр уг барааг тогтоосон хэмжээнээс ______ хувиар илүү буюу дутуу бэлтгэн нийлүүлж болно.

## 2. Гэрээний үнэ

2.1. Энэ гэрээгээр худалдаж буй барааны цэвэр жингээр нэг тонн нь, сав, баглаа боодол, шошго тэмдэг болон тээврийн хэрэгсэлд ачих, эмхлэн хураах, янзлах ажиллагаа, тэдгээрт ашигласан материалын үнийн хамт ________________________________________ (валютаар, бичгээр) болно.

2.2. Нийт худалдаж буй барааны үнэ нь ________________________________________ (валютаар, бичгээр) болно.

## 3. Бэлтгэн нийлүүлэх хугацаа.

3.1. Энэ гэрээгээр худалдаж буй барааг бэлтгэн нийлүүлэх хугацаа нь Талуудын тохиролцсон, барааг ачуулах сарын графиктай зохицуулан дор дурдсан хугацаанд бэлтгэн нийлүүлнэ:

____________________________________.

3.2. Барааг Худалдан авагчийн нэр дээр Монголын боомт буюу ачаа хүлээн авах газарт явуулсан тухай баримт бичгийн он, сар, өдрийг барааг бэлтгэн нийлүүлсэн хугацаа гэж үзнэ.

## 4. Барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдэг.

4.1. Барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдэг нь энэ гэрээний болон энэ гэрээний ___________-р хавсралтууд болох техникийн нөхцөл, мал эмнэлгийн ба ариун цэврийн шаардлагад нийцсэн байна.

4.2. Барааны чанар, түүний сав, баглаа боодол, шошго тэмдэг дээр дурдсан шаардлагад нийцэж буйг дор дурдсан баримт бичгүүдээр баталнa:

1. Барааг үйлдвэрлэсэн орны төрийн зохих эрх бүхий байгууллагаас барааны хэсэг бүрд, түүний энэ гэрээний 1-д дурдсан бүрэн нэрийг зааж олгосон чанарын гэрчилгээ, барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдгийн үзүүлэлт (эдгээр нь энэ гэрээний _____-р хавсралтад дурдсан шаардлагад нийцсэн байна), барааг үйлдвэрлэсэн он, сар, өдөр;
2. Худалдан авагчийн шаардлага, Худалдагчийн томилолт, зардлаар ажилласан хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргасан чанарын тухай гэрчилгээ; Энэ гэрчилгээнд энэ гэрээний 4.1-д дурдсан барааны тухай бүх мэдээллийг заасан байна.
3. Энэ гэрээний ______-р хавсралтад дурдсан барааг үйлдвэрлэсэн орны ________ албанаас барааны хэсэг бүрд өгсөн, уул бараа энэ гэрээний _______-р хавсралтад дурдсан мал эмнэлгийн шаардлагын зүйл нэг бүрийн заалттай бүрэн нийцэж байгааг баталсан бөгөөд тэр нь хэрэг дээрээ зохих баримт бичгээр давхар батлагдсан гэрчилгээ;
4. Барааг үйлдвэрлэсэн орны төрийн эрх бүхий байгууллагаас барааны хэсэг бүрд олгосон ариун цэврийн гэрчилгээ;

4.3. Барааны чанарын тухай болон мал эмнэлгийн, ариун цэврийн гэрчилгээнүүдэд дор дурдсан зүйлсийг заавал бичсэн байна:

4.3.1. Барааг тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл, ачуулсан газар (цэг), ачаа ачихаар хүлээн авсан тухай тээвэрлэгч байгууллагын (удирдлагын) мэдэгдэл бичгийн он, сар, өдөр, дугаар;

4.3.2. Мэдэгдэл бичиг тус бүрээр барааны (ачуулахаар өгсөн хэсэг бүрээр) цэвэр ба бохир жин;

4.3.3. Гэрчилгээ олгосон он, сар, өдөр;

4.4. Гэрчилгээнүүдэд уул бараа техникийн ба ариун цэврийн шаардлага, энэ гэрээний болон гэрээний хавсралтуудад заасан шаардлагад нийцэж байгааг шууд заасан байна.

4.5. Гэрчилгээнүүдэд Худалдан авагчийн шаардлагаар бусад мэдээллийг оруулж болно.

4.6. Гэрчилгээнүүдийг уг барааг үйлдвэрлэсэн улсын хэл, мөн Монгол хэл дээр хийсэн байна.

## 5. Барааг хүлээлгэн өгөх, авах.

5.1. Зохих тоо, чанарын барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг урьдчилан тохиролцсон газар (цэг)-т Монгол Улсын зохих мэргэжлийн шинжилгээний байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

5.2. Зохих тоо, чанарын барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлын үр дүн нь Монголын талын зохих мэргэжлийн шинжилгээний байгууллагын актаар эцэслэн шийдвэрлэгдэх бөгөөд уг актад хийсэн дүгнэлт, шаардлагыг Худалдагч, Худалдан авагч нар нэгэн адил биелүүлнэ.

5.3. Дээр дурдсан актын заалттай нийцүүлэн Худалдан авагч нь бэлтгэн нийлүүлсэн барааны талаар эцсийн тооцоог, энэ гэрээний 7-д заасан журмаар хийнэ.

5.4. Хэрэв дээр өгүүлсэн мэргэжлийн шинжилгээний байгууллагын актаар ирсэн бараа бүхэлдээ буюу түүний зарим хэсэг нь чанар, сав, баглаа боодол, шошго тэмдгийн талаар энэ гэрээний шаардлагыг хангаагүй нь тогтоогдвол, Худалдан авагч нь тэдгээрийн зохих үнийг барааны жинхэнэ чанарт тохируулан бууруулж тооцоо хийх буюу Худалдагчид энэ гэрээний 10-д заасан хариуцлага хүлээлгэх, эсвэл уг барааг Худалдагчид түүний зардлаар буцааж, учирсан бүх хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

5.5. Барааг буцааж өгөх явдал энэ гэрээнд дурдсан үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн хариуцлагаас Худалдагчийг чөлөөлөхгүй.

5.6. Хэрэв Худалдагч нь гэрээ болон түүний хавсралтад дурдсан хугацаанаас эрт үйлдвэрлэгдсэн барааг бэлтгэн нийлүүлсэн нь мэргэжлийн шинжилгээний байгууллагын актаар тогтоогдвол, Худалдан авагч тооцоо хийхдээ энэ гэрээнд дурдсан үнийн 50 хувиас илүүгүй үнэ төлж болохын хамт чанарын шаардлага хангаагүй бараа нийлүүлсний төлөө түүнд зохих торгууль (алданги) авах эрхтэй.

5.7. Хэрэв шинжилгээ, шалгалтын үр дүнд бэлтгэн нийлүүлсэн барааны ___-ээс дээш хувь нь чанарын талаарх энэ гэрээний техникийн нөхцөлийг хангаагүй нь илэрвэл, Худалдан авагч гэрээг цуцлахын хамт, Худалдагчаас бэлтгэн нийлүүлсэн барааны үнийн дүнгийн __ хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль авах эрхтэй. Тэрчлэн энэ үед Худалдан авагч нь энэ гэрээнд дурдсанаас дутуу нийлүүлэгдсэн барааг дэлхийн зах зээлийн үнээр худалдан авч, хэрэв энэ үнэ нь гэрээ ёсоор Худалдагчид төлөх үнээс илүү байвал, уг үнийн зөрүүгээр учирсан хохирлыг Худалдагчаас нэхэмжлэн авах эрхтэй.

5.8. Худалдагч нь энэхүү үнийн зөрүүгээс учирсан хохирлыг Худалдан авагчийн шаардлагыг хүлээн авснаас хойш ___ хоногийн дотор төлөх үүрэгтэй. Энэ талаарх Худалдагчийн шаардлагыг дурдсан хугацаанд биелүүлэхгүй удаашруулбал, Худалдагч нь шаардлагад өгүүлсэн төлбөрийн дүнгийн ____ хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдэл торгуулийг Худалдан авагчид төлнө.

5.9. Худалдагч нь Худалдан авагч буюу түүний төлөөлөгчид барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдгийг барааг ачуулахаас өмнө ачих газар (цэг) дээр болон ачсан тээврийн хэрэгсэл дотор өөртөө тохиромжтой цагтаа шалган үзэх эрх, боломж олгоно.

5.10. Хэрэв ингэж шалгаж үзэхэд аль нэг барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдэг энэ гэрээний шаардлагыг хангаагүй нь илэрвэл, Худалдан авагч буюу түүний төлөөлөгч уул хэсэг барааг ачуулахыг хориглох эрхтэй. Энэ тохиолдолд Худалдагч нь гологдол болсон барааг өөрийн зардлаар сольж өгнө.

## 6. Тээвэрлэлтийн нөхцөл.

6.1. Худалдагч нь энэ гэрээний 3-т заасан хугацаанд нийцүүлэн барааг ачуулахад бэлэн болохоо бэлтгэн нийлүүлэх ажил хийгдэх сар бүрийг эхлэхээс _____ хоногоос доошгүй хугацааны өмнө Худалдан авагчид батлан мэдэгдэнэ.

6.2. Худалдагч нь, Худалдан авагч зохих тээврийн хэрэгслийг сонгон нэрлэснээс хойш ________ хоногийн дотор бараа ачуулах газар (цэг)-т, Худалдан авагчийн сонгон нэрлэсэн тээврийн хэрэгсэлд ачих, барааны тоо хэмжээг Худалдан авагчаас урьдчилан тодорхойлсонд нийцэх хэмжээний барааг ачуулахад бэлэн байгаагаа дахин мэдэгдэнэ.

6.3. Хэрэв дээр дурдсан мэдээллийг хүлээн аваагүй бол Худалдан авагч нь Худалдагчид бараа ачих тээврийн хэрэгслийг зохих хугацаанд нь гаргаж өгөөгүйн төлөө хариуцлага хүлээхээс чөлөөлөгдөх бөгөөд түүнээс болж бэлтгэн нийлүүлэх хугацаа зөрчигдсөний төлөө хариуцлагыг Худалдагч хүлээнэ.

6.4. Тээвэрлэгч нь (хөлөг онгоцны ахмад зэрэг) Худалдагч буюу түүний төлөөлөгчид зохих тээврийн хэрэгслийг ачаа ачих газар (цэг)-т ирэх сар, өдөр, уг тээврийн хэрэгсэлд ачиж болох ачааны тоо хэмжээний тухай мэдэгдсэн байна.

6.5. Хэрэв Худалдагч тээвэрлэгчийн бичгээр өгсөн мэдэгдэлд дурдсан хугацаанд, дурдсан газар (цэг)-т барааг бэлтгэн нийлүүлээгүй буюу зохих тээврийн хэрэгслийн даац, багтаамжид хүргэж ачаа ачаагүй бол Худалдагч, Худалдан авагчид түүний тээврийн хэрэгсэлд төлсөн хөлсийг төлж өгнө. Энэхүү төлсөн хөлсийг Худалдан авагч энэ гэрээний 7-д заасан журмаар эцсийн тооцоо хийхдээ Худалдагчаас суутган авах, эсвэл уул хоосон төлсөн мөнгийг энэ гэрээний 10-д дурдсантай нийцүүлэн, Худалдан авагчийн даалгавраар түүний дансанд, Худалдагч дансаар шилжүүлэн өгөхийн алинаар ч гүйцэтгэж болно.

6.6. Бараа ачих, ачуулахаар ажилласан цагийг тооцох журмыг Талууд, холбогдох байгууллагатай хамтран жич тохиролцоно. Уг тохиролцоог бичгээр үйлдэн энэ гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг _____-р хавсралт болгов.

6.7. Тээврийн хэрэгсэл нь хэрэв усан онгоц бол түүнийг анх удаа зогсоолд тавих зардлыг онгоц өмчлөгч (эзэмшигч) хариуцах бөгөөд үүнд зарцуулсан цагийг ачаа ачсан цагт оруулахгүй.

6.8. Хоёр дахь удаагаас эхний зогсоолд тавих зардлыг Худалдагч төлнө.

6.9. Хэрэв тээврийн хэрэгсэлд ачаа ачих хугацааны норм хэмжээг биелүүлээгүй бол, Худалдагч Худалдан авагчид гэрээнд заасан хэмжээгээр норм хэтрүүлсэн цагийн төлөө торгууль (алданги) төлнө.

6.10. Хэрэв тогтоосон хугацаанаас бага цагт ачсан бол, Худалдан авагч Худалдагчид хугацаа хожимдуулсны төлөө төлөх торгууль (алданги)-ийн _______ хувьтай тэнцэх хэмжээгээр шагнал өгнө.

6.11. Худалдагч Худалдан авагчийн өмнө ачаа тээвэрлэлтэд холбогдох баримт бичгүүд, түүнчлэн ачааг тээврийн хэрэгсэлд ачих, хураах, ялган цэгцлэх ажлын

зөв болохыг хариуцаж, тээврийн хэрэгсэлд ачаа ачих, хураах, ялгаж янзлах ажлын зардал, түүнд ашиглах зүйлийн үнийг Худалдагч гаргана.

6.12. Тээврийн хэрэгсэлд ачаа ачихаар хүлээн авсан тухай баримт бичигт дор дурдсан зүйлийг тодорхойлно:

1. Барааны бүрэн нэр, шошго тэмдэг;
2. Ачааны тоо, барааны цэвэр, бохир жин (ачааг ачуулах үед бүх ачааг тоолж жинлэсэн байна);
3. Нэг боодол ачааны жин (бүх боодол ачааны жин адил байна);
4. Худалдан авагч тээврийн хөлсийг төлсөн тухай тэмдэглэл;
5. Ачаа явуулагч ачуулсан боомт (газар);
6. Ачаа хүлээн авагч байгууллага;
7. Ачаа хүргэх газар (цэг).

6.13. Худалдагч нь ачаатай хамт буюу шуудангаар дор дурдсан баримт бичгийг явуулна.

6.13.1. Тээврийн хэрэгсэлд ачааг ачихаар хүлээн авсан тухай баримт бичгийн үндсэн эхийг ___ хувь, хуулбарыг ___ хувь;

6.13.2. Барааны чанарын тухай гэрчилгээний үндсэн эхийг ___ хувь, хуулбарыг ___ хувь;

6.13.3. Мал эмнэлгийн гэрчилгээний үндсэн эхийг ___ хувь, хуулбарыг ___ хувь;

6.13.4. Барааны жагсаалт-тодорхойлолтын үндсэн эхийг ___ хувь, хуулбарыг ___ хувь;

6.13.5. Бараа үйлдвэрлэсэн орны худалдааны танхимаас өгсөн барааны гарал үүсэл буюу үйлдвэрлэсэн тухай гэрчилгээ;

6.13.6. Усан онгоцонд бол Карго-план (онгоцонд бараа байрлуулах төлөвлөгөө) ___ хувь.

6.14. Мөн усан онгоцоор явуулж байгаа бол онгоц хөдөлж явахаас _____ цагийн өмнө Худалдагч буюу түүний төлөөлөгч Худалдан авагчид телекс буюу факсаар дор дурдсан мэдээллийг явуулна:

6.14.1. Ачуулсан порт, онгоцны нэр;

6.14.2. Барааны нэр;

6.14.3. Гэрээний он, сар, өдөр, дугаар;

6.14.4. Барааг ачихаар хүлээн авсан тухай баримт бичгийн он, сар, өдөр, дугаар;

6.14.5. Ачааны боодлын тоо, цэвэр ба бохир жин.

## 7. Төлбөр төлөх нөхцөл.

7.1. Энэ гэрээгээр бэлтгэн нийлүүлсэн барааны үнийг ачаа ачигдах бүрд түүний үнийн дүнгийн _______ хувийн хэмжээгээр Монгол Улсын холбогдох банк дор дурдсан баримт бичгийг хүлээн авсан өдөрт ________________________ ________________________________ (валютаар) төлнө:

7.1.1. Ачуулсан барааны бүрэн үнийн талаар Худалдагчийн хийсэн тооцоо __ хувь;

7.1.2. Ачааг ачихаар хүлээн авсан тухай тээвэрлэх байгууллагын өгсөн баримт бичгийн үндсэн эх ___ хувь, хуулбар ___ хувь;

7.1.3. Барааны чанарын гэрчилгээ ___ хувь;

7.1.4. Хөндлөнгийн хяналтын байгууллагын гэрчилгээ ___ хувь;

7.1.5. Мал эмнэлгийн гэрчилгээ ___ хувь;

7.1.6. Ариун цэврийн гэрчилгээ ___ хувь;

7.1.7. Барааны үүсэл гарлын тухай гэрчилгээ ___ хувь;

7.1.8. Жагсаалт-тодорхойлолт ___ хувь.

Дээр дурдсан бүх баримт бичгүүдэд энэ гэрээний он, сар, өдөр, дугаарыг бичсэн байна.

7.2. Барааг Монголын ачаа хүлээн авах газар (цэг)-т буулгаж дууссаны дараа хэрэв Монголын үйлдвэр-Худалдааны танхимын дүгнэлт, Худалдан авагчийн эцсийн тооцоогоор өглөгтэй байвал, Худалдан авагч Худалдагчийн дансанд барааны үнийн төлөөгүй үлдэгдэл ____ хувийг шилжүүлэх замаар төлнө.

7.3. Эцсийн тооцоо хийх, мөнгө шилжүүлэх үедээ Худалдан авагч энэ гэрээний нөхцөлд заасан ёсоор Худалдагчаас авбал зохих торгууль, хорогдуулсан үнэ, бусад хохирлоо суутган авах эрхтэй.

7.4. Хэрэв Худалдан авагчийн суутгах мөнгөний хэмжээ ирүүлсэн нэгэн бүлэг барааны үнийн дүнгийн ____ хувиас хэтэрвэл, Худалдан авагч нь уул мөнгийг өөр бүлэг барааны үнээс суутган авах, эсвэл Худалдагч Монголын ______________________ банк дахь Худалдан авагчийн дансанд шилжүүлэхийн аль нэгээр Худалдагчийн эцсийн тооцоог хүлээн авсан өдрөөс хойш _______ хоногийн дотор шийдвэрлэнэ.

7.5. Банкны, түүний дотор банкны комиссын бүх зардлыг Монгол Улсын нутаг дээр бол Худалдан авагч, өөр улсын нутаг дээр бол Худалдагч гаргана.

## 8. Маргааныг хянан шийдвэрлэх журам

8.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 9. Давагдашгүй хүчин зүйл

9.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

9.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 10. Бусад нөхцөл.

10.1. Энэ гэрээнд гарын үсэг зурсны дараа энэ талаар урьдын хийж байсан хэлцэл, бичиж байсан бичиг захидал хүчингүй болсонд тооцогдоно.

10.2. Энэ гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт нь зөвхөн Талууд тохиролцон, бичгийн хэлбэрээр үйлдэж, тэдгээрийн эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурсны үндсэн дээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

10.3. Энэ гэрээг биелүүлэхтэй холбогдох бүх мэдэгдэл, мэдээлэл, зарлалыг Талууд нэг нь нөгөөдөө гэрээнд дурдсан хаягаар явуулна.

10.4. Талуудын аль нь ч нөгөө талын бичгийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ бусдад шилжүүлэхгүй.

10.5. Хэрэв Худалдагч гэрээний нөхцөлийг зөрчсөн бол, тэрээр түүнээс болж Худалдан авагчид учирч болох бүх хохирлыг төлөхийн зэрэгцээ уг зөрчил гаргасны учир гэрээнд заасан үнийн дүнгийн дор дурдсан хувьтай тэнцэх хэмжээгээр торгууль төлнө:

10.5.1. Энэ гэрээний 3-т дурдсан хугацаанд барааг бүхэлд нь буюу зарим хэсгийг нийлүүлж чадаагүй бол Худалдан авагчид доорх хэмжээгээр торгууль төлнө:

10.5.1.1. Хугацаа хожимдуулсан эхний ____ хоногт ____ хувийн торгуулийг хожимдуулсан өдөр бүр;

10.5.1.2. Хугацаа хожимдуулсан дараачийн ____ хоногт ____ хувийн торгуулийг өдөр бүр;

10.5.1.3. Цаашид ____ хувийн торгуулийг өдөр бүр.

10.5.2. Барааны чанар, сав, баглаа боодол, шошго тэмдгийн талаарх гэрээний шаардлагыг зөрчсөн бол, Худалдан авагч, тэдгээрийн үнийг бууруулсан эсэхийг харгалзахгүйгээр ____ хувийн торгууль;

10.5.3. Ачуулсан барааны тухай Худалдагч Худалдан авагчид мэдэгдээгүй, эсвэл цаг тухайд нь мэдэгдээгүй буюу бүрэн мэдээлэл өгөөгүй бол ____ хувийн торгууль;

10.5.4. Хэрэв уг бараа ачсан тээврийн хэрэгсэл уул ачааг хүлээн авах газар (цэг)-т ирэхэд тэрхүү газар (цэг)-т энэ гэрээний 6-д дурдсан тээвэрлэлтийн баримт бичгийн аль нэг нь бэлэн байгаагүй (Худалдагч өгөөгүй) бол, тэр ирсэн өдрөөс эхлэн зохих баримт бичгийг тэнд хүлээн авсан өдөр хүртэл _________ хувийн торгууль өдөр бүр;

10.5.5. Хэрэв энэ гэрээний 7-д дурдсан ямар нэгэн баримт бичгийг энэ гэрээний нөхцөл зөрчин үйлдсэн бол ___ хувийн торгууль;

10.5.6. Энэ гэрээний 6-д дурдсан тээврийн хэрэгсэлд ачаа ачих, хураах, ялгаж янзлах талаар заасан шаардлагыг зөрчсөн бол ____ хувийн торгууль;

10.5.7. Худалдагчаас гэрээний үүрэг, нөхцөлийг зөрчсөн бусад тохиолдолд ____ хувийн торгууль төлнө.

10.6. Дээр дурдсан торгууль болон учирч болох бүх хохирлыг төлөх нь Худалдагчийг гэрээний үүргээ бодитойгоор биелүүлэх үүргээс чөлөөлөхгүй.

10.7. Худалдагч хохирол арилгах, торгууль төлөх тухай Худалдан авагчийн шаардлагыг хүлээн авснаас хойш ___ хоногийн дотор биелүүлнэ. Хэрэв энэ

шаардлагыг Худалдагч биелүүлээгүй бол тэдгээр шаардлагын үнийн дүнгийн ____ хувьтай тэнцэх хэмжээгээр Худалдан авагчид өдөр бүр торгууль төлнө.

10.8. Гааль, татвар болон энэ гэрээг байгуулах, биелүүлэхтэй холбогдсон бусад зардлыг Монгол улсын нутаг дээр бол Худалдан авагч, бусад улсын нутаг дээр бол Худалдагч хариуцна.

10.9. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь, ______________________ хэл дээр үйлдэж, гарын үсэг зуран, нэг хувийг Худалдагч, нөгөө хувийг Худалдан авагч хадгалав.

## 11. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

11.1. Худалдагч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ________________________________.

11.2. Худалдан авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ________________________________.

11.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

**ГАДААДАД БАРАА БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас ____________________ ________________________________________

*(Үйлдвэрийн нэр, хаяг)*

(цаашид "Үйлдвэр" гэнэ), түүнийг ___ ________________үндсэн дээр төлөөлөн

*(төлөөлсөн хүний албан тушаал. нэр)*

Нөгөөталаас ____________________________________________________________

*( худалдааны байгууллагын нэр. хаяг)*

(цаашид "Гадаад худалдааны байгууллага" гэнэ). түүнийг______________ ____________________________________________ үндсэн дээр төлөөлөн ___________________________________ _,

*(төлөөлсөн хүний албан тушаал. нэр)*

Бид энэхүү гэрээг дор дурьдсан нөхцөлтэйгөөр байгуулав. Үүнд:

1. Үйлдвэр *(барааны нэр, тоо хэмжээ, нэр төрөл, иж бүрдлийг бичих)* барааг бэлтгэн нийлүүлж, Гадаад худалдааны байгууллага түүнийг гадаадад худалдахад зориулан хүлээн авч, зохих үнийг төлнө.
2. Барааны чанар нь *(олон улсын стандарт, үндэсний стандарт, техникийн нөхцлийг баталсан байгууллагын нэр. баталсан он. сар, өдөр.дугаар, индекс, загварын тодорхойлолт. Тэдгээрийг үзүүлэх, хадгалах журам, тэрчлэн халуун болон чийглэг уур амьсгал бүхий улс оронд гаргах бараанд зориулан тогтоосон тусгай нөхцлийг нэрлэн бичих)* баримт бичгүүдэд дурьдсан шаардлагыг хангасан байна.
   a. Бэлтгэн нийлүүлж буй барааны чанарт тавих нэмэлт шаардлага:
   b. Барааны чанар нь энэ гэрээ болон гадаадын худалдан авагчтай байгуулсан гэрээний нөхцөлд нийцэж байгаа болохыг (үйлдвэрлэгч буюу тогтоосон журмаар бусад байгууллагуудаас олгосон гэрчилгээ буюу өөр баримт бичгээр)-ээр батлана.
3. Үйлдвэр нь барааг баталгаат хугацаанд ашиглах боломжийг хангахуйц эд ангийг тусгайлан бэлтгэн нийлүүлэх бөгөөд (баталгаат хугацаа дууссаны дараа уул барааг ашиглахад шаардагдах эд ангийн нэр төрөл. тоо хэмжээг бичнэ)-ийг бэлтгэн нийлүүлэх үүрэг хүлээнэ.
4. Үйлдвэр нь (Улсын хилээр гадагш гарсан өдрөөс буюу өөр ямар үеэс баталгаат хугацааг тоолохыг дурьдана)-ээс эхлэн тоологдсон баталгаат хугацааны дотор барааны чанарын төлөө хариуцлага хүлээнэ.
5. Баталгаат хугацаа _________-ээс _________ хүртэл байх болно.

6. Үйлдвэр барааг гадаадад гаргахаар зориулан ачуулснаас хойш 2 хоногийн дотор гадаад худалдааны байгууллагад зохих тооцооны баримт-төлбөрийн даалгавар болон бусад ________________ баримт бичгийг явуулна.
7. Талуудын үнийн тооцоог ________________________________________ (үнийн талаар Талууд заавал баримталбал зохих баримт бичгийг баталсан байгууллага. баримт бичгийн он, сар, одөр, нэр буюу эсвэл Талууд бие даан тогтоосон үнийн тухай бичнэ)-д заасныг баримтлан хийнэ.
8. Гадаад худалдааны байгууллага нь доорхи тохиолдолд акцептээр тооцоо хийх, төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй:

   ____________________________________________________________

9. Доорхи журмаар Гадаад худалдааны байгууллагад ашигтайгаар суутгал хийнэ:

   ____________________________________________________________

10. Бэлтгэн нийлүүлэх ажлыг доорхи хугацаанд хийнэ:

    *(улирал, сар бүрд ижил хэмжээгээр, эсвэл арав хоног буюу хоног тутамд ижил хэмжээгээр, тохиролцсон графикаар гэх зэргээр)*

11. Үйлдвэр барааг, Гадаад худалдааны байгууллагаас барааг ачуулах нь чухал болсныг дурьдсаны дээр түүнд шаардагдах бүхий л тоо баримтыг агуулсан мэдээлэлтэй нийцсэн бөгөөд гэрээгээр тогтоосон хугацаанд бэлтгэн нийлүүлнэ.
12. Зөвхөн Гадаад худалдааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр барааг хугацаанаас өмнө бэлтгэн нийлүүлнэ.
13. Үйлдвэр барааг Гадаад худалдааны байгууллагад хүлээлгэн өгөхдөө доорхи журмаар гүйцэтгэнэ: (барааг хүлээлгэн өгөх газар (цэг), барааг тээвэрлэх арга, нөхцлийг энд бичнэ).
14. Үйлдвэр нь барааг ачуулахад бэлэн болсноо Гадаад худалдааны байгууллагад дараахи журмаар мэдэгдэнэ. Үүнд:

    ____________________________________________________________

15. Барааны сав, баглаа боодол нь (Стандарт, техникийн нөхцөл, бусад техникийн баримт бичиг, сав. баглаа боодолд тавих бусад тодорхой шаардлагыг бичих)-нд нийцсэн байна.
16. Бараанд (бэхэлсэн пайз дээр буюу бусад тэмдэг шошго хийх аргыг энд бичих) аргаар тавина.
17. Үйлдвэр барааг тээвэрлэх болон түүний бүрэн бүтэн байдлыг хангахын тулд дараахи аргыг хэрэглэнэ: (чингэлэг хэрэглэх, боож баглах, бусад арга).
18. Ачаа тээврийн реквизит:

(Хэрэв эдгээр нь гэрээ байгуулах үед мэдэгдэж байгаа бол бичнэ). Техникийн ба барааг дагалдах баримт бичигт доорхи зүйлийг; (хууль тогтоомжинд заасан зохих баримт бичгийн төрөл, гадаадын худалдан авагчийн шаардлагыг харгалзан үзсэн тохиролцоо болон барааны чанар байдлыг тодорхойлж буй бусад баримт бичгийг энд

нэрлэн бичнэ) багтаах бөгөөд тэдгээрийг ________________________________ журмаар үйлдэх ба тараан хүргүүлнэ.

19. Техникийн ба бараач дагалдан явах баримт бичгүүдийг нь Монгол болон _________________ хэл дээр үйлдэнэ.

20. Үйлдвэр барааг ачуулахаас өмнө өөрийн зардлаар машин, хэрэглэл, тоног төхөөрөмжийг ашиглах, засварлах хөтлөл. заавар, тэрчлэн тэдгээрийн эд ангийн каталогийг хэвлүүлнэ. Каталогит машины бүх эд ангийг багтаан жагсаана.

Хөтлөл, заавар, каталогийг Монгол, _______________хэл дээр бичнэ.

21. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

22. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

23. Энэ гэрээ ________ үеэс хүчин төгөлдөр болж, _________ хугацаанд үйлчилнэ.

24. Энэ гэрээний нэмэлт нөхцөл:

____________________________________________________________

25. Энэ гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг мөн.

1. ____________________________________________________________
2. ____________________________________________________________
3. ____________________________________________________________

26. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

26.1 Үйлдвэр талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ___________________________________.

26.2 Гадаад худалдааны байгууллага талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: _____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: ____________________

Банк дахь тооцооны дансны дугаар: ____________________________________.

26.3 Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ҮЙЛДВЭРИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГАДААД ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# ДИСТРИБЬЮТЕРИЙН ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас, ............................…. улсын хуулийн дагуу хуулийн этгээд болох ................................. компани /цаашид “Бэлтгэн нийлүүлэгч” гэгдэх/ түүнийг төлөөлөн………........................., нөгөө талаас .................................. улсын хуулийн дагуу хуулийн этгээд болох ................................... компани /цаашид “Дистрибьютор” гэгдэх/ түүнийг төлөөлж ………….......................... дараах нөхцөлөөр харилцан тохиролцож дор дурдсан гэрээг байгуулав. Үүнд:

## 1. Гэрээний зүйл ба газар нутаг

1.1. Энэ гэрээгээр Бэлтгэн нийлүүлэгч нь энэ гэрээний салшгүй хэсэг болох Хавсралтад заасан бараа бүтэгдэхүүнийг /цаашид бараа бүтээгдэхүүн гэх/ дистрибьютерт шилжүүлэх, түүнээс гадна эдгээр бараа бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг өгөх үүргийг, дистрибьютер нь Хавсралтад заасан газар нутгийн хүрээнд эдгээр бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах ажлыг зохион байгуулж, хэрэглэгчдийг бараа бүтээгдэхүүний талаар тодорхой мэдээллээр хангах үүргийг тус тус хүлээнэ.

1.2. Хэрвээ Бэлтгэн нийлүүлэгч нь дээр дурдсан газар нутгийн хүрээнд өөр бараа бүтээгдэхүүн борлуулахаар шийдсэн бол энэ талаар Дистрибьютерт Хавсралтад заасан бараа бүтээгдэхүүнд өөр бараа бүтээгдэхүүн оруулж болох боломжийг хэлэлцэх зорилгоор заавал мэдэгдэнэ.

## 2. Шударга өрсөлдөөн

2.1. Талууд энэ гэрээний үүргээ биелүүлэхдээ шударга өрсөлдөөний зарчмыг баримтална.

2.2. ________________________________________________________________

## 3. Дистрибьютерийн эрх, үүрэг

3.1. Бараа бүтээгдэхүүнийг өөрийн нэрийн өмнөөс өөрийн зардлаар борлуулах

3.2. Дистрибьютер нь Бэлтгэн нийлүүлэгчийн бодлогын дагуу бараа бүтээгдэхүүн борлуулахад үзүүлэх тус дэмжлэгийг хүлээн авахыг зөвшөөрөх

3.3. Дистрибьютер нь Бэлтгэн нийлүүлэгчийн урьдчилан эрх олгосноос бусад тохиолдолд түүний нэрийн өмнөөс эсвэл түүний эрх ашгийн тулд ажиллах эрхгүй.

3.4. Дистрибьютер нь бараа бүтээгдэхүүнийг өөрөө худалдан авч цааш нь борлуулахаас гадна Бэлтгэн нийлүүлэгчийг хэрэглэгчтэй шууд холбох зуучлалын үйл ажиллагаа явуулж болно. Дистрибьютер нь зуучлалын үйл ажиллагаа явуулах бүрдээ Хавсралтад заасан шимтгэлийг авна.Ийнхүү зуучлалын үйл ажиллагаа явуулах нь дистрибьютерийн бараа бүтээгдэхүүнийг өөрийн нэрийн өмнөөс өөрийн зардлаар борлуулдаг эрх зүйн статусыг өөрчлөхгүй.

## 4. Бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Дистрибьютер энэ гэрээ үйлчлэх хугацаанд дээр дурдсан газар нутаг дээр Хавсралтад заасан бараа бүтээгдэхүүнтэй өрсөлдөх бараа бүтээгдэхүүнийг Бэлтгэн нийлүүлэгчийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, сурталчлах, худалдах эрхгүй.

4.2. Дистрибьютер нь Хавсралтад заасан бараа бүтээгдэхүүнтэй өрсөлдөхгүй бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, сурталчлах, худалдах эрхтэй ба энэ тухайгаа Бэлтгэн нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэх ёстой.

4.3. ________________________________________________________________

## 5. Барааны худалдааг зохион байгуулах

5.1. Дистрибьютер нь өөрийн газар нутгийн хүрээнд шаардлага хангасан худалдааг зохион байгуулж, тохирсон худалдааны дараах үйлчилгээг үзүүлнэ.

5.2. Талууд Хавсралтад өөрийн үйлчлүүлэгч нарын нэрийг зааж болно.

## 6. Зар сурталчилгаа ба үзэсгэлэн

6.1. Талууд жил бүр зар сурталчилгааны төлөвлөгөөг урьдчилан хэлэлцэнэ. Бүх зар сурталчилгаа Бэлтгэн нийлүүлэгчийн имидж болон маркетингийн бодлогын дагуу явагдана. Талуудын харилцан зөвшилцөн явуулж байгаа зар сурталчилгааны үнийг Хавсралтад заасны дагуу талууд хувааж төлнө. Өөрөөр хэлбэл, тал бүр өөрийн явуулсан зар сурталчилгааны зардлыг даана.

6.2. Талууд дистрибьютерийн газар нутаг дээр зохиогдож байгаа худалдааны үзэсгэлэн, яармагт нөгөө талыгаа оролцохыг хүлээн зөвшөөрнө. Энэ үзэсгэлэн, яармагт оролцох дистрибьютерийн зардлыг талууд Хавсралтад зааснаар хувааж төлнө.

## 7. Бэлтгэн нийлүүлэлтийн нөхцөл – үнэ

7.1. Бэлтгэн нийлүүлэгч нь захиалсан бүх барааг нийлүүлэх, дагалдах бичиг баримтыг хавсаргах, чанарын баталгаанд дурдсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг хангах үүрэгтэй. Бэлтгэн нийлүүлэгч Дистрибьютерийн захиалгыг хүлээж авахаас татгалзаж болно.

7.2. Бэлтгэн нийлүүлэгч нь хүлээн авсан захиалгаа биелүүлэхэд бүх хүч чармайлтаа гаргана.

7.3. Энэ гэрээнд хавсаргасан Бэлтгэн нийлүүлэгчийн худалдах, худалдан авах ерөнхий нөхцөлийн дагуу бараа бүтээгдэхүүнийг Дистрибьютерт худалдана. Ерөнхий нөхцөл болон энэ гэрээний нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд энэ гэрээний заалтыг хэрэглэнэ.

7.4. Дистрибьютер нь Бэлтгэн нийлүүлэгч захиалгыг хүлээн авах үед хүчинтэй байсан Бэлтгэн нийлүүлэгчийн үнийн жагсаалт болон Хавсралтад заасан хямдралын дагуу бараа бүтээгдэхүүний үнийг төлнө.

7.5. Дистрибьютер нь талууд хоорондоо зөвшилцсөн төлбөр хийх хугацааг дагаж мөрдөнө.

7.6. Бэлтгэн нийлүүлэгч төлбөрийг бүрэн хүлээн автал шилжүүлсэн бараа бүтээгдэхүүн Бэлтгэн нийлүүлэгчийн өмчид хэвээр үлдэнэ.

## 8. Худалдах, худалдан авах төлөвлөгөө

8.1. Талууд ирж буй оны худалдах, худалдан авах төлөвлөгөөг жилд нэг удаа тохиролцож болно.

8.2. ______________________________________________

8.3. ______________________________________________

## 9. Субдистрибьютер ба агент

9.1. Дистрибьютер нь Бэлтгэн нийлүүлэгчид урьдчилан мэдэгдсэнээр өөрийн газар нутгийн хүрээнд бараа бүтээгдэхүүнийг борлуулах субдистрибьютер эсвэл агентыг томилж болно.

9.2. Дистрибьютер нь өөрийн томилсон субдистрибьютер эсвэл агентыг хариуцах үүрэгтэй.

## 10. Бэлтгэн нийлүүлэгчийг мэдээллээр хангах

10.1. Дистрибьютер нь өөрийн үйл ажиллагаа, зах зээлийн нөхцөл, төрийн эрх мэдлийн талаар Бэлтгэн нийлүүлэгчид мэдээлнэ. Бэлтгэн нийлүүлэгчийн мэдээлэл гаргаж өгөх тухай хүсэлтэд дистрибьютер хариулт өгөх үүрэгтэй.

10.2. Дистрибьютер нь дараах мэдээллүүдийг Бэлтгэн нийлүүлэгчид гаргаж өгнө. Үүнд: тухайн газар нутаг дээр үйлчилж байгаа бараа бүтээгдэхүүнтэй

холбоотой хууль тогтоомж, /тухайлбал, экспорт, импорт, барааны тэмдэгт, барааны гарал үүсэл, барааны аюулгүйн байдлын стандартын тухай зэрэг болно/, Бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой дистрибьютерийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж болно.

## 11. Дамжуулан худалдах үнэ

11.1. Дистрибьютер Бэлтгэн нийлүүлэгчийн тогтоосон дээд үнийг харгалзан бараа бүтээгдэхүүнийг дамжуулан худалдах үнийг өөрөө чөлөөтэй тогтооно.

11.2. ____________________________________________________________

## 12. Гэрээнд заасан газар нутгаас гадуур худалдаа

12.1. Дистрибьютер гэрээнд заасан газар нутгаас гадна орших үйлчлүүлэгч нарт бараа бүтээгдэхүүнийг худалдахгүй. Эдгээр үйлчлүүлэгчдээс ирсэн бүх эрэлт хэрэгцээ шаардлагыг дистрибьютер бэлтгэн нийлүүлэгчид дамжуулах үүрэгтэй.

## 13. Бэлтгэн нийлүүлэгчийн худалдааны тэмдэг

13.1. Дистрибьютер Бэлтгэн нийлүүлэгчийн худалдааны нэр, худалдааны тэмдэг болон бусад симболыг хэрэглэх үүрэгтэй. Гэхдээ энэ нь зөвхөн энэ гэрээний үйлчлэлийн хүрээнд Бэлтгэн нийлүүлэгчийн ашиг сонирхлын үүднээс бараа бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилготой.

13.2. Дистрибьютер өөрийн газар нутаг болон үүнээс өөр хаана ч гэсэн Бэлтгэн нийлүүлэгчийн худалдааны нэр, худалдааны тэмдэг болон бусад симболыг бүртгүүлэх шаардлагагүй.

13.3. Дистрибьютер өөрийн газар нутгийн хүрээнд бэлтгэн нийлүүлэгчийн худалдааны нэр, худалдааны тэмдэг, бусад симбол болон өмчлөх эрхийг зөрчиж байгаа үйлдлийн талаар бэлтгэн нийлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

13.4. Дистрибьютер бараа бүтээгдэхүүнээ интернэтээр чөлөөтэй сурталчлах эрхтэй. Гэхдээ энэ үед бэлтгэн нийлүүлэгчийн урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр түүний худалдааны нэр, худалдааны тэмдэг болон бусад симболыг хэрэглэж болохгүй.

## 14. Мэдээллийн нууцыг хадгалах

14.1. Талууд энэ гэрээний талаар аль нэг тал нь нууцлахыг хүссэн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.

14.2. Нууц мэдээлэл гэдэг нь нэг тал нөгөөдөө гаргаж өгсөн, тухайн мэдээлэл нууц гэдгийг зааж өгсөн, мэдээллийг хэлнэ.

### 15. Бараа бүтээгдэхүүний нөөц ба худалдааны дараах үйлчилгээ

15.1. Дистрибьютер энэ гэрээний үйлчлэх хугацаанд өөрийн зардлаар Хавсралтад заасан тохиолдлуудад шаардлагатай бараа бүтээгдэхүүний нөөцийг тасралтгүй байлгана.

15.2. Дистрибьютер хавсралтад заасан хугацаа, нөхцөлийн дагуу худалдааны дараах үйлчилгээг үзүүлнэ.

### 16. Дистрибьютерийн харилцаа

16.1 ____________________________________________________________

### 17. Шууд худалдаа

17.1. Бэлтгэн нийлүүлэгч хавсралтад заасан тусгай хэрэглэгчидтэй шууд харьцах эрхтэй байж болно. Энэ үед дистрибьютер хавсралтад заасан шимтгэлийг авах эрхтэй.

17.2. ____________________________________________________________

### 18. Дистрибьютерийг мэдээллээр хангах

18.1. Бэлтгэн нийлүүлэгч Дистрибьютерт энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай бараа бүтээгдэхүүнд хамааралтай бүх баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргаж өгнө. Энэхүү гэрээ дуусгавар болоход дистрибьютер эдгээр баримт бичгүүдийг бэлтгэн нийтүүлэгчид буцаан өгнө.

18.2. Бэлтгэн нийлүүлэгч дистрибьютерийг энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүх мэдээллээр хангана.

18.3. Бэлтгэн нийлүүлэгч Дистрибьютерийг түүний газар нутаг дээрх хэрэглэгчтэй холбоо харилцааны талаарх мэдээллээр хангах үүрэгтэй.

### 19. Гэрээний үйлчлэх хугацаа

19.1. Энэхүү гэрээ нь _____________хүчин төгөлдөр болох ба уг гэрээний 19.2 эсвэл 20-р зүйлд заасан хугацаа хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна. Гэхдээ ямар ч тохиолдолд уг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс таван жилийн дараа гэрээ дуусгавар болно. Энэ таван жил дуусахаас өмнөх сүүлийн гурван сард энэ гэрээг дуусгавар болсны дараа шинэ гэрээ байгуулах боломжтой эсэх талаар хэлэлцэх зорилгоор талууд уулзаж харилцан тохиролцоно.

19.2. Энэхүү гэрээг аль нэг тал __-аас доошгүй сарын өмнө бичгээр урьдчилан мэдэгдсэнээр хэзээ ч дуусгавар болж болно.

### 20. Бизнесийн нэр төрийн баталгаа

20.1. Энэхүү гэрээ дуусгавар болсон тохиолдолд дистрибьютер бизнесийн нэр төрийн нөхөн төлбөр эсвэл түүнтэй адилтгах нөхөн төлбөрийг хийх үүрэггүй.

20.2. Дээрх заалт нь дистрибьютерийн уг зөрчсөнөөс үүсэх хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхэд нөлөөлөхгүй.

## 21 Бичиг баримт болон нөөцөд байсан бараа бүтээгдэхүүнийг буцаах

21.1. Энэхүү гэрээний хугацаа дуусахад дистрибьютер бэлтгэн нийлүүлэгчийн түүний эзэмшилд өгсөн зар сурталчилгааны материал болон бусад бичиг баримтыг бэлтгэн нийлүүлэгчид буцаан өгнө.

21.2. Дистрибьютерийн хүсэлтээр бэлтгэн нийлүүлэгч нь дистрибьютерийн нөөцөд авсан шинээрээ сав баглаа боодолтойгоо байгаа бүх бараа бүтээгдэхүүнийг түүнд худалдсан үнээр эргүүлэн худалдаж авна.

## 22. Давагдашгүй хүчин зүйл

22.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт /-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

22.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 23. Маргааныг зохицуулах журам

23.1 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 24. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

24.1 Энэхүү гэрээний нөхцөлийг талуудын хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан баримт бичгийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж болно. Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

## 25. Талуудын хоорондох харилцаа

25.1. Энэ гэрээтэй холбоотой асуудлаар харилцах Талуудын эрх бүхий төлөөлөгчдөөр доорх хүмүүсийг томилов:

| Бэлтгэн нийлүүлэгч талын: | Дистрибьютер талын : |
|---|---|
| Нэр: | Нэр: |
| Албан тушаал: | Албан тушаал: |
| Утасны дугаар: | Утасны дугаар: |
| Цахим шуудангийн хаяг: | Цахим шуудангийн хаяг: |

## 26. Тусгай нөхцөл

______________________________________________________________

______________________________________________________________

## 27. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

27.1. А талын :

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: __________________________________________________.

Утас: ____________ телетайп: ________________

Факс: _________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

27.2. Б талын:

Оршин байгаа газар: ____________________________________________.

Хаяг, индекс: __________________________________________________.

Утас: ____________ телетайп: ________________

Факс: _________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

27.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

## 28. Гэрээний хавсралт

Барааны тухай мэдээллийг заасан Хавсралт нь тус гэрээний салшгүй хэсэг болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

ДИСТРИБЬЮТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:

______________________________

*(гарын үсэг, тамга, тэмдэг)*

*Нэр*

*Албан тушаал*

## ФРАНЧАЙЗИЙН /бүтээл ашиглах, зөвшөөрөл/ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас:

______________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Зөвшөөрөл олгогч" гэнэ/, түүнийг______________________________үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

Нөгөө талаас :

______________________________________________________

(хуулийн этгээдийн нэр, хаяг)

/цаашид "Зөвшөөрөл авагч" гэнэ/, түүнийг ____________________________ үндсэн дээр төлөөлөн

______________________________________________________

(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)

нар энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 333-338 дугаар зүйлийг удирдлага болгон дор дурдсан нөхцөлөөр байгуулав. Үүнд:

### 1. Гэрээний зүйл

1.1. Энэ гэрээг __________________________________________ -ийн зах зээл дээр

/ газар нутгийн нэрийг заах /

бараа борлуулах, үйлчилгээ явуулах ажлыг амжилттай явуулах, эдийн засгийг аль болох өндөр үр дүнд хүргэх, талуудын ажил хэрэгч хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын дор байгуулж байна.

1.2. Зөвшөөрөл авагч, Зөвшөөрөл өгөгчийн худалдааны тэмдэг бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах систем нь өөрийн өндөр чанартайг батлалсныг харгалзан Зөвшөөрөл олгогчтой үйлдвэрлэлийн болон ажил хэргийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, түүний тулд _______________________________________ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ажилд оролцох, энэ үйл ажиллагаанд Зөвшөөрөл олгогчтой үйлдвэрлэлийн арга, туршлагыг хэрэглэх, түүний техникийн тусламжийг ашиглахыг хүсч байна.

/бүтээгдэхүүний нэр/

1.3. Талууд ажил хэргийн дараах зорилтуудтай болохоо санал нэгтэй тэмдэглэж байна. Үүнд:

a. үйлдвэрлэлийг тусгайлан мэргэжүүлэх болон хөдөлмөрийг зохистой хуваарилах

b. үйлдвэрлэлийн хөтөлбөрийг өргөжүүлэн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх

c. нэгж бүтээгдэхүүнийг өөрийн өртөг, түүхий эд, бусад материалын худалдан авах үнийг хямдруулсны үндсэн дээр үйлдвэрлэлд хэмнэлттэй байдлыг хангах

d. зах зээлийн шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааны уян хатан байдлыг хангах

e. зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй байгаа шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түргэн эзэмших

f. ____________________________________________

## 2. Үйлдвэрлэлийг төлөөлөх ба хөгжүүлэх

2.1. Энэ гэрээний нэгд дурдсан хамтын зорилтыг биелүүлэхийн тулд дараах тохиролцоонд хүрэв. Үүнд:

a. Гэрээ ёсоор бидний ажил хэргийн харилцаа нь өдөр тутмын хамтын ажиллагаа, харилцан туслалцаа үзүүлэх явдалд үндэслэх

b. Харилцан бараа солилцох, үйлчилгээ үзүүлэх, үнэ тогтооход зах зээлийн шалгуур, зарчмыг баримтлах

c. Зөвшөөрөл авагч нь үйлдвэрлэлийг төлөвлөх, хөгжүүлэх ажлыг Зөвшөөрөл олгогчийн саналыг харгалзан түүнтэй ижил арга зүйгээр явуулах

d. Талууд энэ гэрээгээр хамтран ажиллах гол зүйл болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах ажлыг нэгтгэн зохицуулах, аж ахуйн үйл ажиллагаанд нэг арга зүйгээр төлөвлөх талаар бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллах болно.

## 3. Франчайзийн /бүтээл ашиглах, зөвшөөрөх / зорилго

3.1. Энэ гэрээний зорилго нь үйлдвэрлэл явуулах, бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагаанд Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагчийн хамтын ажиллагаа, хүч хэрэгслийг нэгтгэн зохион байгуулж хэрэгжүүлэх явдал мөн.

3.2. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тусламж үзүүлэх хүрээнд үйлдвэрлэлийн Франчайзинг нь дор дурдсан асуудлыг өөртөө багтаав.

a. Эрх бүхий байгууллагаас үйлдвэрлэлийн байршлын талаар зөвшөөрөл авахад зориулан техникийн нөхцөлийг тодорхойлон хангах талаар хамтран ажиллах

b. ажилтнуудыг сургах хөтөлбөр боловсруулах, уг сургалтыг зохион байгуулах

c. объектыг ашиглалтад оруулах, ажиллуулахад зориулсан баримт бичгээр хангах

d. үйлдвэрлэлийн хөтөлбөр ажлын төлөвлөгөө боловсруулах

e. үйлдвэрийн өөрийн нэр, хамгаалалтын тэмдэг ашиглах эрхийн тухай асуудлын зохицуулах

3.3. Энэ гэрээний 3.2т дурдсан арга хэмжээ нь Зөвшөөрөл олгогчоос үзүүлэх “багц үйлчилгээ”-г бүрдүүлэх бөгөөд гэрээний үнийг талууд тохиролцон ________________-д тодорхойлно.

## 4. Зөвшөөрөл авагчийн үүрэг

4.1. Зөвшөөрөл авагч нь Франчайзингийн хүрээнд хамтын үйл ажиллагаа явуулахад зориулан дараах хэрэгслийг бэлтгэн өгөх үүрэгтэй.

a. санхүүгийн хэрэгсэл болгон ___ төгрөг

b. үйлдвэрийн байр тоног төхөөрөмж

c. үйлдвэрлэлийн хэрэгцээ, шаардлагын хэмжээгээр ажиллах хүчин

4.2. Зөвшөөрөл олгогчийн үйлдвэрлэлийн хөтөлбөрөөр ажиллах

4.3. Франчайзингийн зүйл дээр ажилладаг үйлдвэрүүд дээр үйлдвэрийн өөрийн __________ нэр, ________________ хамгаалалтын тэмдэгтэйгээр ажиллах

4.4. Үйлдвэрлэх, борлуулах явцад Зөвшөөрөл олгогчийн баримт бичигт дурдсан нөхцөл, шаардлагад онцгой анхаарал тавьж ажиллах

4.5. Зөвшөөрөл олгогчийн нууцад тооцсон бүх баримт бичгийг үйлдвэрлэлийн нууцын нэгэн адилаар хадгалан хамгаалах

4.6 Зөвшөөрөл авагч багц үйлчилгээ үзүүлсний төлөө Зөвшөөрөл олгогчид энэ гэрээний агуулгад болсон хамтран зохион байгуулсан үйлдвэрлэлийг үйл ажиллагааны төлөвлөгөөт хэмжээ /борлуулах бүтээгдэхүүнийг оролцуулан/-ны зохих хувиар шагнал төлнө. Эхний удаагийн шагнал нь Зөвшөөрөл олгогчийн энэ гэрээний 2-т заасан үйл ажиллагааны зардлыг нөхөх ёстой бөгөөд дээр өгүүлсэн хэмжээний _______ хувьтай тэнцэхээр байна.

4.7 Зөвшөөрөл авагч нь Зөвшөөрөл олгогчид гэрээ, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрт дурдсан техникийн тусламж үзүүлсэн, бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах болон хөдөлмөр, үйлдвэрлэлийг зохион байгуулахтай холбогдсон үйлчилгээ үзүүлсэн зардлыг нөхөхөөр урсгал шагнал /комисс/-ийг төлөх үүрэгтэй.

4.8 Зөвшөөрөл авагч ажилтныг сургахын тулд үндэслэл бүхий бөгөөд жинхэнэ гаргасан зардлыг төлнө.

## 5. Зөвшөөрөл олгогчийн үүрэг

5.1. Зөвшөөрөл олгогч нь энэ гэрээнд заасан ёсоор үйлдвэрлэлийн хамтын үйл ажиллагаа явуулах зорилгоор Зөвшөөрөл авагчид багц үйлчилгээ үзүүлнэ.

5.2. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийн хөтөлбөр боловсруулахын зэрэгцээгээр энэ гэрээнд дурдсан үйл ажиллагааг явуулахын тулд Зөвшөөрөл авагчид шаардагдах бүх техникийн болон зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

5.3. Зөвшөөрөл олгогч нь Зөвшөөрөл авагчид тоног төхөөрөмж олж авахад нь зориулан комиссын үйлчилгээ үзүүлэхээс гадна төлөвлөсөн тоо хэмжээ, зохих чанар бүхий үйлдвэрлэлийн материалыг цаг тухайд нь ______________________ үнээр бэлтгэн нийлүүлнэ.

5.4. Зөвшөөрөл олгогч үйлдвэрлэлийг нэгжийн ажилд зориулан технологийн баримт бичиг боловсруулахад нь шаардагдах тусламж үзүүлнэ.

5.5. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийг зохион байгуулахад тусгай тусламжийг байнга үзүүлж, гэрээний үндсэн зүйл болох бүтээгдэхүүний чанарт хяналт тавина.

5.6. Зөвшөөрөл олгогч нь үйлдвэрлэлийн төлөвлөсөн хэмжээг хангахын тулд үйлдвэрлэлийн нэгжийн боломжид нийцүүлэн тэдэнд ажлын тодорхой даалгавар өгнө.

5.7. Зөвшөөрөл олгогч нь Зөвшөөрөл авагчид гэрээний үндсэн дээр түүний тогтмол үйлдвэрлэлийг нийлүүлж, бүртгүүлэн бүтээгдэхүүний үнийг тогтмол төлнө.

## 6. Аж ахуйн үйл ажиллагааны хамтын байгууллага

6.1. Аж ахуйн үйл ажиллагаа амжилттай явуулахын тулд Талууд ______________ нэр бүхий хамтын байгууллага, байгуулахаар тохиролцов. Энэ нь Талуудаас тэгш тооны хүмүүсээс бүрдэх бөгөөд харин дарга нь Зөвшөөрөл авагчийн талаас томилно.

6.2. Хамтын байгууллагын эрх мэдэл, ажлын болон шийдвэр гаргах журам нь гэрээний тусгай хавсралт, мөн гэрээний талуудын зөвшөөрснөөр хамтын байгууллага батлан гаргах ажлын заавраар тус тус зохицуулагдана.

6.3. Талууд маргаан гарсан бүх асуудлыг хамтын байгууллагын саналын үндсэн дээр урьдчилан нөхөрсөг хэлцлийн журмаар шийдвэрлэхийг хичээж ажиллахаар тохиролцов.

## 7. Гэрээний үйлчлэх хугацаа, гэрээг сунгах, гэрээг цуцлах түүнээс татгалзах

7.1. Энэ гэрээг ___ оны __ -р сарын __-ээс ___ оны ____-р сарын ______ хүртэл ____ жил үйлчилнэ.

7.2. Талуудын аль нэг нь энэ гэрээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө уул гэрээнээс цаашид татгалзахаа бичгээр илэрхийлээгүй бол гэрээний үйлчлэх хугацааг автоматаар ______ хугацаагаар сунгасанд тооцно.

7.3. Гэрээний нэмэлт сунгалтыг мөн гэрээний 7.2-т заасан нөхцөлөөр гүйцэтгэнэ.

7.4. Зөвхөн захиалгын захидлаар гэрээнээс татгалзаж болно.

7.5. Энэ гэрээний 7.1-7.4-т заасан үндэслэлээр гэрээг цуцлахын зэрэгцээгээр талууд дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно.

7.5.1. Хэрэв талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй байх буюу энэ гэрээний 8-д дурдсан нөхцөл байвал, бэрхшээл бий болсны улмаас гэрээг цуцлахыг хүссэн тал энэ тухайгаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

7.5.2. Энэ гэрээний 7.6-д дурдсан мэдэгдлийг хүлээн авсан тал уул мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн санаа бодлыг бичгээр мэдэгдэж, бий болсон бэрхшээлийг арилгах талаар санал тавина. Хэрэв ирүүлсэн санал, мэдэгдлээс үзэхэд учирсан бэрхшээлийг боломжийн хугацаанд арилгах аргагүй нь тодорхой байвал, аль нэг тал ийнхүү учирсан бэрхшээлийг гэтлэн давах байдлыг баталсан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гэрээг цуцлах эрхтэй.

7.6. Дээр дурдсан шалтгаанаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг цуцлах өдөр хүртэл талууд өөрсдийн гэрээний үүргээ биелүүлэх болно.

7.7. Хэрэв талуудын аль нэг нь буруугийн улмаас гэрээг цуцалсан бол нөгөө тал түүнээс шалтгаалж учирсан хохирол, түүний дотор олох ёстой байсан орлогыг буруутай талаас нэхэмжлэн авах эрхтэй.

## 8. Давагдашгүй хүчин зүйл

8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас / алданги, торгууль / чөлөөлөгдөх үндэслэл болно.

8.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 9. Маргааныг шийдвэрлэх

9.1. Энэ гэрээнээс болон түүнтэй холбогдон гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ.

9.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 10. Төгсгөлийн заалт

10.1. Энэ гэрээнд Зөвшөөрөл олгогч, Зөвшөөрөл авагч нарын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

10.2. Энэ гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгийн хэлбэрээр хийнэ.

10.3. Энэ гэрээний хавсралт болон протокол нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан нөхцөлд энэхүү гэрээн оруулах нэмэлт, өөрчлөлт болж чадна.

10.4. Энэ гэрээний үндсэн эхийг 2 хувь хийсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.

10.5. Талуудын хууль ёсны хаяг, банкны харилцах данс, гарын үсэг

## 11. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

11.1. Зөвшөөрөл олгогч талын :

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

11.2. Зөвшөөрөл авагч талын:

Оршин байгаа газар: ______________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

11.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ЗӨВШӨӨРӨЛ АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ___ дугаар сарын ___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас______________________________________________________________

/цаашид "А" тал гэнэ/, түүнийг төлөөлж____________________________________________

***/төлөөлсөн хүний албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр/***

Нөгөө талаас ____________________________________________________________________

/цаашид "Б" тал гэнэ/, түүнийг төлөөлж ____________________________________________________________________

***/төлөөлсөн хүний албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр/***

нар дор дурдсан гэрээг байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний талууд _____________________________________________ чиглэлээр

__________________________________________________________ хэлбэрээр хамтран ажиллана.

1.2. Хамтын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг талууд дараахь байдлаар хариуцан гаргана (Хөрөнгийн төрөл хэмжээ, бэлэн болгох хугацаа зэргийг тодорхой заана):

- "А" тал
- "Б" тал

1.3. Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараахь байдлаар хариуцан зохион байгуулна (хийх ажлын чиглэл, төрөл, хийгдэх хугацааг заана):

- "А" тал
- "Б" тал

1.4. Гэрээний хугацаа жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

## 2. Хамтын ажиллагааны удирдлага, хяналт

2.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбботой үйл ажиллагааг дараахь журмаар удирдан явуулна (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):

- "А" тал нь дангаар төлөөлөх
- "Б" тал нь дангаар төлөөлөх
- "А" болон "Б" талууд хамтран
- "А" болон "Б" талууд өөр этгээдийг томилох замаар

2.2. Хамтын ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлж буй тал хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг __ бүрийн хугацаанд тогтмол тайлагнах үүрэгтэй.

2.3. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгжилт, бусад талуудын гэрээний талаархи үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.

2.4. Гэрээний аль нэг тал бусад талын шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой өөрийн хийсэн ажлын талаар тайлан тавих үүрэгтэй.

## 3. Эд хөрөнгө

3.1. Хамтын үйл ажиллагаатай холбоотой санаа, зардал, олсон орлого, өр, авлага, бусад зүйлс нь талуудын дараахь өмчлөлд байна (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно):

- хамтран өмчлөх дундын өмчид
- хэсгээр өмчлөх дундын өмчид, дараахь хувь хэмжээгээр:

3.2. Үйл ажиллагааны орлогоос бий болсон орлогын өөрт ногдох хэсгийг талууд өөрийн үзэмжээр захиран зарцуулна.

3.3. Хамтын үйл ажиллагааг үргэлжлүүлэхтэй холбоотой гарах зардлыг талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.4. Хамтын ажиллагаанд зориулан хуримтлуулсан хөрөнгө мөнгийг зөвхөн хамтын ажиллагааны зорилгод нийцүүлэн зарцуулна.

## 4. Хариуцлага

4.1. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн хариуцлагыг талууд дараахь зарчмаар хариуцна:

(дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно)

- хувь тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна. хэсгээр
--------- өмчлөх хувь хэмжээний дагуу хариуцна.

4.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй үед нөгөө талдаа дараахь торгууль эсхүл алданги төлнө (дараахь
хувилбарын аль нэгийг сонгож болно):

- үүргийн үнийн дүнгийн_________ хувийн торгууль төлнө.
- үүргийн гүйцэтгэлийг хожимдуулсан хоног тутам ____ хувийн (0.5-аас ихгүй байх) алданги төлнө.

## 5. Давагдашгүй хүчин зүйл

5.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас/ алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

5.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 6. Маргааныг шийдвэрлэх

6.1. Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

6.2. Хэрэв маргаантай асуудлаар Талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 7. Бусад заалт

7.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.2. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд жил тутам, явцын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.

## 8. Гэрээ хүчин төгөлдөр байх

8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд (дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно)

- харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.
- аль нэг тал нь__ сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээнээс татгалзаж болно. Энэ тохиолдолд тодорхой шалтгаан заагаагүй байж болно.
- онцгой нөхцөл шалтгаан бий болсон үед гэрээний аль нэг тал сарын өмнө мэдэгдэж гэрээнээс татгалзаж болно.

8.3. Талууд тохиролцвол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

### 9. Талуудын хууль ёсны хаягийн мэдээлэл

<u>“А” тал:</u>

Хаяг:______________________________________________________________

Утас:______________________________________________

Факс:________

<u>“Б” тал:</u>

Хаяг:______________________________________________________________

Утас:______________________________________________

Факс:________

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| <u>А ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:</u> | <u>Б ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:</u> |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

***БУСАД ТӨРЛИЙН ГЭРЭЭ***

## БИЗНЕСИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

_____оны ____ дугаар сарын____ өдөр                                                                        Улаанбаатар хот

Нэг талаас

_____________________________________________________________

*(аж ахуйн нэр,хаяг)*

(цаашид “Мэдээлэгч” гэнэ), түүнийг ___________________ үндсэн дээр төлөөлөн

__________________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

Нөгөө талаас

__________________________________________________________

*( аж ахуйн нэгжийн нэр, хаяг)*

(цаашид “Хүлээн авагч” гэнэ), түүнийг ___________________________үндсэн дээр төлөөлөн_____________________________________________________

*(төлөөлсөн хүний албан тушаал, нэр)*

дараах гэрээг байгуулав. Үүнд:

### 1. Гэрээний агуулга.

“Мэдээлэгч” тал компанийн нууц буюу нууцлах шаардлагатай, тухайлбал:

_____________________________________________________________

________________________________________________________________

тухай мэдээллийг шилжүүлэн өгч, “Хүлээн авагч” тал тэдгээрийг

________________________________________________________________

________________________________ зорилгоор хүлээн авна.

Мэдээлэл шилжүүлэх нь талуудын хамтын ажиллагаа болон

________________________________________________________________

__________________________________-ны үндсэн нөхцөл болно.

### 2. Талуудын үүрэг.

Талууд энэ асуудлын чухлыг ойлгон баталж өөр өөртөө дараах үүргийг хүлээн авч байна. Үүнд:

2.1. Энэ гэрээг байгуулснаас хойш _____ жилийн туршид “Хүлээн авагч” тал “Мэдээлэгч” талаас хүлээн авсан түүний нууцад тооцогдох мэдээллийг бусад үйлдвэр, байгууллагад, хүмүүст зарлан тараахгүй бөгөөд энэ гэрээний 1 дэх зүйлд зааснаас өөр зорилгоор хувьдаа ашиг олохын тулд ашиглахгүй.

2.2. Хүлээн авагч тал Мэдээлэгчийн нууцыг өөрийн компанийн нууцын нэгэн адил задруулах, бусдад ашиглуулахаас зайлсхийн өндөр хариуцлагатай, сонор сэрэмжтэй хамгаална.

## 3. Онцгой нөхцөл

3.1. Харилцан шилжүүлэн өгсөн бөгөөд бичгээр үйлдсэн мэдээллийг гэрээнд хавсаргана.

( Мэдээлэл шилжүүлэх тухай протокол. Хавсралт дугаар 1)

3.2. Нууцад тооцогдох мэдээлэл нь хэрэв дор дурдсан зүйлийн аль нэгэнд хамаарагдаж байвал Хүлээн авагч тал түүний талаар ямар нэг үүрэг хариуцлага хүлээхгүй. Үүнд:

3.2.1. Хүлээн авагч тал хэдийнээ мэдэж байсан бол

3.2.2. Мэдээлэгч талын буруу, хайхрамжгүй буюу санаатай үйлдлийн үр дүнд түүнийг нийтээр мэдэх болсон бол,

3.2.3. Хөндлөнгийн этгээдээс гэрээг зөрчсөн бөгөөд ямар нэг саад, хязгаарлалтгүйгээр хүлээн авсан бол

3.2.4. Мэдээлэгч тал хөндлөнгийн этгээдэд мөн тийм саад хязгаарлалтгүйгээр шилжүүлсэн өгсөн бол,

3.2.5. Хүлээн авагч тал зохих хэмжээгээр боловсруулсан бөгөөд тэгэхдээ уг боловсруулсан хүмүүс нь тэрхүү нууц зүйлд хүрээгүй бол,

3.2.6. Мэдээлэгч тал задруулж мэдээлэхийг бичгээр зөвшөөрсөн бол,

3.2.7. Хүлээн авагч тал мэдээллийн нууцыг дайчлан задруулахгүйг чармайсан боловч төрийн байгууллагын шаардлагаар төрийн байгууллагад мэдээлсэн бол.

## 4. Талуудын хариуцлага.

4.1. Хүлээн авагч тал дор дурдсан хариуцлага хүлээнэ.

А. Мэдээллийн нууцыг хадгалах талаар өндөр хариуцлага, сонор сэрэмжтэй байж чадаагүйгээс нууц мэдээллийг санамсаргүйгээр задруулсан буюу ашигласан бөгөөд тийм болсныг илрүүлснээс хойш тийнхүү задруулж ашиглахыг зогсоох арга хэмжээ аваагүй бол,

Б. Уул мэдээлэл дээр ажилласан хөлсний ажилтан нараас өндөр хариуцлага, сонор сэрэмжтэй ажиллаж чадаагүйн улмаас түүний нууцыг зөвшөөрөлгүйгээр задруулсан буюу ашигласан бол.

4.2. Хүлээн авагч тал ______________________________________________

(хүний албан тушаал овог, нэр)

гэрээнд дурдсан ёсоор хүлээн авагчийн даалгавраар нууц мэдээллийг хүлээн авч, нууцыг хадгалах хариуцлагатай ажилтнаар томилов.Цаашид энэ

хариуцлагатай ажилтныг өөрчлөх бол тийнхүү өөрчлөн томилсны дагуу__________ хоногийн дотор шинээр томилогчдын нэр хаягийг мэдээлэгч талд бичгээр мэдэгдэнэ.

4.3. Мэдээлэгч талаас хүлээн авагч талд өгсөн аливаа хэлбэрийн бүх мэдээлэл нь мэдээлэгч талын өмч хэвээр үлдэх бөгөөд тэдгээрийн хуулбар болон баримт сэлтийг мэдээлэгч талд түүний бичгийн шаардлагын үндсэн дээр нэн даруй буцаан өгөх буюу мэдээлэгч талын үзэмжээр устгана.

## 5. Мэдээллийг задруулах

5.1. Талууд нөгөө талынхаа урьдчилсан зөвшөөрөлгүйгээр гэрээний гол сэдэв болсон нууцлалыг бусдад задруулахгүй.

5.2. Гэрээг хуулийн хүчээр буюу удирдлагын шийдвэрийн үндсэн дээр хүлээн авагч бусдад шилжүүлж болохгүй. Мэдээлэгч талын урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хүлээн авагч тал гэрээг бусдад шилжүүлэх аливаа оролдлого хүчингүй болно. Хэрэв хөндлөнгийн этгээд ямар нэг мэдээллийн нууц задарсан тухайн нэхэмжлэл гаргах буюу бусад хууль зүйн үйлдэл хийсэн бол хүлээн авагч энэ тухай нэн даруй мэдээлэгчид мэдэгдэж, уул нууцыг задруулахаас урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээг авна.

## 6. Тусгай байдал

Энэ гэрээ болон түүнтэй холбогдон гарах асуудлыг _____________ хуулийн удирдлага болгон шийдвэрлэж тайлбарлана.

6.1. Энэ гэрээ болон түүнтэй холбогдон гарсан маргаанд ялсан тал нэхэмжлэл гаргах, шүүн таслах ажиллагаанд гарсан зардал, өмгөөлөгчийн шагналыг боломжийн хэрээр төлж өгөх эрхтэй.

6.2. Хүлээн авагч талын буруугаас нууц задарсан тохиолдолд мэдээлэгч тал өөрийн үзэмжээр нууц задарснаас болж учирсан хохирлыг арилгах, эсвэл хүлээн авагчийн талаас мэдээлэл шилжүүлэн өгөх үед бичгээр тохиролцсон хэмжээгээр торгууль авах эрхтэй.

## 7. Маргаан шийдвэрлэх

7.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 8. Бусад нөхцөл.

8.1. Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь хийсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгалав.

8.2. Энэ гэрээнд гарын үсэг зурмагц түүнтэй холбогдуулан хийсэн бүхий л урьдчилсан хэлэлцээ, тохиролцоо, гэрээ, бичиг захидал, ямар нэгэн протокол дахь тохиролцоонд зөрүүтэй байдал үүсвэл энэхүү гэрээг баримтална.Энэ гэрээ____ оны ___-р сарын ____-ээс ____ оны ____ -р сарын ___ хүртэл ________ хугацаагаар үйлчилнэ.

8.3. Энэ гэрээтэй холбоотой асуудлаар Талуудын нууцлалыг хариуцсан ажилтнаар доорх хүмүүсийг томилов:

| Мэдээлэгч талын: | Хүлээн авагч талын : |
|---|---|
| Нэр: | Нэр: |
| Албан тушаал: | Албан тушаал: |
| Утасны дугаар: | Утасны дугаар: |
| Цахим шуудангийн хаяг: | Цахим шуудангийн хаяг: |

## 9. Талуудын гэрээ байгуулж байх үеийн хууль ёсны хаяг, мэдээлэл

9.1. Мэдээлэгч талын :

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

9.2. Хүлээн авагч талын:

Оршин байгаа газар: ________________________________________________.

Хаяг, индекс: ____________________________________________________.

Утас: _____________ телетайп: ________________

Факс: __________________

Банк дахь тооцооны дансны дугаар: __________________________________.

9.3. Энэ зүйлд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухайд Талууд энэ тухай нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.

## 10. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| <u>МЭДЭЭЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u> | <u>ХҮЛЭЭН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:</u> |
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

# КОМПАНИЙН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Нэг талаас

______________________________________________________________

/эрхийг шилжүүлж буй компанийн нэр/

ХХКомпанийн захирал _______________________ овогтой _______________________

/цаашид эрх “Шилжүүлэгч” гэх/

Нөгөө талаас ___________________________овогтой ___________________________

/цаашид эрх “Хүлээн авагч” гэх/ нар

____________________ ХХКомпанийн эрх үүргийг бүрмөсөн шилжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## 1. Гэрээний зорилго

1.1 Компанийн эрх үүрэг хариуцлага эд хөрөнгө шилжүүлэх, үйлчлэх хугацаа бусад харилцааг зохицуулахад оршино.

## 2. Компани шилжүүлэгчийн эрх, үүрэг

2.1 Захирлаар томилогдсон эрх хүлээн авагчид компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх үүргийг бүрэн шилжүүлэх үүрэгтэй.

2.2 Компанийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө, /___________ мянган төгрөг / болон үйл ажиллагааны санхүүгийн тайлан баланс, тэмдэгтийг хүлээлцэх үүрэгтэй.

## 3. Компанийг хүлээн авагчийн эрх, үүрэг

3.1 Компанийн эрх хүлээн авсан өдрөөс өмнөх захиран зарцуулах, удирдах, төлөөлөх зэрэг эрхийг эдэлнэ.

3.2 Компанийн зорилгын төлөө үнэнч шударгаар ажиллах үүрэг хүлээнэ.

3.3 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг бүрэн хариуцна.

## 4. Хүлээх хариуцлага

4.1 Компанийн үйл ажиллагаанаас үүсэх хариуцлагыг

4.1.1 Компанийг байгуулсан үеэс;

*4.1.2* Компанийн эрх шилжсэн үеэс (*аль нь болохыг гэрээний талууд шийдвэрлэнэ.)*

________________________________________________________________________________________________________________________________________________

### 5. Гэрээний хүчинтэй болох үйлчлэх хугацаа

5.1 Энэхүү гэрээнд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчинтэйд тооцно.

### 6. Давагдашгүй хүчин зүйл

6.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль / чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2 Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

### 7. Маргаан шийдвэрлэх

7.1 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

### 8. Талуудын хууль ёсны хаягийн мэдээлэл

<u>Шилжүүлэгч:</u>
Хаяг:____________________________________________________________
Утас:_______________________________________________
Факс:________

<u>Хүлээн авагч:</u>
Хаяг:____________________________________________________________
Утас:_______________________________________________
Факс:________

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

<u>Шилжүүлэгч:</u> <u>Хүлээн авагч::</u>

| | |
|---|---|
| *Нэр* | *Нэр* |
| *Албан тушаал* | *Албан тушаал* |

## ХАМТАРСАН КОМПАНИ БАЙГУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

Монгол улсын иргэн ____________________________________ /цаашид “А” тал гэх/,

Монгол улсын иргэн ____________________________________ /цаашид “Б” тал гэх/,

Монгол улсын иргэн ____________________________________ /цаашид “В” тал гэх/,

нар нь олон улсын эдийн засгийн харилцааны практик, зан заншлын хэм хэмжээг харгалзан, эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн Монгол улсын Иргэний хууль, Гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль, Компанийн тухай хууль, Татварын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон Монгол улсын нутаг дэвсгэр дээр хязгаарлагдмал хариуцлагатай Хамтарсан Компани байгуулахаар дор дурдсан гэрээг байгуулав.

### 1. Хамтарсан компанийн зорилго, үйл ажиллагаа

1.1 Хамтарсан компани нь доорх үйл ажиллагааг явуулах зорилготой. Үүнд:

А_______________________________________________

Б_______________________________________________

В_______________________________________________

### 2. Талуудын үүрэг

Оролцогч талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1 “А” талын хүлээх үүрэг:

- 2.1.1 Гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрч, Гадаадын хөрөнгө оруулалтын газраас гэрчилгээ олгосноос хойш компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг Компанийн тухай хуулийн дагуу бүрдүүлнэ.
- 2.1.2 Оролцогч талуудын байгуулсан Гэрээ, түүний хавсралт болох дүрмийн үндсэн дээр Монгол улсын төрийн холбогдох байгууллагад хамтарсан компанийг бүртгүүлэх, данс нээлгэх, тамга тэмдэг хийлгэх, болон бусад бэлтгэл ажлыг хангах.
- 2.1.3 Хамтарсан компанид ажиллах боловсон хүчнийг бэлтгэх сургахад дэмжлэг үзүүлэх
- 2.1.4 Гэрээний дагуу Зөвлөлийн гишүүн болон хамтарсан компанийн удирдлагад оруулах этгээдийн талаар санал оруулах.

2.1.5 Хамтарсан компанийг шаардлагатай түүхий эд, материал, машин тоног төхөөрөмж, бусад зүйл худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх.
2.1.6 Хамтарсан компанийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн орох, гарах виз авах, оршин суух, ажиллах зөвшөөрөл, тэдгээрийг орон байр унаагаар хангахад туслах.
2.1.7 Хамтарсан компани болон “Б” талыг Монголын шаардлагатай хууль тогтоомжууд болон бусад мэдээллээр хангах.
2.1.8 Хамтарсан компанийн хувь хөрөнгө оруулж байгаа барилга байгууламжийг тохиролцсон цаг хугацаанд бэлэн байлгах, түүнийг хэрэглэх эзэмших эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байх.
2.1.9 Бусад үүргүүд болно.

2.2 “Б” талын хүлээх үүрэг:
2.2.1 Гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрч, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас (ГХОГХА) гэрчилгээ олгосноос хойш компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх үед дүрмийн санг Компанийн тухай хуулийн дагуу бүрдүүлнэ.
2.2.2 Хамтарсан компанид ажиллах боловсон хүчнийг бэлтгэх сургахад дэмжлэг үзүүлэх.
2.2.3 Гэрээний дагуу Зөвлөлийн гишүүн болон хамтарсан компанийн удирдлагад оруулах этгээдийн талаар санал оруулах.
2.2.4 Хамтарсан компанийг шаардлагатай түүхий эд, материал, машин тоног төхөөрөмж, бусад зүйл худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх.
2.2.5 Хамтарсан компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гуравдагч орны зах зээлд борлуулах арга хэмжээ авах.
2.2.6 Хамтарсан компанийн үйл ажиллагаанд оролцох монголын иргэдийг өөрийн улсад орох, гарах виз авах, оршин суух, ажиллах зөвшөөрөл, тэдгээрийг орон байр унаагаар хангахад туслах.
2.2.7 Хуульд заасан бусад үүргүүд болно.

## 3. Талуудын эрх

3.1 Талууд нь дор дурдсан эрхийг эдэлнэ.
3.1.1 Хамтарсан компанийн удирдлагыг бүрдүүлэхэд оролцох
3.1.2 Хамтарсан компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг зөвлөлд оруулах
3.1.3 Хамтарсан компанийн өөрт ноогдох ашгийг авах
3.1.4 Өөрт ноогдох ашгаараа хамтарсан компанийн дүрмийн санд хөрөнгө дахин оруулах.
3.1.5 Бусад эрхүүд болно.

## 4. Хамтарсан компанийн нэр, байршил, эрх хэмжээ

4.1 Хамтарсан компани нь

Монголоор _____________ ХХК

Англиар ________________Co.,Ltd

гэж тус тус нэрлэгдэх бөгөөд ________________хотноо байрлана.

4.2 Хамтарсан компанийн:

Албан ёсны хаяг____________________

Утас____________________

Факс________________________

4.3 Хамтарсан компани нь Улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол улсын хуулийн дагуу этгээдийн эрхтэй болох бөгөөд уг өдрөөс эхлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ. Хамтарсан компанийн хуулийн этгээд болсон өдрийг уг компани байгуулагдсан өдөр гэж үзнэ.

4.4 Хамтарсан компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх, хөндлөнгийн шүүхэд нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

4.5 Хамтарсан компани нь энэхүү гэрээнд оролцогч талуудын хүлээсэн үүрэг хариуцлагыг хүлээхгүй ба оролцогч талууд нь хамтарсан компанийн хүлээсэн үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.

4.6 Хамтарсан компани нь хүлээсэн үүргийнхээ хувьд эд хөрөнгийн хариуцлагыг зөвхөн эзэмшиж байгаа эд хөрөнгийнхөө хэмжээнд хүлээнэ.

4.7 Хамтарсан компани нь өөрийн салбар, төлөөгчийн газрыг Талуудын оронд болон бусад улсад байгуулах эрхтэй. Салбар нь хуулийн этгээдийн эрхтэй байх асуудлыг хамтарсан компанийн Зөвлөлөөс баталсан салбарын дүрмээр тодорхойлно.

## 5. Дүрмийн сан

5.1 компанийн дүрмийн сан нь оролцогч талуудын оруулсан хувь хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ нь ________ төгрөг буюу _________ ам.доллар байна. 1ам.доллар=_________ төгрөг.

5.1.1 Хамтарсан компанийн дүрмийн санд “А” талын оруулах хувь нь нийт хөрөнгийн _________ % буюу _______сая төгрөг / ___________ ам.доллар/ байна.

5.1.2 Хамтарсан компанийн дүрмийн санд “Б” талын оруулах хувь нь нийт хөрөнгийн __________ % буюу _______сая төгрөг / __________ ам.доллар/ байна.

5.2 Оролцогч талууд нь хамтарсан компанийн дүрмийн санд оруулах өөрийн хувь хөрөнгийг энэхүү гэрээний дагуу оруулна. Үүнд:

а/ “А” тал:

- Байшин барилга
- Тоног төхөөрөмж
- Бэлэн мөнгө
- Бусад

б/ “Б” тал:

- Тоног төхөөрөмж
- Бэлэн мөнгө
- Бусад

5.3 Хамтарсан компанийн дүрмийн санд Талуудын оруулж буй тоног төхөөрөмж, материал болон бусад барааны тоо ширхэг, нэр төрөл, нэг бүрийн үнийг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт [1]1 –д заав.

5.4 Дүрмийн сангийн хэмжээг хамтарсан компанийн удирдах дээд байгууллагын шийдвэрээр өөрчилж болох бөгөөд энэ тухайгаа 14 хоногийн дотор ГХОГХА болон Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж зохих шийдвэрийг гаргуулсны үндсэн дээр Гэрчилгээнд өөрчлөлт оруулна.

5.5 Хамтарсан компани байгуулагдах үед талуудаас дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээг нотолсон гэрчилгээг уг компанийн удирдах дээд байгууллага талуудад олгоно.

## 6. Удирдлага

6.1 Хамтарсан компанийн удирдах дээд байгууллагыг ГХОГХА-аас гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн Гэрчилгээ авсны дараа байгуулна.

6.2 Хамтарсан компанийн удирдах дээд байгууллага нь оролцогч талуудын томилсон...... хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөл байна. Зөвлөлийн гишүүд нь Зөвлөлийн хурлыг зарлах, зохион байгуулах, удирдан явуулах эрх бүхий Зөвлөлийн даргыг хоёр орны иргэдээс ээлжлэн ...... жилийн хугацаатай сонгоно.

6.3 Зөвлөлийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хийх ба Зөвлөлийн гишүүд, захиргаа, Ерөнхий захирлын санаачилгаар ээлжит бус хурлыг хэзээ ч зарлан хуралдуулж болно. Зөвлөлийн хурлаар санал нэгтэй буюу ердийн олонхын саналаар шийдвэрлэх асуудлын хүрээг хамтарсан компанийн дүрмээр тодорхойлно.

6.4 Хамтарсан компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Ерөнхий захирлаар толгойлуулсан захиргаа гүйцэтгэнэ.

6.5 Ерөнхий захирал нь хамтарсан компанийн үйл ажиллагааг энэхүү Гэрээ, хамтарсан компанийн дүрэм, Зөвлөлийн хурлын шийдвэрээр олгосон эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

6.6 Хамтарсан компани нь Зөвлөлөөс томилсон ерөнхий ня-бо-той байна. Ерөнхий ня-бо нь Зөвлөл болон Ерөнхий захирлын өмнө ажлаа тайлагнана.

## 7. Ажиллах хүч

7.1 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь Монгол улсын иргэдийг тэргүүн ээлжинд авч ажиллуулна. Компанийн удирдлагад байх болон компанид нарийн мэргэжлээр ажиллах гадаадын ажиллагсдын тоо, тэдгээрийн Монголд байх хугацаа, үндэслэлийг Хөдөлмөр зохицуулалтын газартай тохиролцож шийдвэрлэнэ.

7.2 Хамтарсан компани нь ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ болон хамтын гэрээ байгуулах, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх, цалин, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж олгох, хөдөлмөр хамгаалал болон хөдөлмөрийн бусад харилцааг Монгол улсын Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

7.3 Ажиллагсдын нийгмийн даатгал болон бүх төрлийн төлбөр, хураамжийн асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.4 Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн төслийг хамтарсан компанийн Зөвлөл батална.

7.5 Хамтарсан компани ажлынхаа дотоод журмыг Монгол улсын хууль, тогтоомжийг иш үндэс болгон боловсруулж хамтарсан компанийн Зөвлөлд оруулж батална.

## 8. Хамтарсан компанийн эдийн засгийн үйл ажиллагаа, татвар санхүүжилт ба хяналт

8.1 Хамтарсан компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс эхлэн /эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс / 12 дугаар сарын 31-нд /сүүлийн жилийн хувьд бол энэхүү гэрээ хүчингүй болох буюу гэрээний заалт ёсоор татан буулгасан өдөр/ дуусна.

8.2 Хамтарсан компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар, гаалийн хураамж, газар эдэлбэр, түрээсийн төлбөрийг төлнө. Орлогын татварыг орлого олсон тухайн валютаар төлнө.

8.3 Хамтарсан компанийн санхүүгийн болон статистикийн бүртгэлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтөлнө.

8.4 Хамтарсан компани нь Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу орлогоосоо улсын төсөвт татвар төлсний дараа нөөцийн болон бусад сангуудыг өөрийн эдийн засгийн байдлыг харгалзан Зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр байгуулна.

8.5 Хамтарсан компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу элэгдэл шимтгэлийг байгуулна.

8.6 Хамтарсан компанийн санхүүгийн тайлан, тэнцлийг холбогдох татвар, хяналтын байгууллага Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шалгах эрхтэй бөгөөд холбогдох баримт материалыг шаардан гаргуулах эрхтэй.

8.7 Хамтарсан компани нь улирал болон жил бүрийн санхүү аж ахуйн үйл ажиллагааныхаа талаархи тайланг орлого зарлагын тайлан тэнцэтгэлийн хамт талуудын холбогдох татварын хяналтын байгууллагад үйл ажиллагааныхаа товч тайланг зохих маягтын дагуу Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газарт өгч байх үүрэгтэй.

Оролцогч аль нэг тал хүсэлт гаргавал хамтарсан компани санхүүгийн мэдээллийг гаргаж өгч болно.

8.8 Хамтарсан компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй, талуудын тэнцүү тооны төлөөлөгчөөс бүрдсэн Хянан шалгагчдын зөвлөлийг...... хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөлөөс байгуулна. Хянан шалгагчдын зөвлөл нь хамтарсан компанийн санхүү, аж ахуйн үйл

ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа шалгаж дүнг зөвлөлийн хуралд оруулж байна.

8.9 Хянан шалгагчдын зөвлөлийн гишүүн нь хамтарсан компанийн зөвлөл буюу захиргаанд ямар нэгэн албан үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

8.10 Хамтарсан компани нь Монгол улсын аль нэг банканд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй. Хамтарсан компани нь гадаадын банканд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банканд болон Улсын татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

8.11 Хамтарсан компанид оролцогч талууд компанийн дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашгаа орлого олсон тухайн валютаар жилд ...... удаа хуваарилуулан авна. Хэрэв хамтарсан компани нь алдагдалтай ажилласан бол түүнийг нөхөж дуустал ашгийн хуваарилалт хийхгүй.

8.12 “Б” тал өөрт ноогдох ашгаа Монгол улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу чөлөөтэй захиран зарцуулах, гадаадад гуйвуулах эрхтэй. “Б” тал өөрт ноогдох төгрөгийн ашгаа:

- нэгдүгээрт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр авах,
- хоёрдугаарт, Монгол улсын Засгийн газраас гадаад чөлөөтэй гаргахыг зөвшөөрсөн бараа бүтээгдэхүүнийг монголын зах зээлээс худалдан авах,
- гуравдугаарт, зах зээлийн үнэ ханшаар худалдан авсан чөлөөтэй хөрвөх валютаар гадаадад гуйвуулах эрхтэй бөгөөд энэ тухайд “А” тал дэмжлэг үзүүлнэ.

8.13 Хамтарсан компанийн аж ахуйн үйл ажиллагааг явуулахдаа холбогдсон материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад бүтээгдэхүүнийг тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авч байна.

## 9. Даатгал

9.1 Хамтарсан компанийн бүх төрлийн даатгалыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Монгол улсын даатгалын байгууллагад даатгуулна.

## 10. Татан буулгах

10.1 Хамтарсан компанийг дараах тохиолдолд Зөвлөлийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:

- Үйл ажиллагааны анх тохирсон хугацаа буюу сунгасан хугацаа нь дууссан үед,

- Дор дурдсан аль нэг нөхцөл байдал бий болж байнга үргэлжлэх болсон гэдгийг үндэслэн нэг талын санаачилгаар талууд Зөвлөлийн гишүүдээрээ дамжуулан хамтарсан компанийг татан буулгах тухай шийдвэрийг санал нэгтэй баталсан үед, Үүнд:

а/ хамтарсан компани алдагдалтай ажиллаж байгаагийн улмаас цаашид үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон бол,

б/ аль нэг тал нь энэхүү гэрээнд заасан журмын дагуу хамтарсан компанийн дүрмийн санд өөрийн хувь хөрөнгөө нийлүүлж чадахгүй байдалд ...... сар буюу түүнээс дээш хугацаагаар орсон байвал,

в/ аль нэг тал нь энэхүү гэрээ болон дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрсний улмаас хамтарсан компани үйл ажиллагаагаа цаашид явуулах боломжгүй болж энэ нь гэрээний зорилгод харшилж байгаа бол,

г/ аль нэг тал бодит байдал дээр Зөвлөлд болон хамтарсан компанийн үйл ажиллагааг удирдах ажилд оролцож чадахгүйд хүрсэн байвал,

д/ монголын талын оролцогч нь нөгөө оролцогч талынхаа хамтарсан компанид оруулах хувь хөрөнгийг бүхэлд нь худалдан авсан бол

е/ харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтарсан компанийг татан буулгахад хүрвэл

ж/ тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл үйлчилгээг дагнан эрхэлдэг компанид олгосон тусгай зөвшөөрөл хүчингүй болсон.

10.2 Монгол улсын шүүх нь компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана. Үүнд:

1/ компани дампуурсан

2/ компанид нэг ч гишүүн үлдээгүй

3/ хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн

4/ хуульд заасан бусад үндэслэл

10.3 Хамтарсан компанийг татан буулгах тохиолдолд өр төлбөрийг төлсний дараа хөрөнгийг нь хувь оруулсан хэмжээгээр хувааж авах эсвэл аль нэг тал компанийн бүх хөрөнгө, түүний хэсгийг худалдан авах, хөрөнгийг бусдад борлуулах арга хэмжээ авна.
Хөрөнгийг оролцогч талуудын хүлээн авахуйц валютаар төлбөр, тооцоо хийхээр тохирч худалдана.

10.4 Хамтарсан компанийг татан буулгах тохиолдолд Татан буулгах комиссыг Зөвлөлөөс томилно.

10.5 Татан буулгах комиссын эрх үүрэг, ажиллах журмыг хамтарсан компанийн дүрмээр тодорхойлно.

## 11. Хариуцлага

11.1 Энэхүү гэрээнд оролцогч аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүссэн хохирлыг нөгөө талдаа төлөх үүрэгтэй.Гэхдээ шууд бус хохирол буюу олох байсан ашгийг нөхөн төлөхгүй.

11.2 Аль нэг тал нь хүндэтгэх шалтгаангүйгээр хамтарсан компанийн оролцогч байхаас татгалзвал оролцогч нөгөө талдаа хамтарсан компанийн дүрмийн сангийн ......%-тай тэнцэх хэмжээний торгууль төлнө.

11.3 Дүрмийн санд оруулах хувь хөрөнгийг хугацаа хоцроосон хоног тутамд оруулаагүй хөрөнгийн үнийн дүнгийн ....%-тай тэнцэх алдагдлыг нөгөө оролцогч талдаа төлнө.

## 12. Давагдашгүй хүчин зүйл

12.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль / чөлөөлөгдөх үндэслэл болно.

12.2 Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## 13. Маргаан шийдвэрлэх

13.1 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

13.2 Хэрэв талууд хамтран шийдвэрлэж чадахгүй тохиолдолд гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## 14. Эрх үүрэг шилжүүлэх, худалдаалах

14.1. Оролцогч тал өөрийн хувь хөрөнгөө бүхэлд нь буюу хэсгийг нь гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх саналтай бол оролцогч талдаа энэ тухай бичгээр мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдэлд шилжүүлэх хаяг, эдийн агуулга, үнэ, шилжүүлэх хугацаа зэргийг тодорхойлсон байна. Оролцогч нөгөө тал нь гуравдагч этгээдээс илүү таатай буюу адил тэгш нөхцөлөөр худалдан авах давуу эрхийг эдэлнэ. Оролцогч нөгөө тал мэдүүлэг авснаас хойш ... сарын дотор өөрөө худалдан авах эсэхээ мэдэгдэнэ. Энэ хугацаанд хариу эс мэдэгдвэл мэдүүлэгт заасан нөхцөлөөр шилжүүлэн худалдахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

14.2. Оролцогч тал өөрийн хувийг эзэмших эрхээ бүхэлд нь хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлж болно. Ийнхүү шилжүүлэхэд нөгөө талд болон Зөвлөлд илтгэж урьдчилан тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэнэ. Хувь шилжүүлэн эзэмших эрх авагч нь эрхээ шилжүүлэгч талын шилжүүлсэн буюу худалдсан хувь хөрөнгөтэй холбогдуулан энэхүү гэрээгээр хүлээх бүх хариуцлагыг мөн адил шилжүүлэн авна.

14.3. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд аль нэг тал хамтарсан компанид эзлэх өөрийн хувийг бүхэлд нь буюу хэсгийг нь нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр худалдах, шилжүүлэх, барьцаанд өгөх болон өөр бусад аргаар түүнээс хагацаж болохгүй.

14.4. Энэхүү зүйлд заасны дагуу хамтарсан компанийн дүрмийн санд эзлэх хувь хөрөнгөө бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлэхэд шилжүүлэгч тал хамтарсан компанийн Зөвлөлөөс олгосон тухайн хувь хөрөнгийг компанийн дүрмийн санд оруулсныг нотлох гэрчилгээг хамтарсан компанид эргүүлэн өгч цуцлуулна. Хамтарсан компани нь энэхүү гэрчилгээг шинэчлэн өв

залгамжлагчид олгоно. Энэ нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.

### 15. Хамтарсан компанийн ажиллах хугацаа

15.1. Хамтарсан компани түүнийг байгуулсан өдрөөс хойш ... жил үйл ажиллагаагаа явуулна. Энэхүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа нь түүнийг баталсан өдрөөс эхэлж гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу хамтарсан компанийг татан буулгаснаар дуусна.

15.2. Хэрэв аль нэг тал гэрээний хугацааг сунгахыг хүсвэл энэ тухай нөгөө талдаа энэхүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө мэдэгдэнэ.

15.3. Гэрээний хугацааг сунгах талаар хамтарсан компанийн зөвлөл шийдвэр гаргасан тохиолдолд Талууд Гадаадын хөрөнгө оруулалтын газар болон татварын албанд мэдэгдэнэ.

### 16. Хэл

16.1. Энэхүү гэрээг _________ хэлээр тус бүр__________ хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад маргаан гарвал ________хэл дээрх эхийг баримтална.

16.2. Хамтарсан компанийн ажлын хэл нь _________ хэл байх бөгөөд албан ёсны хэл нь монгол хэл байна.

### 17. Хэрэглэгдэх хууль

17.1. Гэрээг байгуулах, хүчин төгөлдөр болох, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, зогсооход Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэглэнэ.

17.2. Хамтарсан компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах үүрэг хүлээнэ.

### 18. Бусад асуудал

18.1. Энэхүү гэрээний оролцогч талууд нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

18.2. Энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд урьд өмнө нь явагдаж байсан хэлэлцээ, албан бичиг, санамж, бусад мэдээлэл хүчингүйд тооцогдоно.

### 19. Талуудын хууль ёсны хаягийн мэдээлэл

<u>“А” тал:</u>

Хаяг:____________________________________________________________

Утас:______________________________________________

Факс:________

<u>“Б” тал:</u>

Хаяг:______________________________________________________________
Утас:______________________________________________
Факс:________

<u>“В” тал:</u>
Хаяг:______________________________________________________________
Утас:______________________________________________
Факс:________

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| “А” тал: | “Б” тал: |
| _________________________ | _____________________ |
| /гарын үсэг/ | /гарын үсэг/ |
| тэмдэг | тэмдэг |

“В” тал:

_________________________

/гарын үсэг/

тэмдэг

**ЭВЛЭРЛИЙН ГЭРЭЭ**

Дугаар____

____оны ___ дугаар сарын___ өдөр Улаанбаатар хот

А тал: Хохирсон этгээдийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн овог, нэр, хаяг, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, утасны дугаар

______________________________________________________________________

______________________________________________________________________

Б тал: Хохирол учруулагчийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн овог, нэр, хаяг, иргэний үнэмлэх, регистрийн дугаар, утасны дугаар,

______________________________________________________________________

______________________________________________________________________

1. Учруулсан гэм хорын нэр, төрөл, хэр хэмжээ, /амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, оюуны өмч, хөдөлмөрийн харилцаа, барилга байгууламж, амьтны учруулсан гэм хорын аль нь болохыг тодорхой заана/

______________________________________________________________________

______________________________________________________________________

2. Учруулсан хохирлыг хэрхэн арилгах талаар тохиролцоо, төлбөрийн дүн, төлөх журам, барагдуулах хугацааг тодорхой заана

______________________________________________________________________

______________________________________________________________________

3. Б тал гэрээний 2-т заасан үүргээ биелүүлээгүйгээс хоногийн алданги эсвэл торгууль тооцох талаарх тохиролцоо

______________________________________________________________________

______________________________________________________________________

4. Энэ гэрээ талуудын хүсэл зоригоор, харилцан тэгш эрх, сайн дурын үндсэн дээр хийгдсэн бөгөөд хөндлөнгийн хүчин зүйл, шахалт дарамт нөлөөлөөгүй болно.
5. Энэ гэрээ нь гэрээний 2-т заасан үүргээ Б тал бүрэн биелүүлснээр, төлбөр хохирлыг арилсанд тооцож, талууд эвлэрснийг гэрчилнэ.
6. Гэрээний үүрэг бүрэн биелж, хохирол арилсан үед үндсэн гэрээний адил хэлбэрээр нотариатаар гэрчлүүлснээр дуусгавар болж, талууд эвлэрснийг гэрчилнэ.
7. Талууд эвлэрлийн гэрээг байгуулснаар эвлэрлийг баталгаажуулж энэ гэрээнд заасан асуудлаар дахин арбитрт болон шүүхэд маргаан гаргах

эрхгүй бөгөөд нэхэмжлэгч тал үл маргах журмаар нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэр биелүүлэх газраар албадан гүйцэтгүүлэх эрхтэй

8. Энэхүү гэрээгээр талуудын болон гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй болно.
9. Талуудын бичиг баримт эх хувиараа, нууцлал бүрэн.
10. Талууд эрх зүйн бүрэн чадамжтай.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| А ТАЛ: | Б ТАЛ: |
|---|---|
| ______________________________ | ______________________________ |
| *(гарын үсэг, тамга, тэмдэг)* | *(гарын үсэг, тамга, тэмдэг)* |
| *Овог, Нэр* | *Овог, Нэр* |
| *Регистрийн дугаар* | *Регистрийн дугаар* |

***1.*** Хөндлөнгийн гэрчийн овог, нэр, утасны дугаар, Гарын үсэг,

***2.*** Хөндлөнгийн гэрчийн овог, нэр, утасны дугаар , Гарын үсэг